

# Монгол улсын Баталгаажуулалтын тайлан (2022):

ОУИТБС-ын стандартуудыг  
хэрэгжүүлэх чиглэлд гарч буй ахиц  
дэвшилд хийсэн үнэлгээний эцсийн  
тайлан

## Агуулга

Товчилсон үгс.....	3
Гүйцэтгэлийн хураангуй.....	4
Баталгаажуулалтын онооны карт.....	8
ОУИТБС-ны Баталгаажуулалтын оноог хэрхэн өгдөг вэ? .....	10
1. Үр дүнтэй байдал, тогтвортой байдлын үзүүлэлтүүд .....	11
2. Үр дүн, үр нөлөө.....	19
3. Талуудын оролцоо .....	30
4. Ил тод байдал .....	43
Олборлох үйлдвэрлэлийн салбарын тойм (Шаардлага 3.1, 6.3) .....	43
Эрх зүйн орчин болон санхүүгийн горим (Шаардлага 2.1, 2.4, 6.4) .....	45
Тусгай зөвшөөрөл, хөрөнгийн эрх (Шаардлага 2.2, 2.3) .....	50
Эцсийн өмчлөгч (Шаардлага 2.5).....	54
Төрийн оролцоо (Шаардлага 2.6, 4.2, 4.5, 6.2) .....	58
Үйлдвэрлэл болон экспорт (Шаардлага 3.2, 3.3) .....	65
Орлого төвлөрүүлэлт (Шаардлага 4.1, 4.3, 4.4, 4.7, 4.8, 4.9) .....	67
Орлогын менежмент (Шаардлага 5.1, 5.3).....	74
Орон нутагт оруулж буй хувь нэмэр (Шаардлага 4.6, 5.2, 6.1).....	77
Үндэслэл.....	84
Эх сурвалжууд.....	86

## Товчилсон үгс

ЭӨ	Эцсийн өмчлөгч
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
ОУИТБС	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
ЭТТ	Эрдэнэс Таван Толгой
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ЗГСС	Засгийн газрын санхүүгийн статистик
ХБА	Хараат бус аудитор
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпорац
ХК	Хувьцаат компани
ОНХЕС	Орон Нутгийн Хөгжлийн Ерөнхий Сан
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МОУИТБС	Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
МУУҮА	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
₮	Монгол төгрөг
СЯ	Сангийн Яам
АМГТГ	Ашигт Малтмал, Газрын Тосны Газар
АХ/ ОТОБ	Олон талын оролцоот Ажлын хэсэг (Олон талын оролцоот бүлэг)
НА	Хамаарахгүй
ТББ	Төрийн бус байгууллага
ББЗХ	Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ТСУ	Төрийн санхүүгийн удирдлага
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ТАН	Төлсөн Авснаа Нийтэл эвсэл
ТӨК	Төрийн өмчит компани
ГАД	Гүйцэтгэх ажлын даалгавар
НӨАТ	Нэмүү өртгийн албан татвар
Ам.доллар	Америк доллар

## Гүйцэтгэлийн хураангуй

Энэхүү тайланд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улсад хийсэн баталгаажуулалтын ажлын үр дүнг тусган харууллаа. Баталгаажуулалтын тайлангийн төслийг ОУИТБС-ын Ажлын хэсэг буюу Олон талын оролцоот бүлэгт зориулан 2022 оны 5-р сарын 10-ны өдөр эцэслэн гаргасан. 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Ажлын хэсгээс тайлангийн төсөлд санал, тайлбар өгөх хугацааг сунгах хүсэлт гаргасныг ёсоор болгон, хугацааг 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл сунган талуудаас санал, тайлбарыг хүлээн авсан. Оролцогч гурван талын зүгээс өгөх санал, тайлбаруудыг 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хүлээн авч, улмаар Баталгаажуулалтын тайланг ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хүргүүлэхээр эцэслэн бэлтгэсэн болно. Үнэлгээний дүгнэлтээр Монгол улс нь ОУИТБС-ын 3 шаардлагыг давуулан биелүүлж, 7 шаардлагыг бүрэн хангаж, 17 шаардлагын ихэнх хэсгийг хангаж, 3 шаардлагыг хэсэгчлэн хангасан байна. Энэхүү үнэлгээгээр Монгол улсын ОУИТБС-ын 2019 оны Стандартын хэрэгжилтийг дунд хэмжээнд (moderate) биелүүлсэн хэмээн дүгнэж, харгалзах оноог өгсөн.

### Гол үр дүнгүүд

- Монголын ОУИТБС-ын нээлттэй мэдээллийн портал нь олборлох үйлдвэрлэлийн салбарын мэдээллийг системтэйгээр ил тод болгох тогтвортой платформыг бий болгожээ. Тухайн платформ нь компаниудаас өгөгдөл мэдээлэл цуглуулах, Засгийн газрын мэдээллийг ил тод нийтлэх зориулалт бүхий Цахим тайлангийн систем дээр суурилсан байна. Цаашид Монголын ОУИТБС-ын хэрэгжилт болон Засгийн газраас илүү өргөн хүрээнд хэрэгжүүлж буй цахим засаглалын үйл ажиллагааг үүнтэй үялдуулах, энэ хүрээнд Засгийн газрын цахим засаглалын [порталтай](#) автоматаар мэдээлэл солилцож байхаар төлөвлөжээ. Энэхүү мэдээллийг нийт санхүүгийн 15 жилийг хамрахуйц хугацааны цуваа байдлаар нэгтгэн, нээлттэй мэдээллийн форматаар тусгасан нь дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулахад ашиглах бодит үндэс суурийг бий болгожээ.
- Монгол улс нь ОУИТБС-ын хэрэгжилтийг, ялангуяа ОТОБ-ийн иргэний нийгмийн оролцогч талуудын тэргүүлэх үйл ажиллагааны хүрээнд, улам дэлгэрүүлэн гэрээний ил тод байдал, эцсийн өмчлөгчийн ил тод байдал, төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгох чиглэлээр шинэчлэл хийхэд ашиглаж байна. Дээр дурдсан оролцогч талын зүгээс төрөл бүрийн [гэрээ, эцсийн өмчлөгчийн талаарх ОУИТБС-ын мэдээлэл](#) болон малчдад зориулсан [уул уурхайн мэдээлэл](#) зэргийг багтаасан вэбсайтыг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэн хэрэгжүүлж иржээ.
- Монголын ОУИТБС-ын хэрэгжилтэд иргэний нийгэм нь онцгой идэвхтэй оролцогч тал бөгөөд ОУИТБС-ын үйл явц дахь талуудын байнгын оролцоог хангагч байж иржээ. Тиймээс иргэний нийгэм нь ОУИТБС-ын дизайн төлөвлөлт, хэрэгжилтийн үйл явцад чухал үүрэг гүйцэтгэж, хэрэгжилтэд зориулан санхүүжилт олгож, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг тэргүүлэн ажиллаж, ОУИТБС-ын өгөгдлийг ашиглан салбарын талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж иржээ. Энэхүү оролцогч тал нь олон талт, олон байгууллагаас бүрдэж, уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн иргэдийн

төлөөллийг багтааж, уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй бол аймаг, сумдад хүрч ажиллаж байна.

### Цаашдын хөгжлийн чиглэл

- Монгол улс нь ОУИТБС-ын тайланг гаргахад баримталж буй “үян хатан” хандлагаа эргэн харж, орлогын ил тод байдлын эрсдэлд суурилсан үнэлгээ, орлогын шударга байдал зэрэг илүү тогтвортой хандлагыг түршин хэрэгжүүлэх боломжтой. Нэгтгэлд хамрагдаж буй компаниудын тоог бууруулахаас илүүтэйгээр Монгол улсын хувьд цахим тайлагналын системийг эргэн харж, олборлох үйлдвэрлэлийн салбарын бүх компаниудаас цуглуулж буй өгөгдөл мэдээллийн цар хүрээг өргөтгөх боломжтой байна. ОУИТБС-ын цуглуулсан өгөгдөл мэдээллийг төслийн түвшинд задаргаатайгаар ил тод болгох нь тодорхой нэг төслөөс Засгийн газрын орлогод оруулж буй хувь нэмрийг үнэлэх сонирхол бүхий талуудад тухайн өгөгдлийн хэрэгцээт байдлыг улам сайжруулна.
- Засгийн газрын зүгээс ОУИТБС дахь төрийн өндөр албан тушаалтнуудын оролцоо, тэдний гүйцэтгэлийг эргэн сэргээх, сайжруулах, үүний хүрээнд хамаарах төрийн байгууллагуудын албан тушаалтнууд үйл явцад идэвхтэй оролцож байх явдлыг хөхиүлэн дэмжих шаардлага үүсжээ. Үүнийг хэрэгжүүлэх боломжит хувилбарт ОУИТБС-ын аргачлалыг ашиглан олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж буй шинэтгэлийг, жишээ нь 2020 онд хийхэд төлөвлөсөн Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг дэмжих зэрэг багтана. Засгийн газар нь ОУИТБС-ын хэрэгжилтэд зориулан хангалттай хэмжээний техникийн болон санхүүгийн нөөц эх үүсвэрийг хуваарилан, хийгдэж буй үйл явц нь бүхий л талын хүлээлтэд нийцэх бодит үр дүнг гаргаж буйг баталгаажуулах шаардлагатай. Монгол улс нь мөн олборлох үйлдвэрлэлийн салбарын өмчлөлийн ил тод байдлыг хангах зорилгоор эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг сайжруулах эрх зүйн зүйл заалтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг түргэвчлэх шаардлагатай байна. Бүх гэрээ, тусгай зөвшөөрлийг иж бүрнээр нь нээлттэй болгох замаар гэрээний ил тод байдлын чиглэлээр хийж буй хүчин чармайлтыг улам сайжруулах шаардлагатай.
- ОУИТБС-ын Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь бүх гурван талыг тэгш эрх бүхий түншлэгч хэмээн хандсан тэнцвэртэй, бодит хэлэлцүүлгийг хийж байх шаардлагатай. ОУИТБС-ын хамаарах талууд нь байгалийн баялгийн засаглалын асуудлаар, үүний хүрээнд баялгийн засаглал дахь иргэний нийгмийн оролцооны эрх зүйн орчны асуудлыг өргөн хүрээний иргэний орон зайг бий болгох, хэлэлцэх боломж, орон зайг бүрдүүлэх шаардлагатай байна. ОУИТБС нь байгалийн баялгийн засаглалын бүхий л чиглэлээр чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэх ил тод байдал, эгэх хариуцлагын орон зайг ханган өгөх шаардлагатай байна.
- ТӨК-иудын засаглал, санхүүгийн удирдлага, ажил гүйлгээ болон КОВИД-19 цар тахлын үеэр улам өсөн нэмэгдэж буй төсвийн шинжтэй зарцуулалт зэрэгт жил тутамд дүн шинжилгээ хийхэд ОУИТБС-ыг ашиглах боломжтой. Ингэснээр Засгийн газрын зүгээс баримталж буй нэгдсэн төсвийн бодлогод хамаараад зогсохгүй мөн олон улсын санхүүгийн байгууллага, хөгжлийн түншлэгч байгууллагуудад хандсан ил тод байдлыг зорилтуудын хэрэгжилтэд ч хамааралтай болох юм. Монголын ОУИТБС нь авлигын эсрэг хийж буй үйл ажиллагаагаар дамжуулан ОУИТБС-ын хэрэгжилтийг илүү нөлөөтэйгөөр

хэрэгжүүлэх, жишээ нь ОУИТБС-ын өгөгдлийг авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаанд зориулан мэдээллээр хангахад ашиглах боломжтой.

### Хэрэгжилтэд гарч буй ахиц

ОУИТБС-ын Баталгаажуулалтын үнэлгээг “Оролцогч талуудын оролцоо”, “Ил тод байдал” болон “Үр дүн, үр нөлөө” хэмээх гурван бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийдэг.

#### *Оролцогч талуудын оролцоо*

Өмнө хийгдсэн Баталгаажуулалтаас хойш ОУИТБС-ын үйл явц дахь талуудын оролцоо суларсан харагдаж байна. ОУИТБС-ын хэрэгжилтийг Ерөнхий сайдын Ажлын албаны чиг үүргээс салган, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсэн явдлыг ОУИТБС дахь төрийн оролцоог бууруулж, өндөр түвшний оролцоонд хийдэл гаргахын зэрэгцээ хэрэгжилтэд шаардлагатай нөөц эх үүсвэрийг хязгаарласан хэрэг хэмээн өргөн хүрээнд талууд үзэж байна. Гэвч КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөөлөл ОУИТБС дахь талуудын оролцоонд сөргөөр нөлөөлсөн ба 2020- 2021 онуудад долоон удаагийн хөл хорио тогтоосон байна. Үнэлгээний төсөл дээр үүнтэй холбоотой ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба 2020- 2021 онд КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хэд хэдэн удаагийн хөл хорио нь ОУИТБС-ын хэрэгжилт болон нийт эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллийг цохон дурдсан байна. Уул уурхайн тэргүүлэх компаниуд, салбарын холбоод нь ОУИТБС дахь оролцоогоо энэ үеэр хадгалж ирсэн ч салбарыг бүрэн төлөөлөхүйц оролцоо хангагдсаныг харуулах баримт нотолгоо байхгүй, ялангуяа дунд хэмжээний компаниуд, газрын тос, байгалийн хийн компаниудын оролцоо бага байна. Иргэний нийгмийн хувьд ОУИТБС-д идэвх, санаачилгатай оролцооор ирсэн ч тэдний үзэл бодлоо илэрхийлэх, төрийн шийдвэр гаргалтад оролцох эрхэд саад тотгор тулгарч буй ба зарим саад тотгорыг нь Засгийн газрын зүгээс учруулж буйн жишээнд олборлох үйлдвэрлэлийн салбарын бодлого, эрх зүйн шинэтгэл хийхэд олон нийттэй зөвлөлдөх арга хэмжээ зохион байгуулж байх хуулиар ноогдуулсан үүргийн биелэлтийг хангахгүй байх явдал багтжээ. Талуудын оролцоо ийнхүү суларч буй нь ОУИТБС-ын үйл явцад тавих Үндэсний зөвлөл болон ОТОБ/ Ажлын хэсгийн хяналтад хийдэл үүсгэж, мөн үндэсний бүтэц дэх дотоод засаглалын тэнцвэр алдагдахад хүргэж байна.

#### *Ил тод байдал*

Монгол улсад ОУИТБС-ын өгөгдөл мэдээллийг Засгийн газрын порталаар дамжуулан өргөн хүрээнд системтэйгээр ил тод болгож байна. ОУИТБС-ын хүрээнд Засгийн газрын зүгээс системтэйгээр ил тод болгож буй байдалд дүн шинжилгээ хийж буй ч үүнд үндэслэн жил тутам ОУИТБС-ын тайлан гаргах явцад бүтцийн өөрчлөлт хийгээгүй. Монголын ОУИТБС-ын зүгээс 2020 онд зөвшөөрөн хэрэгжүүлсэн ОУИТБС-ын тайлан гаргах “үян хатан” хандлагыг иргэний нийгмийн зүгээс дэмжээгүй, төрийн хүлээн авсан олборлох салбарын орлогыг үнэн бодитой тайлагнах чиглэлээр хамрах хүрээ нь буурсан байна. Засгийн газрын зүгээс цахим засаглалын чиглэлээр өргөн хүрээний шинэчлэл хийж буй өнөөгийн нөхцөлд Монгол улсын хувьд хэдийн бий болсон системтэй ил тод болгох үйл явц болон Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системд суурилан ОУИТБС-ын ил тод болгох үйл явцад шинэлэг инновац, хандлагыг хөгжүүлэх боломж байна. Монгол улс нь гэрээний болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлын чиглэлээр ахиц дэвшил гаргажээ. Харин төслийн түвшинд мэдээлэл ил тод болгох чиглэлд ахиц дэвшил

хязгаарлагдмал байна. ТӨК-иудын ажил гүйлгээний ил тод байдал, ялангуяа олборлох салбараас олж буй орлогыг улсын төсөвт бүртгэхгүй байх, төсвийн шинжтэй зарцуулалт, нөөцөөр баталгаажсан зээл, зэрэг дээр цаашид ихээхэн зүйлийг хийж хэрэгжүүлэх шаардлагатай бүйг КОВИД-19 цар тахлын үед ТӨК-иудын зарцуулалт ихээхэн нэмэгдсэнтэй холбон үзэж болно. Түүнчлэн олон нийтийн ихээр сонирхдог тусгай зөвшөөрөл олгох, олборлох үйлдвэрлэлийн орлогоос орон нутагт шилжүүлэх, компаниудын нийгмийн зарцуулалт зэрэг дээр ОУИТБС нь жил тутамд дүн шинжилгээ хийж байсан өмнөх үйл ажиллагааг сэргээх боломж, орон зай байна.

#### *Үр дүн, үр нөлөө*

Монгол улс нь ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүнгүүд, төлөвлөлтийг жил тутамд судлан үзэж буй ч эдгээр хоёр гол мониторингийн аргачлал хоорондын уялдаа холбоо сүүлийн жилүүдэд сул хэвээр байж иржээ. Монголын ОУИТБС-ын хувьд жил тутмын Ажлын төлөвлөлтөө сайжруулах зорилгоор тусгайлсан нөлөөллийн үнэлгээг хийж гүйцэтгэх боломж нээлттэй байна. Эдгээр баримт бичгүүдийг боловсруулахад өргөн хүрээнд хэлэлцүүлэг, зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулах нь хамаарах оролцогч талуудын үзэл бодлыг эдгээрт тусгахад чухал ач холбогдолтой. Монголын ОУИТБС-ын зүгээс онлайн мэдээлэл ашиглан цар тахлын нөлөөллийг даван гарахаар хичээл зүтгэл гаргасан ч иргэний нийгмийн зүгээс идэвхтэй ажилласантай харьцуулбал Засгийн газар, салбарын аж ахуйн нэгжүүдийн оролцоо хангалтгүй байсан нь Монголын ОУИТБС-ын зүгээс олборлох үйлдвэрлэлийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг өрнүүлэхээр хэрэгжүүлсэн хүчин чармайлт сулрахад хүргэжээ. ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх илүү тогтвортой, хүчтэй механизмыг бүхий л оролцогч талуудын шинэ, илүү өндөр хэмжээний оролцоотой хослуулах нь олборлох салбар, төрийн санхүүгийн удирдлагыг шинэтгэлд оруулах чиглэлээрх ОУИТБС-ын хувь нэмрийг улам бэхжүүлнэ. Энэ нь цаашид Монголын ОУИТБС-ын нээлттэй өгөгдлийн чиглэлээрх хүчин чармайлтыг олон нийтийн хэлэлцүүлэг, бодлого боловсруулахад зориулсан мэдээллээр хангахад түлхэц болох юм.

## Баталгаажуулалтын онооны карт

Бүрэлдэхүүн хэсэг болон модуль	ОУИТБС-ын шаардлага	Ахиц	Оноо
<b>Үр дүн, үр нөлөө</b>		<b>Дунд</b>	<b>75.5/100</b>
Нэмэлт оноо	Үр дүнтэй, тогтвортой байдлын үзүүлэлтүүд		3.5
Үр дүн, үр нөлөө	Ажлын төлөвлөгөө (#1.5)	Бүрэн хангасан	90
	Олон нийтийн хэлэлцүүлэг (#7.1)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Мэдээллийн хүртээмж болон нээлттэй мэдээлэл (#7.2)	Бүрэн хангасан	90
	ОУИТБС-ын өгсөн зөвлөмжүүд (#7.3)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Үр дүн, үр нөлөө (#7.4)	Ихэнх хэсгийг хангасан	60
<b>Оролцогч талуудын оролцоо</b>		<b>Доогуур</b>	<b>67.5/100</b>
Олон талт оролцогчдын хяналт	Төрийн оролцоо (#1.1)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Салбарын оролцоо (#1.2)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Иргэний нийгмийн оролцоо (#1.3)	Бүрэн хангасан	90
	Ажлын хэсгийн засаглал (#1.4)	Ихэнх хэсгийг хангасан	60
<b>Ил тод байдал</b>		<b>Доогуур</b>	<b>67/100</b>
Олборлох үйлдвэрлэлийн тойм	Хайгуулын мэдээлэл (#3.1)	Давуулан хангасан	100
	Эдийн засагт оруулж буй хувь нэмэр (#6.3)	Бүрэн хангасан	90
Эрх зүйн, санхүүгийн орчин	Эрх зүйн орчин (#2.1)	Давуулан хангасан	100
	Гэрээ (#2.4)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл (#6.4)	Үнэлээгүй	-
Тусгай зөвшөөрөл	Гэрээ болон тусгай зөвшөөрөл хуваарилалт (#2.2)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Тусгай зөвшөөрлийн бүртгэл (#2.3)	Бүрэн хангасан	90
Эзэмшил	Эцсийн өмчлөгч (#2.5)	Ихэнх хэсгийг хангасан	60
Төрийн оролцоо	Төрийн оролцоо (#2.6)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Мөнгөн бус орлого (#4.2)	Хамаарахгүй	-



	ТӨК-иудын ажил гүйлгээ (#4.5)	Ихэнх хэсгийг хангасан	60
	ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалт (#6.2)	Хэсэгчлэн хангасан	30
Үйлдвэрлэл, экспорт	Үйлдвэрлэлийн мэдээлэл (#3.2)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Экспортын мэдээлэл (#3.3)	Бүрэн хангасан	90
Орлого төвлөрүүлэлт	Иж бүрэн байдал (#4.1)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Бартерын гэрээ (#4.3)	Хэсэгчлэн хангасан	30
	Тээвэрлэлтийн орлого (#4.4)	Хамаарахгүй	-
	Задаргаат байдал (#4.7)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Өгөгдөл мэдээллийн цаг хугацаат байдал (#4.8)	Давуулан хангасан	100
	Өгөгдөл мэдээллийн чанар (#4.9)	Ихэнх хэсгийг хангасан	60
Орлогын удирдлага	Орлогын хуваарилалт (#5.1)	Хэсэгчлэн хангасан	30
	Орлогын менежмент болон зарцуулалт (#5.3)	Үнэлээгүй	-
Орон нутагт оруулах хувь нэмэр	Орон нутагт хийх шууд төлбөр (#4.6)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Орон нутагт шилжүүлэх шилжүүлэг (#5.2)	Ихэнх хэсгийг хангасан	60
	Нийгэм, байгаль орчны чиглэлийн зарцуулалт (#6.1)	Ихэнх хэсгийг хангасан	60
<b>Нийт оноо</b>		<b>Доогуур</b>	<b>70/100</b>

## ОУИТБС-ны Баталгаажуулалтын оноог хэрхэн өгдөг вэ?

### Бүрэлдэхүүн хэсэг болон нийт оноо

ОУИТБС-ын гурван бүрэлдэхүүн болох “Ил тод байдал”, “Талуудын оролцоо” болон “Үр дүн, үр нөлөө” дээр тус бүрд нь 100 хүртэл оноо өгнө. Нийт өгсөн оноо нь тухайн бүрэлдэхүүн хэсгийн дундаж оноо болно.



### ОУИТБС-ын шаардлагуудын үнэлгээ

Баталгаажуулалт нь ОУИТБС-ын аль шаардлагыг ханган биелүүлж буй цар хүрээг 5 ангилал ашиглан үнэлдэг. Бүрэлдэхүүн хэсгийн оноо нь тухайн бүрэлдэхүүн хэсэгт хамаарах шаардлага бүр дээр өгсөн онооны дундаж байна.



- **Давуулан ханган биелүүлсэн** (100 оноо): Шаардлагын бүхий л талыг, үүнд “хүлээгдэж буй”, “хэрэгжүүлэх тохиолдолд давуу талтай” болон “хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож буй” шаардлагуудыг ханган биелүүлсэн, тухайн шаардлагын өргөн хүрээний зорилтуудыг Засгийн газар болон компаниудын системээр дамжуулан системтэйгээр ханган биелүүлсэн байх.
- **Бүрэн ханган биелүүлсэн** (90 оноо): Тухайн шаардлагын өргөн хүрээний зорилт нь бүрэн биелэгдсэн, шаардлагад тусгагдсан бүхий л зүйлсийг бүрэн хамруулан биелүүлсэн.
- **Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн** (60 оноо): Шаардлагын ихэнх хэсгийг ханган биелүүлсэн, шаардлагын өргөн хүрээний зорилтын ихэнх хэсэг нь биелэгдсэн.
- **Хэсэгчлэн ханган биелүүлсэн** (30 оноо): Шаардлагын ихэнх хэсэг нь бүрэн биелэгдээгүй, шаардлагад хамаарах өргөн хүрээний зорилт биелээгүй.
- **Ханган биелүүлээгүй** (0 оноо): Шаардлагад хамаарах бүх эсвэл бараг бүх хэсгийн биелэлт хүлээгдэж буй, өргөн хүрээний зорилт хангагдахад хол буй.
- **Үнэлээгүй**: Ил тод болгож байхыг зөвлөмж болгосон ч заавал шаардлагын хэлбэргүй тул баталгаажуулалтын хамрах хүрээнд оруулаагүй.
- **Хамаарахгүй**: Ажлын хэсгийн зүгээс тухайн шаардлага нь хамаарахгүй болохын батлан харуулсан.

Цуглуулсан баримт нотолгоо нь тодорхой үнэлгээ гаргах боломжгүй хэмжээнд буй, тухайн асуудлаарх оролцогч талуудын үзэл бодол зөрүүтэй эсвэл Ажлын хэсэг (Олон талын оролцоот бүлэг) нь Олон улсын Ажлын албаны үнэлгээтэй санал нийлэхгүй бол үнэлгээнд тухайн нөхцөл байдлыг тайлбарлан тусгадаг.

## 1. Үр дүнтэй байдал, тогтвортой байдлын үзүүлэлтүүд

Нийт таван үзүүлэлт тус бүр дээр Монгол улс нь 0, 0.5 эсвэл 1 гэсэн оноог тус бүр нэмэлтээр авсан. Эдгээр оноог Үр дүн, үр нөлөө хэмээх бүрэлдэхүүн хэсгийн оноонд нэмж тооцсон.

### 1.1 ОУИТБС-ын үндэсний хэмжээнд хамааралтай байдал

Энэхүү үзүүлэлт нь ОУИТБС-ын хэрэгжилт нь Монгол улсын хувьд үндэсний түвшинд хамааралтай олборлох салбарт тулгарч буй сорилт, эрсдэлд хандаж буй хэм хэмжээг харгалзан үнэлнэ.

Монголын ОУИТБС-ын жил тутмын Ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжилтийн ихэнх зорилтууд нь олборлох салбарт хамаарах үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлт үялдахаас (*Шаардлага 1.5 дээр үзнэ үү*) илүүтэйгээр ОУИТБС-ын хэрэгжилттэй явцуу байдлаар үялджээ. Гэвч орон нутгийн оролцогч талуудын олборлох салбарын талаарх мэдээллийн хүртээмжийг сайжруулах, орон нутаг дахь олон талын оролцоот платформын чадавхыг сайжруулах, авлигатай тэмцэх арга зам болох эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг сайжруулах зэрэг үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлд зарим талаар холбогджээ. Эдгээр зорилтуудыг боловсруулах, тодорхойлох үйл явцад оролцогч талуудтай өргөн хүрээнд зөвлөлдсөн байдал нь нөгөө талаар асуудалтай бөгөөд ажлын төлөвлөгөөний төслийг Ажлын хэсгийн гишүүдэд богино хугацааны өмнө тараан санал авчээ (*Шаардлага 1.4 дээр үзнэ үү*). Эцсийн өмчлөгчийн болон гэрээний ил тод байдал, ТӨК-иудын засаглалтай холбоотойгоор ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэд хэдэн ажил нь олборлох салбарын хүрээнд тулгараад буй өргөн хүрээний сорилтуудтай холбоотой ч тухайн сорилтуудыг шийдэхээр төлөвлөж буй үйл ажиллагааг Ажлын төлөвлөгөөнд тодорхой тусгаагүй байна.

ОУИТБС-ын Ажлын төлөвлөгөө, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлүүдээс үзвэл Ажлын хэсэг нь өөрийн үйл ажиллагааг ОУИТБС-ын минимум шаардлагуудыг давахуйц хэмжээнд явуулах боломжуудыг судлан үзсэн ба ялангуяа ОУИТБС-ын өгөгдөл мэдээллийг системтэйгээр ил тод болгох, ил тод болгож буй мэдээллийн цар хүрээнд нүүрс боловсруулагч компаниуд, гэрээт гүйцэтгэгч нарыг багтаан өргөтгөх, мөн 200 гаруй Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг ил тод болгох замаар нийгмийн шинжтэй зарцуулалтад хамаарах нэмэлт мэдээлэл ил тод түгээх зэрэг олон боломжуудыг хэлэлцжээ. Ялангуяа өгөгдөл мэдээллийг системтэйгээр ил тод болгохтой холбоотойгоор Монголын ОУИТБС нь төрийн байгууллагууд өөрийн төсвийн зарцуулалтын материаллаг дүнг ил тод нийт болгохыг шаарддаг Шилэн дансны тухай хууль, цахим засаглалын [e-government](#) шинэчлэл зэрэг бусад шинэтгэлийн үйл ажиллагааг харилцан нөхөрлөж байх арга замыг эрэлхийлэх шаардлагатай. Үндэсний зөвлөл, Ажлын

хэсгийн хурлын тэмдэглэлүүд, талуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлага зэрэг нь Ажлын хэсэг дээр ОУИТБС-ын Стандартад зааснаас бусад олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглалын асуудлаар хэлэлцэж байсан эсэхийг харуулан нотолгоо бага, зөвхөн Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ) л уул уурхайн үйл ажиллагаа дахь авлигын эрсдэл, зохицуулалтын орчин болон худалдан авалтын журмууд зэргийг судалсан [Авлигын дүн шинжилгээний аргачлал](#) боловсруулж буйг эс тооцвол өөр нотолгоо байхгүй. Гэсэн ч зарим баримт нотолгоо, жишээ нь Монголын ОУИТБС-ын жилийн Ажлын тайлан зэрэг нь орон нутгийн түвшинд хийгдсэн мэдээлэл хүргэх үйл ажиллагаа нь орон нутгийн ажил эрхлэлт, худалдан авалт, орон нутгийн хөгжлийн гэрээ, түсгай зөвшөөрөл олгох үйл явц зэрэг үндэсний хэмжээний ая холбогдол бүхий асуудлаарх хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангажээ. Монголын ОУИТБС-ын тайлангууд нь олборлох үйлдвэрлэлийн салбараас байгаль орчинд нөлөөлөх байдал, ус болон хог хаягдлын менежмент зэрэг ОУИТБС-ын Стандартаас шаардсанаас давахуйц мэдээллийг мөн ил тод болгон нийтэлжээ. Ажлын хэсэг нь мөн 2018 оноос хойш гэрээний ил тод байдлыг хангах, үүнд 2021 оноос өмнө хийгдсэн буй олон тооны гэрээг гэрээний ил тод байдлын порталд ил тод нийтлэх чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргаж иржээ.

Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч талын зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтийн зорилтуудыг хангахад, ялангуяа олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг ил тод болгох чиглэлээр ахиц гарч буй хэмээн үзэж буй ч тухайн зорилт хангагдсан хэмээн бүрэн үзэхгүй байна. Ялангуяа иргэний нийгмийг төлөөлж буй талуудын зүгээс орон нутгийн түвшин дэх олборлох үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл, авлигыг бууруулах зорилтуудыг хангах хүртэл урт хугацаа байна хэмээн үзэж байна. Бүхий л оролцогч талын зүгээс нутгийн иргэд, орон нутгийн иргэний нийгмийн идэвхтнүүд, нутгийн захиргааны зүгээс уул уурхай, байгалийн хий, газрын тосны үйл ажиллагааг эсэргүүцэх байдал түгээмэл буй, эдгээр талууд нь уул уурхайг эсэргүүцэх зорилготой буйг тэмдэглэж байв. Ярилцлага хийсэн бүхий л талуудын зүгээс ОУИТБС-ийн хэрэгжилтэд зориулан санхүүгийн болон техникийн хангалттай эх үүсвэр хуваарилдаггүй нь ОУИТБС-ын хэрэгжилтийн зорилтуудыг хангахад саад болж байна гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Ярилцлагад оролцсон зарим талуудын зүгээс ОУИТБС дахь оролцоо удааширсан нь КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс шалтгаалсан гэж үзсэн бол зарим нь энэ явдал цар тахлаас өмнө үүссэн, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиг үүргийг Ерөнхий сайдын Ажлын албанаас УУХҮЯ-нд шилжүүлснээс шалтгаалсан гэж үзжээ. Баталгаажуулалтын үнэлгээний тайланд өгсөн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор хэд хэдэн удаагийн хөл хорио тавигдсан нь 2020- 2021 онуудын ОУИТБС-ын хэрэгжилт болон улсын эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлсэн болохыг дурджээ. Ярилцлагад хамрагдсан төрийн албан тушаалтнуудын хувьд Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн талаар өөдрөг бодолтой, жишээ нь Засгийн газрын зүгээс цаашид шаардлагатай эх үүсвэрийг хуваарилна хэмээн үзэж буй бол салбар болон иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс явагдаж буй үйл явцад сэтгэл дундуур буйгаа илэрхийлж, ялангуяа салбарын төлөөллийн зүгээс компаниудад жил болгон мэдээллээ гарган тайлагнахыг шаарддаг, иргэний нийгмийн зүгээс нөгөө хоёр талын оролцоо тааруу буй талаар асуулга явуулж байдаг талаар дурдсан. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс Баталгаажуулалтын тайлангийн төсөлд өгсөн тайлбартаа санаачилгын хэрэгжилт нь нээлттэй мэдээллийн чиглэлээр, үүнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль боловсруулах чиглэлээр Засгийн газар хамаарах шийдвэр гаргахад хувь нэмэр оруулсан хэмээн

үзжээ. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгэм, салбарын хэд хэдэн оролцогч ОУИТБС-ын мэдээлэл ил тод болгохоос илүү мэдээллийн илүү үр дүнтэй ашиглах замаар олборлох үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн засаглалын механизмын үр ашигтай байдлыг үнэлэх хэрэгтэйг дурдсан.

Энэхүү үзүүлэлтийн Үр дүн, үр нөлөөн дээр нэмэлтээр 0.5 оноог өгөхийг Ажлын албаны зүгээс санал болгож байна.

## 1.2 Олборлох үйлдвэрлэлийн салбарын мэдээллийн системтэйгээр ил тод болгох

ОУИТБС-ын Стандартад заасны дагуу өгөгдөл мэдээллийг системтэйгээр төрийн байгууллага болон ТӨК-ийн вэбсайт, порталаар дамжуулан ил тод болгох үйл явц явагдаж буй энэ явцад хувийн компаниуд хамрагдаагүй. Ийнхүү системтэйгээр ил тод болгож буй нь олон хэлбэрээр жишээ нь АМГТГ-ын кадастрын [мэдээллийн сан](#) болон Монголын ОУИТБС-ын нээлттэй мэдээллийн [портал](#), нээлттэй гэрээний [портал](#) дээрх иж бүрэн ил тод болгосон гэрээ, Шилэн дансны [портал](#) дээрх ТӨК-иудын мэдээлэл, АМГТГ-ын сар тутмын [тайлан мэдээ](#) дээрх олборлох салбарын үйлдвэрлэлийн мэдээлэл, ГЕГ-ын [портал](#) дээрх экспортын мэдээ, [төсөв](#), [худалдан авалт](#) болон [аудитын](#) үйл ажиллагааны мэдээлэл, Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн сангийн [портал](#) дээрх орон нутагт хуваарилж буй төсвийн мэдээлэл зэргээс бүрджээ. Үүний зэрэгцээ олборлох салбараас Засгийн газар татвар болон татварын бус хэлбэрээр бүрдүүлж буй орлого, компаниудын төлж буй мөнгөн дүнг Монголын ОУИТБС-ын [цахим тайлангийн портал](#) болон нээлттэй өгөгдлийн порталаар ил тод болгож буй ч энэхүү мэдээлэл цуглуулах систем нь шинээр байгуулагдсан [Цахим хөгжил, харилцаа холбооны яамны](#) хэрэгжүүлж буй [цахим засаглал](#) чиглэлийн мэдээллийн сантай холбогдоогүй, төрийн байгууллагууд болон ОУИТБС-ын мэдээллийн портал хоорондын шууд холболт хараахан бүрдээгүй байна. Энэхүү системтэй ил тод болгож буй үйл явцыг 2018 оны 2 дугаар сард хийгдсэн [Мэдээллийг нэгтгэн үялдуулах ТЭЗҮ-ийн](#) хүрээнд судлан үзжээ. Эдгээр порталуудын олонх нь мэдээллийн хүртээмжийг сайжруулах шинэлэг арга замыг хөгжүүлсэн ч бүгд өгөгдлийг нээлттэй өгөгдлийн форматаар татан авах боломжийг бүрдүүлээгүй. Цаашид системтэй ил тод болгож буй мэдээллийг оролцогч талууд, ялангуяа орон нутагт буй оролцогч талууд ашиглаж байдлыг сайжруулах ажил хийгдэх шаардлагатай.

Монгол улс нь өөрийн ОУИТБС-ын тайлагналыг ашиглан төрийн байгууллагуудтай ажиллаж, тэднээр нээлттэй гэрээний портал эсвэл цахим тайлангийн системийн нэгэн адил ил тод болгох сувгуудыг хөгжүүлэх чиглэлд хандан ажиллаж байна. Гэвч онлайн тайлагналын платформ нь өнөөг хүртэл мэдээлэл гараар оруулахыг шаардаж, ТЕГ, АМГТГ, ҮСХ зэрэг төрийн бусад мэдээллийн сангуудтай холбогдоогүй байна. Монгол улс нь 2020 оны ОУИТБС-ын мэдээллийг тайлагнахад цахим тайлагналын системээр ил тод болгож буй мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулахыг турших сонголтот арга хандлага бус харин “уян хатан” хандлага баримтлахаар шийдэж, нэгтгэл тайланд хамрагдах компаниудын тоог бууруулсан. Энэхүү уян хатан аргачлал нь Монгол улсад үүссэн КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн 2020-2021 онд тавьсан 7 удаагийн хөл хориотой холбоотой байна. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа жил тутам цахим тайлангийн системээр 1500 гаруй компани тайлангаа ирүүлдэг бол 2021 онд энэ тоо 1700 болж өссөнийг дурдсан. Монголын ОУИТБС-ын хувьд ирэх

саруудад өөрийн өгөгдлийн порталыг харилцан уялдуулах замаар цахим засаглалын нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал ([e-засаглал](#)), төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох чиглэлээр хүчин чармайлт гаргах шаардлагатай. Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг нь өнөөг хүртэлх хугацаанд цахим тайлангийн платформд хийсэн хөрөнгө оруулалтад суурилан ирүүлж буй мэдээллийн үнэн зөв байдлыг эрсдэлд суурилсан аргаар хянаж байх шинэ сонголтот тайлагналын системийг мөн нэвтрүүлэх боломжийг судлан үзэж болно. Эрдэс баялгийн салбарт хийгдэж буй болон төлөвлөгдөж буй эрх зүйн шинэтгэл нь олборлох үйлдвэрлэлийн салбар дахь тусгай зөвшөөрөл эзэмшигч, төрийн хамааралтай хуулийн этгээдүүдэд өгөгдөл мэдээлэл ил тод нийтэлж байх үүргийг хуулиар ноогдуулах боломжийг олгож буйн тоонд Ашигт малтмалын тухай хууль, Баялгийн сангийн тухай хууль, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль, Төрийн өмчийн тухай хууль болон бусад хуулиуд багтаж байна.

Олон улсын Ажлын албаны зүгээс энэхүү үзүүлэлтийн Үр дүн, үр нөлөөлөл дээр нэмэлт 1 оноо өгөхийг санал болгож байна.

### 1.3 Олборлох үйлдвэрлэлийн засаглал дахь иргэдийн оролцооны орчин

Энэхүү үзүүлэлтээр олборлох үйлдвэрлэлийн засаглалд иргэдийн, тэр дундаа салбарын нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн оролцооны орчин хэр хэмжээнд бүрдсэн эсэхийг үнэлдэг.

Хамаарах эрх зүй, зохицуулалтын орчин нь иргэдийн, тэр дундаа нөлөөлөлд өртөж буй нутгийн иргэдийн зүгээс олборлох үйлдвэрлэлийн нөөцийг хэрхэн удирдах талаарх шийдвэр гаргалт дахь оролцоог дэмжсэн харагдаж байна. Бодлого болон хууль тогтоомж боловсруулахад олон нийттэй зөвлөлдөх арга хэмжээг явуулж байхыг шаардсан хэд хэдэн хууль буйн тоонд Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль зэрэг багтжээ. Эдгээр хуульд заасан зүйл заалтууд нь ямар нэгэн бодлогын болон эрх зүйн шинэтгэл хийхэд олон нийттэй зөвлөлдөх, сонсох ажиллагаа зохион байгуулах үүргийг хамаарах талуудад ноогдуулж байна. Гэвч эдгээр хуулийн бодит байдал дэх хэрэгжилтийн хувьд тодорхой асуудлууд байна. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн байгууллагуудын хэд хэдэн төлөөллийн зүгээс заавал хийх ёстой зөвлөлдөх үйл явц гажиж буй, ялангуяа энэхүү гажуудуулах үйлдэл сүүлийн жилүүдэд ихээр гарч буй зовниж буйгаа илэрхийлсэн. Тэдний хувьд зөвлөлдөх үйл ажиллагаанд хамаарах яам нь хууль, журмын төслийг зөвхөн өөрийн вэбсайтад байрлуулж л буй бөгөөд ирүүлсэн саналуудын дагуу арга хэмжээ авдаггүй ажээ. Бусад ИНБ-уудын зүгээс зөвлөлдөх арга хэмжээнд хамруулах ТББ-уудыг Засгийн газар өөрөө сонгон авдгийн зэрэгцээ өгсөн саналыг нь үл хайхардаг хэмээн үзжээ. Үүний жишээ болгон уул уурхай, төрийн өмчийн холбогдолтой хэд хэдэн хуулийн шинэчлэлийн төслийг өнөө хүртэл нийтлээгүй тул УИХ-ын хаврын чуулганд хэлэлцэхийг намрын чуулган болтол хойшлуулсныг дурдсан. Төрийн зарим албан тушаалтны зүгээс хуулийн төслийн сонсох ажиллагаа саатсан гэж хэлж буй ч үндсэндээ цар тахал, хөл хорионоос шалтгаалж, сонсох ажиллагааг хойшлуулжээ. Хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр уул уурхайн төслүүд болон нийтийн сонсгол дахь иргэдийн оролцоонд зориулан мэдээлэл хүргэх [порталыг](#) хөгжүүлсэн байна. Нээлттэй засгийн түншлэлийн Монгол улсын Үйл ажиллагааны үндэсний 4 дүгээр төлөвлөгөөний ([2021-23](#)) Үүрэг амлалт 2 дээр мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг тусгасан ба үүнд Нийтийн сонсголын тухай хуулийг сайжруулах амлалт



багтжээ. Иргэний нийгмийн байгууллагууд нь нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах, стратегийн өмгөөлөл хийх зэргийг олборлох салбарт хамаарах төрийн шийдвэр гаргалтын үйл явцад нөлөөлөх арга хэрэгсэл байдлаар амжилттай ашиглаж байна. Монгол улс нь 2021 онд Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргаж, мөн хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлсэн хамгийн эхний улс болсон ч баталгаажуулалтын хүрээнд ярилцсан хэд хэдэн талын зүгээс энэхүү хууль нь бодитоор хараахан хэрэгжихгүй буйг дурдсан. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба олборлох үйлдвэрлэлийн салбарын талаар иргэд, уул уурхайн нөлөөнд өртсөн хүмүүсийн мэдлэг нэмэгдэж буйг дурдаад, Монгол улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлт нь бодлого боловсруулах үйл явцад УИХ-ын үүрэг ролийг улам нэмэгдүүлсэн болохыг цохон тэмдэглэжээ.

ОУИТБС-ын үйл явцад оролцож буй, үндэсний хэмжээнд байгалийн баялгийн засаглалын чиглэлээр ажиллаж буй иргэний нийгэм нь харьцангуй чадвар өндөртэй, ихэнхдээ олон улсын эх үүсвэрээс санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн иргэний нийгмийн чадавх ялгаатай, янз бүр ч ярилцлагын үеэр ТАН эвслийн гишүүн байгууллагууд нь гишүүн бус орон нутгийн байгууллагуудтай харьцуулбал илүү чадавхтай болохыг дурдаж байсан. Хэдий Засгийн газрын зүгээс Монгол дахь иргэний нийгэмд тодорхой хаалт, хориг тавьж байсан түүх байхгүй ч ТББ-уудын эрх зүйн орчныг шинэчлэх оролдлого 2011, 2014 болон 2019 онуудад хийгдэж, амжилт олоогүй талаар дотоодын болон улсын иргэний нийгмийн зүгээс асуудал болгон гарган ирсэн. Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй орон нутгийн иргэдийг төлөөлж буй иргэний нийгмийн оролцоо нь Монголын ОУИТБС-ын хувьд байгалийн баялгийн засаглал, үүнд иргэний нийгмийн оролцооны орчин зэрэг хамаарах бүхий л асуудлаарх хэлэлцүүлгийн платформыг ханган өгөх боломжтойг харуулж байна. Монголын ОУИТБС-ын баримт бичгүүд, хурлын тэмдэглэлүүдийг судлан үзэхэд иргэдийн оролцоо, үүнд уул уурхайн нөлөөнд өртсөн нутгийн иргэдийн олборлох салбарын нөөцийг хэрхэн удирдаж буй талаар эсвэл тухайн механизмыг хэрхэн бэхжүүлэх тухай зарим талаар бодлого, үйл ажиллагааны хэлэлцүүлэг хийгдэхгүй буйг харуулж байна. Тиймээс Монголын ОУИТБС-ын олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа, арга хэмжээ нь орон нутгийн түвшинд байгалийн баялгийн менежментийн талаарх хэлэлцүүлгийг дэмжиж, орон нутаг дахь олборлох үйлдвэрлэлтэй хамаарах шийдвэр гаргалт дахь иргэдийн оролцоо, ил тод байдлыг бэхжүүлэх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Гэсэн хэдий ч ярилцлагад хамрагдсан салбар болон төрийн төлөөлөл оролцогчдын зүгээс иргэний орон зайн хамааралтай асуудал нь ОУИТБС-ын үйл явцын нэг хэсэг хэмээн үзэхгүй байна. Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа иргэний нийгмийн оролцогч талууд нь байгалийн баялгийн засаглалын асуудлаарх хэлэлцүүлгийн орон зайг бий болгож буй цорын ганц тал нь иргэний нийгэм болохыг дурдсан.

ОУИТБС-ын хэрэгжилтийн орон нутгийн зөвлөлөөр дамжуулан (бүх 21 аймаг, 13 сум) бодит байдал дээр байгалийн баялгийн засаглалын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх орон зайг бий болгож, мэдээлэл хүргэх үйл явцыг үндсэндээ иргэний нийгэм тэргүүлэн хэрэгжүүлж байна. Ярилцлагын үеэр иргэний нийгмийн зүгээс тухайн форум нь байгалийн нөөцийн удирдлагын талаарх чөлөөт, ач холбогдол бүхий хэлэлцүүлгийн иргэний орон зайг, ялангуяа нутгийн иргэд болон орон нутгийн захиргааны уул уурхайн эсрэг сэдэл бүхий орчинд тухайн орон зайг үүсгэжээ. Иргэний нийгмийг төлөөлсөн хэд хэдэн оролцогчийн зүгээс орон нутаг дахь орлогын урсгал

болон нийгмийн чиглэлийн зарцуулалтын талаарх ОУИТБС-ын өгөгдөл, мөн гэрээ болон тусгай зөвшөөрлийн мэдээллийн портал нь тусгай зөвшөөрөл эзэмшил, орон нутагт хуримтлагдаж буй орлого зэрэгт ихээхэн чухал үүрэгтэйг цохон дурдсан. КОВИД-19 цар тахал нь ОУИТБС-ын мэдээлэл түгээх, мэдээлэл харилцааны үйл ажиллагааг онлайн сувгаар хийхэд хүргэсэн ч Монгол улсын иргэдийн ихэнх нь интернэттэй болсон тул илүү өргөн хүрээнд, хүн нэг бүрд хүрсэн гэж иргэний нийгмийн зүгээс үзжээ.

Олон улсын Ажлын албаны зүгээс энэхүү үзүүлэлтийн Үр дүн, үр нөлөө дээр нэмэлт 0.5 оноо санал болгож байна.

#### 1.4 Олборлох үйлдвэрлэлийн салбарын мэдээллийн хүртээмж, хэрэглээ

Энэхүү үзүүлэлтээр олборлох үйлдвэрлэлийн өгөгдөл мэдээллийг дүн шинжилгээ, судалгаа, нөлөөллийн чиглэлээр хүртээмжийг хангаж, ашиглаж буй байдлыг үнэлдэг.

Баталгаажуулалтын хүрээнд гарган өгсөн баримт бичиг, талуудтай хийсэн ярилцлага зэргээс үзвэл олборлох салбар дах хөрөнгийн эрх, үүнд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, үүл уурхайн компаниудын эзэмшил, үйл ажиллагаа явуулах гэрээний хугацаа болон нөхцөл, орон нутаг дах орлогын үрсгал, үүнд аймаг болон сумдад шууд төлж буй төлбөр, орон нутагт шилжүүлж буй мөнгө, нийгэм болон байгаль орчны чиглэлээр оруулж буй хувь нэмэр зэрэг олон нийтийн ашиг сонирхолд хамаарах асуудал иргэний нийгэмтэй хийсэн зөвлөлдөх үйл ажиллагаанд тусгагдсаныг харуулж байна. Сүүлийн жилүүдэд мөн олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-иудын санхүүгийн удирдлагын талаар, ялангуяа 2017 оноос ОУВС-ын өргөтгөсөн санхүүгийн хөтөлбөрт Монгол улс хамрагдсанаас хойш илүү ихээр сонирхох болжээ. Ярилцлагад хамрагдсан салбарын болон иргэний нийгмийн төлөөллийн зүгээс ОУИТБС-ын ил тод болгож буй мэдээллийг төрийн зүгээс олборлох салбараас төвлөрүүлсэн орлогын удирдлага, хамаарах зарцуулалтыг хамруулан өргөтгөх талаар ижил сонирхолтой байна. Монголын ОУИТБС-ын тайлагнал нь эдгээр чиглэлээрх төрийн байгууллагуудын системтэйгээр мэдээлэл ил тод болгох үйл явц дээр суурилсан ч заавал шаардсан процедурыг нь хамрахаас бус эдгээрээс гажсан ямар нэгэн нөхцөлд жил тутам дүн шинжилгээ хийж байхад анхаарахгүй байна. Монголын ОУИТБС-ын тайлагналаар олборлох үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны талаарх их хэмжээний өгөгдөл мэдээлэл ил болж буй ч хууль болон гэрээний хүрээнд компаниуд хүлээсэн үүргээ даган мөрдөж буй эсэх дээр үнэлгээ хийж, хэвлэн нийтлэх хэмжээнд хараахан хүрээгүй байна.

Монголын [ОУИТБС-ын тайлангууд](#) нь pdf форматаар нийтлэгдэж буй ба хамаарах хавсралт, тойм мэдээлэл нь нээлттэй форматаар гарч байна. Монголын ОУИТБС-ын [мэдээллийн портал](#) нь нээлттэй форматаар (.csv, .xls, .json) өгөгдлийг татан авах үйлдэлтэй. ОУИТБС-ын өгөгдлийг хэвлэн нийтэлж буй цаг үеэ олсон, компаниуд нь мэдээллийн порталаар дамжуулан өгөгдөл мэдээллээ жил бүртийн 3 дугаар сарын 31-нээс өмнө хүргүүлснээс хойш удахгүй порталд тавигдаж байна. Монгол улс нь хамаарах санхүүгийн жил дууссанаас хойш нэг жилийн хугацаанд багтаан ОУИТБС-ын тайланг бэлтгэн гаргадаг. Гэвч ярилцлагад хамруулсан оролцогч талын зүгээс үүнийг олон нийтийн хэлэлцүүлэг, бодлого боловсруулах ашиглах цаг хугацааны хувьд дэлхийд



Твиттерийн хэрэглээгээр өндөрт ордог оронд хоцролттой (хамаарах хугацаа дууссанаас хойш нэг жилд багтан гарч буй ч) байдаг хэмээн үзэж байна.

ОУИТБС-ын үйл явцын хүрээнд бэлтгэгдэж буй өгөгдөл мэдээллийн дотоодын болон олон улсын оролцогч талууд ашиглаж буй баримт байна. Дотоодоо гэхэд ОУИТБС-ын багц өгөгдлийг хэвлэл мэдээлэл ихээр ашиглаж буйн жишээнд уул уурхайн компаниудын өгсөн [хандив тусламж](#), олборлох үйлдвэрлэлийн салбарын орлого болон [Орон нутгийн хөгжлийн сан](#), [эцсийн өмчлөгч](#), [эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл](#), болон ОУИТБС-ын [тайлан](#) гаргаагүй компаниудын тусгай зөвшөөрлийн мэдээлэл зэрэг багтжээ. [Эдийн засгийн судалгааны хүрээлэнгээс](#) ОУИТБС-ын мэдээлэлд тулгуурлан эрдэс баялгийн бүтээгдэхүүний зах зээлийн [судалгаа](#), уул уурхайн салбараас өрхийн орлогод үзүүлэх нөлөөллийн [судалгаа](#) болон нүүрс олборлогч компаниудын төлж буй АМНАТ-ын судалгаа зэргийг хийжээ. Мөн ОУИТБС-ын мэдээллийг орон нутгийн (аймаг, сумын) [сонин](#), [хэвлэл мэдээлэл](#) ашиглаж байна. Эрэн сурвалжлах сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагууд уул уурхайн салбартай холбоотой эрэн сурвалжлах олон ажилд хамтран ажиллаж, төрийн байгууллагын ажиллуулж буй худалдан авалт болон хууль ёсны эзэмшлийг харуулсан төрөл бүрийн мэдээллийн сантай харьцуулан ашигласны тоонд Хөгжлийн банкны чанаргүй зээлтэй холбоотой үүссэн [асуудал](#) багтжээ. Олон улсын хэмжээнд академик судалгаанд ОУИТБС-ын мэдээллийг (жишээ нь [байгаль орчинд нөлөөлөх байдлын талаарх судалгаа](#)) судлаачид, олон улсын хэвлэл мэдээлэл болон [ОУВС](#), [НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр](#), [Нээлттэй засгийн түншлэл](#) зэрэг олон улсын байгууллагууд ашиглаж байна. Монголын болон олон улсын иргэний нийгэм ОУИТБС-ын мэдээллийг өөрийн олон улсын нөлөөллийн үйл ажиллагаанд, жишээ нь Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаарх өөрийн иргэний нийгмийн [тайланд](#) ашиглажээ. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс олборлох үйлдвэрлэлийн мэдээлэл нээлттэй, үүнийг ТББ-ууд болон мэргэжлийн холбоод дүн шинжилгээ, нөлөөллийн үйл ажиллагаанд байнга ашигладаг хэмээн тайлбарласан.

ОУИТБС-ын өгөгдөл мэдээлэл нь олон нийтийн хэлэлцүүлэгт хөтлөн хүргэж байсан гэх зарим баримт нотолгоо буй ч Монгол улсын хэвлэл мэдээллээр олборлох салбарын төслүүдийн талаар мэдээллийн бусад эх үүсвэрт үндэслэн явагдаж буй өдөр тутмын олон нийтийн хэлэлцүүлэгтэй харьцуулбал хязгаарлагдмал байна. Монголын ОУИТБС-ын зүгээс хэлэлцүүлэг өрнүүлээгүй олон нийтийн хэлэлцүүлгийн томоохон сэдвүүд буйн тоонд Оюу Толгой төслийн хоёр дугаар шаттай холбоотой гэрээ хэлцэл эсвэл Эрдэнэс Монголын гаргасан бондын асуудал зэрэг сэдвүүд багтана. Баталгаажуулалтын ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч талын төлөөллийн зүгээс ОУИТБС-ын өгөгдөл мэдээлэл нь Улаанбаатар хотод үндэсний хэмжээний томоохон хэлэлцүүлэг өрнүүлээгүй хэмээн үзсэн ч мөн л ихэнх нь орон нутгийн зөвлөл, ОУИТБС-ын мэдээлэл түгээх арга хэмжээг зөвлөлдөх арга хэмжээ, хэлэлцүүлгийн форум хэмээн чухалчлан цохон дурдсан. Олон улсын Ажлын албаны зүгээс Монголын ОУИТБС-ын мэдээллийн ашиглалт нэмэгдэж буй ч олон нийтийн хэлэлцүүлэг, бодлого боловсруулахад ашиглах байдал нь өнөөг хүртэл хязгаартай байна. Ярилцлагад хамруулсан ихэнх талын зүгээс ОУИТБС-ын мэдээллийн цаг хугацаанд нь шуурхай нийтэлж байхыг хүсэж буйг ОУИТБС-ын мэдээллийг төрийн зүгээс системтэй ил тод болгож буй байдлыг хамаарах жил дууссаны дараа жилийн эхний улирлын сүүлийн өдрөөс өмнө санхүүгийн мэдээллийг цуглуулж буй ОУИТБС-ын цахим тайлагналын портал дээр үндэслэн, тайлагналын сонголтот хандлагын хүрээнд биелүүлэх боломжтой. Ярилцлагад оролцсон иргэний нийгмийн талуудын зүгээс ОУИТБС-ын зүгээс зөвлөмж болгож буй чиглэлээр өгөгдөл

мэдээллийг ил тод болгохоор цар хүрээг өргөжүүлэх, жишээ нь сайн дурын нийгмийн зарцуулалт, байгаль орчны менежмент зэргийг хамруулахаар санал болгож байна. Засгийн газрын зүгээс Байгал орчны мэдээллийн төвөөр дамжуулан ([БОМТ](#)) байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон аудитын тайлангуудыг ил тод болгожээ. Монгол улс нь өөрийн жил тутамд ил тод мэдээлж буй өгөгдөл мэдээллийг ашиглан Засгийн газрын зүгээс үүл уурхайн компаниуд байгаль орчны үүргээ биелүүлж буй эсэхийг тусгасан шаардлагатай тайлангуудыг ил тод болгож буйд дүн шинжилгээ хийж байх шатанд хараахан шилжээгүй байна.

Олон улсын Ажлын албаны зүгээс энэхүү үзүүлэлтийн Үр дүн, үр нөлөө дээр нэмэлт 1 оноог санал болгож байна.

### 1.5 Олборлох үйлдвэрлэлийн бодлого, үйл ажиллагаа дах ОУИТБС-ын хамааралтай өөрчлөлт

Энэхүү үзүүлэлт нь ОУИТБС нь олборлох үйлдвэрлэлийн салбарын бодлого, үйл ажиллагаанд хийгдэж буй өөрчлөлтийг ОУИТБС нь хэр хэмжээнд мэдээллээр хангаж буйг судлан үздэг.

Баталгаажуулалтад хамаарах хугацаанд Монголын ОУИТБС нь бодлого боловсруулах болон шинэтгэлийн үйл явцад шаардлагатай мэдээлэл ханган өгч байсан зарим баримт нотолгоо байна. Талуудтай хийсэн ярилцлагаар КОВИД-19 цар тахал гарснаас хойш зөвхөн ОУИТБС-ын үндсэн чиг үүрэгт л төвлөрч ирсэн ч шинэтгэлд хандсан зөвлөмжүүд хомс байх нь үүнээс ч өмнөх асуудал байсан ба ялангуяа ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиг үүргийг 2018 онд Ерөнхий сайдын Ажлын албанаас УУХҮЯ-нд шилжүүлснээр энэ байдал улам даамжирсан байна. Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр өгсөн тайлбартаа КОВИД-19 цар тахлаас үүдсэн хэд хэдэн удаагийн хөл хорио нь биечлэн хуралдах боломжгүйд хүргэж, ОУИТБС-ын хэрэгжилт, цахим тайлагналын системд төвлөрөхөд нь сөрөг нөлөөлсөн гэж үзжээ. Үүнд үл хамаарах нэг зүйл нь эцсийн өмчлөгчийн ил тод байдал ба Монголын ОУИТБС нь энэ чиглэлийн үйл ажиллагааг манлайлан ажиллаж, хамаарах хууль журам боловсруулахад хувь нэмэр оруулж ирсэн ч өмчлөгчийг ил тод болгох босго хувь хэмжээ зэрэг асуудлаар байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулах шаардлага байсаар байна. Үүнээс үүдэн Монголын ОУИТБС-ын зүгээс олборлох салбарын болон төрийн бусад мэдээллийн сангаас өгөгдөл төвлөрүүлсэн нээлттэй мэдээллийн портал гаргасан ч энэ нь төрийн бусад байгууллаас салангид байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг (ОУИТБС-ын хууль хэмээн нэрлэж буй) 2014 оноос хойш боловсруулж байна. Энэхүү хуулийн төсөл нь Монголын ОУИТБС-ын цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тэргүүлэх зорилт болгон тусгагдаж, 2022 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөгджээ. ОУИТБС-ын зүгээс ихээхэн хувь нэмэр оруулан ажилласан энэхүү хуулийн төсөл нь ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох заалтыг багтаасан ба батлагдан хэрэгжих тохиолдолд мэдээллийн иж бүрдэл, цаг хугацаат байдалд ихээхэн нөлөөлөл үзүүлнэ. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс тус санаачилга нь олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглалын өөрчлөхөд шаардлагатай мэдээллээр хангаж буй ба жишээ нь УИХ дээр хийгдэж буй Эрдэс баялгийн бүтээгдэхүүний биржийн тухай болон Баялгийн сангийн тухай хуулийн төслүүдийн зөвлөлдөх арга хэмжээ, Уур уурхайн тухай хууль,

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулж буйг тусгайлан дурдсан байна.

Ажлын албаны зүгээс энэхүү үзүүлэлтийн Үр дүн, үр нөлөөн дээр нэмэлтээр 0.5 оноог санал болгож байна.

## 2. Үр дүн, үр нөлөө

Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлд хандах болон олон нийтийн хэлэлцүүлэгт хамаарах ОУИТБС-ын Шаардлага 7 болон 1.5 дээр үнэлгээ хийдэг.

### Шаардлага нэг бүрээр гарсан ахиц, засан залруулах арга хэмжээ

Шаардлага нэг бүрээр гарсан ахиц, засан залруулах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй үнэлгээг энэхүү тайлангийн хавсралт хэсэгт үнэлсэн мэдээлэл цуглуулах маягаас авч болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<b>Ажлын төлөвлөгөө (Шаардлага #1.5)</b> <i>Бүрэн биелсэн</i>	<p>Ажлын албаны зүгээс Шаардлага 1.5-ыг бүрэн ханган биелүүлсэн хэмээх дүгнэлтийг хийж байна. Ярилцлагад хамрагдсан Засгийн газар, салбарыг төлөөлсөн ихэнх төлөөллийн зүгээс Монголын ОУИТБС-ын жилийн Ажлын төлөвлөгөөний талаар ямар нэгэн тодорхой санал бодол илэрхийлээгүй. Харин иргэний нийгмийн зүгээс Ажлын төлөвлөгөөг боловсруулсан арга замын талаар асуудалтай буйг илэрхийлж, ОУИТБС-ын хэрэгжилтийн жилийн төлөвлөлт нь олборлох үйлдвэрлэлийн салбар дах үндэсний хэмжээний тэргүүлэх зорилтыг харгалзан үзээгүй хэмээн хариулж байв. Гэвч Ажлын албаны зүгээс ажлын төлөвлөгөөг боловсруулахад гарч буй сул талуудыг Ажлын хэсэг дээр бүтэн жилийн түршид төлөвлөгөөг эргэн хэлэлцэж буйгаар зөвтгөж болох ба ийнхүү хэлэлцэж, эргэн харж буй нь ОУИТБС-ын жилийн төлөвлөгөөний үндсэн зорилтуудыг хангаж байна хэмээн үзэж болно.</p> <p>Монгол улс нь ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөг жилийн түршид шинэчлэн сайжруулж, тухайн төлөвлөгөөний хүрээнд мэдээллийг системтэйгээр ОУИТБС-ын <a href="#">вэбсайт</a> дээр ил тод болгож байна. Шаардлага 1.5-д хамаарах ихэнх хэсгийг 2018- 2022 оны хугацаанд жилийн төлөвлөгөөнд тусгаж ирсэн ч төлөвлөгөөний зорилтууд, төлөвлөгөөг боловсруулахад өргөн хүрээнд зөвлөлдөж байх, үйл ажиллагааны шаардлагатай зардлыг тусган хуваарилж байх, төлөвлөсөн бүхий л үр дүн нь хэмжигдэхүйц байх зэрэг шаардлагын хувьд дутагдалтай байна. Монголын ОУИТБС-ын <a href="#">2022 оны ажлын төлөвлөгөө</a> нь 6 зорилго, 21 зорилтыг дэвшүүлсэн ч үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлтэй уялгүйгээр 2021 оны олон үйл ажиллагааг давтан оруулж, зөвхөн үйл явц болон ОУИТБС-ын хэрэгжилтэд явцуу төвлөрчээ. Гэвч ажлын төлөвлөгөөнд хоёр дугаар зорилтын хүрээнд төрийн байгууллагууд болон</p>

	<p>ТӨК-иудын мэдээллийг системтэйгээр ил тод болгох, үүнд кадастрын порталыг сайжруулах, гэрээний ил тод байдлын порталыг шинэчлэх, бүх ТӨК-удын жилийн тайланг байнга нийтэлж байх зэрэг үйл ажиллагаа багтжээ. Түүнчлэн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан авлигын эсрэг ажил нь олборлох үйлдвэрлэлийн салбарын чиглэлээрх үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлд хамааралтай байна. Энэ нь тухайн ажлын төлөвлөгөө нь олборлох салбарын чиглэлээрх үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлтэй нягт уялдах боломжийг хангажээ.</p> <p>Ажлын төлөвлөгөөг 2021 оны 11 дүгээр сард Ажлын хэсэг дээр хэлэлцэж, 2021 оны 12 дугаар сард Үндэсний зөвлөл эцэслэн баталжээ. Харин талуудтай хийсэн ярилцлага болон баталгаажуулалтад зориулсан “Оролцогч талуудын оролцоо” хэмээх маягтаар ирүүлсэн мэдээлэл дээр ажлын төлөвлөгөөний төслийг Ажлын хэсгийн гишүүдэд 11 дүгээр сарын хурал болохоос нэг хоногийн өмнө тараасан нь гишүүд хоорондоо болон бусад төлөөлж буй сонгогч талуудтайгаа зөвлөлдөх боломжийг хаажээ. Хэд хэдэн оролцогч талын зүгээс КОВИД-19 цар тахлын улмаас ОУИТБС-ын Ажлын алба нь төслийн урьдчилан түгээхэд сорилт тулгарсан хэмээн үзжээ. Үнэлгээний төсөл дээр үүнтэй холбоотой ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба 2020- 2021 онд КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хэд хэдэн удаагийн хөл хорио нь ОУИТБС-ын хэрэгжилт болон нийт эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллийг цохон дурдсан байна. Гэсэн ч бусад талуудын зүгээс жилийн төлөвлөгөөний төслийг судлах, боловсруулах, зөвлөлдөхөд хангалттай хугацаа гарган өгдөггүй энэхүү байдал нь цар тахлаас ч өмнө тохиолдож, 2018 оноос хойш иргэний нийгмийн хувьд хүндхэн сорилтуудыг учруулж байсныг дурдсан. Ямартаа ч Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлүүд, жилийн тайлан зэргээс үзэхэд Ажлын хэсэг дээр жилийн төлөвлөгөөг байнга хэлэлцэж, эргэн харж ирсэн нь Ажлын хэсэг төлөвлөгөөг шаардлагатай үед нь шинэчлэх боломжоор хангаж иржээ.</p> <p>Ажлын төлөвлөгөөнд тусгасан бүхий л үйл ажиллагаанд хамаарах (сараар) хугацааг нь заан өгсөн ч үйл ажиллагаа нэг бүр нь хэмжигдэхүйц үр үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүнтэй холбогдоогүй. Гэхдээ төлөвлөгөө нь чадавх, системтэйгээр ил тод болгох замаар ОУИТБС-ын хамрах хүрээг өргөтгөх, ОУИТБС-ын тайлан болон Баталгаажуулалтын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээрх асуудалд анхаарч ирсэн ч Баталгаажуулалтаас өгсөн зөвлөмжүүд дээр зөвхөн ерөнхий байдлаар хандаж иржээ. Мөн гэрээний болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлын чиглэлийн үйл ажиллагаа төлөвлөгөөнд багтжээ. Ажлын төлөвлөгөө нь ОУИТБС-ын тайлагнал дээр “уян хатан” хандлага баримтлахтай хамаарах үйл ажиллагааг багтаасан ч ирээдүйг харсан ОУИТБС-ын мэдээлэл ил тод болгох чиглэлийн оруулаагүй ажээ. Ажлын төлөвлөгөө нь санхүүжилтийн эх эх үүсвэр, хөгжлийн түншлэгч байгууллагуудын техникийн туслалцааг багтаасан ч төлөвлөсөн үйл ажиллагаа нэг бүр дээр төсөв хуваарилаагүй, ялангуяа УУХҮЯ-ны санхүүжилт бүхий үйл ажиллагаанд төсөв зардлыг нь тусгаагүй. Олон улсын Ажлын албаны зүгээс энэхүү Шаардлага 1.5-д хамаарах цар хүрээг үндсэндээ болон бүрэн ханган биелүүлсэн хэмжээн үзэж байна. Тиймээс Шаардлага 1.5 дээр хамаарах техникийн ихэнх үзүүлэлтийг хангасан, харин бодит байдал дээр</p>
--	--

	<p>бага зэрэг хийдлийг шийдсэн харагдаж байна. Монголын ОУИТБС-ын Ажлын албанаас Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр өгсөн тайлбартаа энэхүү Баталгаажуулалтаас өгсөн зөвлөмжүүдийг Монголын ОУИТБС-ын 2022-2023 оны Ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх тухай дурдсан.</p>
<p><b>Олон нийтийн хэлэлцүүлэг (Шаардлага #7.1)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Ажлын албаны зүгээс Шаардлага 7.1-ийн ихэнх хэсэг нь биелэгдсэн хэмээн үнэлж байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх талуудын зүгээс ОУИТБС-ын өгөгдөл, мэдээллийг гол оролцогч талуудад ил тод болгох замаар олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглалын асуудлаар нотолгоонд суурилсан хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг үндсэндээ хангаж байна хэмээн үзжээ. Бүхий л оролцогч талын зүгээс ОУИТБС-ын мэдээлэл түгээх үйл ажиллагаанд төр болон салбарын оролцоог бэхжүүлэх шаардлагатайг дурдсан. Иргэний нийгмийн зүгээс олборлох үйлдвэрлэлийн өгөгдөл мэдээлэл дээр түшиглэн олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх чиглэлээр санаачилгатай байх хэрэгцээг цохон дурдсаны зэрэгцээ нөгөө хоёр талын зүгээс өгөгдөл мэдээлэл түгээх ажилд түлхүү оролцож байхыг хүсэж байв. Монголын ОУИТБС нь өөрийн мэдээлэл харилцааны үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд шүүмжлэлтэй хандаж, улмаар өөрийн жил тутмын <a href="#">тайлан</a> дээр ОУИТБС-ын мэдээллийг уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй сум, нутгийн иргэдэд түгээж байх хэрэгцээний талаар тэмдэглэж байжээ. Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр иргэний нийгмийн оролцогч талын зүгээс ирүүлсэн тайлбартаа Шаардлага 7.1 дээр өгсөн урьдчилсан үнэлгээг “хэсэгчлэн хангасан” хэмээн дүгнэх нь зүйтэй хэмээн үзсэн ч үүний үндэслэлийн хувьд олборлох үйлдвэрлэлийн засаглал дах иргэдийн оролцоонд хамаарах Үр дүнтэй, тогтвортой байдлын 3 дугаар үзүүлэлтэд хамаарах тайлбар ирүүлсэн. Иргэний нийгмийн зүгээс илэрхийлж буй үзэл бодол, байгалийн баялгийн засаглалын асуудлаар олон нийтийн хэлэлцүүлгийн орон зайг иргэний нийгэм л дангаар бий болгох буй зэргийг харгалзахын зэрэгцээ Олон улсын Ажлын албаны зүгээс ОУИТБС-ын үйл явц дахь Засгийн газар, компанийн оролцоог үнэлэн үзэж, Засгийн газар, компанийн оролцоонд тодорхой сул талууд бий ч (<i>Шаардлага 1.1 болон 1.2 дээр үзнэ үү</i>) энэхүү зорилтын ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээн үзэж байна.</p> <p>Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг нь өөрийн гаргаж буй ОУИТБС-ын тайлан нь иж бүрэн байж, идэвхтэй түгээн сурталчилж, олон нийтэд нээлттэй байлгах чиглэлээр арга хэмжээ авч ирсэн. Цахим тайлангийн платформуор дамжуулан цуглуулсан мэдээлэл, ОУИТБС-ын тайлангийн мэдээллээс бүрдэх Монголын ОУИТБС-ын <a href="#">мэдээллийн портал</a> нь өгөгдлийн тойм, нээлттэй форматаар татан авах өгөгдөл болон өгөгдлийг дүрсжүүлэн ОУИТБС-ын өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг ихээр нэмэгдүүлжээ. Гэсэн хэдий ч өөр өөр талуудыг төлөөлсөн хэд хэдэн оролцогч талын зүгээс ОУИТБС-ын мэдээллийн тоймын хэвлэн нийтлэх, өгөгдлийн энгийн, хялбар ойлгогдохуйц байдлаар түгээх чиглэлээр илүү их хүчин чармайлт гаргах шаардлагатайг дурдсан. Монголын ОУИТБС нь өөрийн вэбсайтыг байнга шинэчилж, <a href="#">Фейсбүүк</a> болон <a href="#">Твиттер</a> хуудсаар мэдээллийг идэвхтэй түгээж байна. Ажлын алба нь төрөл бүрийн, шинэлэг мэдээлэл харилцааны бүтээгдэхүүнийг хөгжүүлсний тоонд инфографик (<a href="#">энд</a>, <a href="#">энд</a>, <a href="#">энд</a> болон <a href="#">энд</a> үзнэ үү), анимац багтжээ. Монгол улс нь 2019- 2021 оны хугацаанд харьцангуй бага төсөвтэй байсан ч ОУИТБС-тай</p>

	<p>хамаарах мэдээлэл харилцаа, мэдээлэл түгээх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хийсэн. 2020 оноос хойш Монголын ОУИТБС нь Олон улсын санхүүгийн корпорац (IFC), Нээлттэй нийгэм форумтай мэдээлэл түгээх, харилцаа холбооны үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхэд хамтран ажилласан ба үүнд бүсийн хурал зохион байгуулах, орон нутгийн дэд зөвлөлүүдийн чадавх сайжруулах, дата хакатон, сургагч багш бэлтгэх сургалт зэрэг багтжээ. Энэ нь 2020 оноос хойш Монголын ОУИТБС-ын мэдээллийн хэрэгцээ, хүртээмжийн асуудлуудад илүү хүртээмжтэй арга хандлагуудыг баримтлах боломж нээжээ. Монголын ОУИТБС-д Дэлхийн Банкны зүгээс 2022- 2023 үзүүлэх дэмжлэгийн томоохон хэсэг нь системтэйгээр мэдээлэл ил тод болгох, олон нийтэд мэдээлэл хүргэх замаар хэлэлцүүлэх өрнүүлэх чиглэлд зориулагдана.</p> <p>Монголын ОУИТБС нь уламжлалын хувьд орон нутагт хүрч ажиллаж, мэдээлэл түгээхэд төвлөрч ирсэн ба үүний үр дүнд Засгийн газрын 2012 оны 22 дугаар тогтоолоор ОУИТБС-ын дэд зөвлөлийг 21 аймаг, уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй 13 суманд байгуулсан. Эдгээр дэд зөвлөл нь тухайн орон нутагт хамаарах ОУИТБС-ын мэдээллийг түгээх, олборлох салбарын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулахад үндсэндээ ажиллаж ирсэн. Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь цар тахлаас хойш мэдээлэл түгээх үйл ажиллагаагаа онлайн хэлбэрт шилжүүлж, хоёр сар тутамд дэд зөвлөлүүдтэй төрөл бүрийн сэдвээр, жишээ нь Ашигт малтмалын хуульд оруулах нэмэлт өөрчлөлт, тусгай зөвшөөрөл олгох журам зэрэг асуудлаар хуралдаж байжээ. Эдгээр хурал/ зөвлөлдөх арга хэмжээнд ойролцоогоор 50- 70 оролцогч оролцсон нь нутгийн захиргаа, иргэний нийгмийн төлөөлөл байж, орон нутгийн түвшин дэх оролцогч талуудын зүгээс шинэтгэл хийх бодит зөвлөмжүүдийг гарган ирсэн. Зарим аймгууд ОУИТБС-ын мэдээллээс хамаарах хэсгийг тоймлон өөрийн вэбсайт дээр байршуулж эхэлсний жишээнд <a href="#">Завхан аймаг</a> багтжээ. Баталгаажуулалтын ярилцлагад оролцсон талуудын зүгээс ОУИТБС болон орон нутаг хоорондын үйл ажиллагааны уялдааг хангахад дэд зөвлөлүүдтэй хийсэн онлайн зөвлөгөөн нь үр дүнтэй байсан гэж үзсэн бол иргэний нийгмийн зарим төлөөллийн зүгээс онлайн зөвлөгөө нь харилцаа болон бодит байдлын хувьд дутагдалтай гэж үзжээ. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн зарим төлөөллийн зүгээс 2021 оны “Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах” жилээр зарласнаас бусдаар орон нутагт хүрч ажиллаж буй түвшинд сэтгэл ханамжгүй байдгаа илэрхийлж байв. Монголын ОУИТБС нь 2021 онд орон нутгийн захиргааны дунд ил тод байдлын үрэлдээн зарласан. Олон улсын Ажлын албаны зүгээс Монголын ОУИТБС-ын Ажлын алба болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс 2020- 2021 онд 7 удаагийн хөл хорио тогтоосон КОВИД-19 цар тахлын үед орон нутагт хүрч ажиллах ажлыг онлайн хэлбэрт шилжүүлж, идэвхтэй ажилласныг цохон тэмдэглэж буйн зэрэгцээ энэ талаар иргэний нийгмийн зүгээс бүхмдалтай буйг ойлгож байна. Үнэлгээний төсөл дээр үүнтэй холбоотой ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба 2020-2021 онд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хэд хэдэн удаагийн хөл хорио нь ОУИТБС-ын хэрэгжилт болон нийт эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллийг цохон дурджээ. Цаашид нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцүүлсэн мэдээллийг бэлтгэн гаргахаар төлөвлөж байна.</p>
--	--



	<p>Ийнхүү орон нутагт хүрч ажиллахын зэрэгцээ ОУИТБС-ын Ажлын алба нь компаниуд, сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагууд, бусад зорилтот бүлэгт зориулсан чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Гэвч 2020 онд цар тахал гарснаас хойш бүхий л биечлэн хийгдэх сургалтуудыг хойшлуулж, ОУИТБС нь чадавх бэхжүүлэх үйл ажиллагаагаа онлайн хэлбэрт шилжүүлж, зөвхөн компаниуд, орон нутгийн захиргаанд ОУИТБС-ын тайлагналын техникийн асуудлаар л хийхээр цар хүрээг нь багасгажээ. Ярилцлагад хамруулсан иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс онлайн мэдээлэл харилцаа, орон нутагт хүрч ажиллах үйл ажиллагааг цар тахлын үеэр ийнхүү багасгасанд бухимдалтай буйгаа илэрхийлсэн.</p> <p>Талуудтай хийсэн ярилцлага, энэхүү Баталгаажуулалтад зориулан маягтаар ирүүлсэн мэдээлэл нь бусад хоёр оролцогч талаас илүүтэйгээр иргэний нийгмийн зүгээс ОУИТБС-ын мэдээллийн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлэх шинэлэг арга хэрэгсэл зэрэг өөрийн үйл ажиллагааны нотолгоог тусгасан. Иргэний нийгэм нь Монголын ОУИТБС-ын мэдээллийг ашиглах хамгийн шинэлэг арга замын гол манлайлагч байсан ба үүний жишээнд ББЗХ-ийн боловсруулсан авлигын эрсдэлийг үнэлэх <a href="#">аргачлал</a>, ННФ-ын нээсэн нээлттэй гэрээний <a href="#">портал</a> болон ОУИТБС-ын мэдээллийг ашигласан эцсийн өмчлөгчийн мэдээллийн <a href="#">портал</a> зэрэг багтаж байна. Иргэний нийгэм нь мөн олборлох үйлдвэрлэлийн засаглалын асуудлаар хамаарах бусад арга хэрэгслийг боловсруулсан ч эдгээр нь ОУИТБС-ын хүрээнд бус байна. Эдгээрийн жишээнд олон нийтээс санал авах зориулалт бүхий <a href="#">miningwatch.mn</a> вэбсайт, ялангуяа Дорноговь аймгийн нутгийн иргэд, малчдаас уул уурхайн төсөл болон тэдний эрхийн талаарх мэдээлэл цуглуулах <a href="#">онлайн өргөдөл</a> зэрэг багтаж байна.</p> <p>ОУИТБС-ын үйл явцын хүрээнд бэлтгэгдэж буй өгөгдөл мэдээллийг дотоодын болон олон улсын оролцогч талууд ашиглаж буй баримт байна. Монголын ОУИТБС-ын тухай онлайн хэлбэрээр буй хэвлэл мэдээллээр гарсан мэдээ, нийтлэлийг судлан үзэхэд 2018- 2022 онд жил тутамд 5- 10 нийтлэл гарч буй ч үндэсний хэмжээний хэд хэдэн сонин мэдээллээ онлайн хэлбэрээр давхар нийтэлдэггүй тул дээрх нь бодит тооноос бага байх магадлалтай. Дотоодоо гэхэд ОУИТБС-ын багц өгөгдлийг хэвлэл мэдээлэл ихээр ашиглаж буйн жишээнд уул уурхайн компаниудын өгсөн <a href="#">хандив тусламж</a>, олборлох үйлдвэрлэлийн салбарын орлого болон <a href="#">Орон нутгийн хөгжлийн сан, эцсийн өмчлөгч, эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл</a>, томоохон татвар төлөгчдийн төлсөн татварын <a href="#">хугацааны цувааны шинжилгээ</a>, ОУИТБС-ын тайлан <a href="#">гаргаагүй компаниудын</a> тусгай зөвшөөрлийн мэдээлэл зэрэг байна. Эдийн засгийн судалгааны хүрээлэнгээс ОУИТБС-ын мэдээлэлд тулгуурлан <a href="#">уул уурхайн салбараас өрхийн орлогод үзүүлэх нөлөөллийн</a> судалгааг хийжээ. Мөн ОУИТБС-ын мэдээллийг орон нутгийн (аймаг, сумын) <a href="#">сонингууд</a> ашиглаж байна. Олон улсын хэмжээнд академик судалгаанд ОУИТБС-ын мэдээллийг (жишээ нь <a href="#">байгаль орчны нөлөөллийн мэдээлэл</a>) судлаачид, олон улсын хэвлэл мэдээлэл болон <a href="#">ОУВС, НУББОХ, НЗТ</a> зэрэг олон улсын байгууллагууд ашиглаж байна. Олон улсын хэмжээнд ОУИТБС-ын тайланг мөн академик судалгааны байгууллага, хэвлэл мэдээлэл ашиглан өөрийн олон улсын нөлөөллийн үйл ажиллагааг хийж буйн тоонд Тогтвортой хөгжлийн зорилтын</p>
--	--

	<p>хэрэгжилтийн талаарх <a href="#">иргэний нийгмийн тайлан</a> багтжээ. Монголын ОУИТБС-ын Ажлын хэсэг болон Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүд нь мөн Нээлттэй засгийн түншлэл болон Олборлох үйлдвэрлэлийн нээлттэй хөтөлбөр зэрэг бусад хамаарах санаачилгуудад мөн хувь нэмэр оруулах ажиллаж байна.</p> <p>Олон улсын Ажлын албаны зүгээс Монголын ОУИТБС-ын зүгээс онлайн хэлэлцүүлэг хийх, орон нутагт хүрч ажиллах зэргээр цар тахлын нөлөөллийг бууруулах хүчин чармайлт гаргаж буйд талархалтай хандаж байна. Гэвч өнөөг хүртэл орон нутагт хүрч ажиллах үйл ажиллагаа нь цар тахлын үеэр болон өмнө нь ч салбарын болон төрийн өргөн хүрээний төлөөлөл буй харин ОУИТБС-ын Ажлын алба, иргэний нийгэм, УУХҮЯ-ны төлөөллийн хүрээнд явагдаж иржээ. ОУИТБС-ын өгөгдлийн багцыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглаж буйг харуулсан олон баримт буйн зэрэгцээ цаашид олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглалын асуудлаар нотолгоонд суурилсан олон нийтийн хэлэлцүүлгийг илүү зорилтот мэдээлэл харилцааны бүтээгдэхүүн, салбар болон төрийн өргөн хүрээний төлөөлөлтэй өрнүүлэх боломж боллоцоо байсаар байна. Монголын ОУИТБС-ын хувьд өөрийн өгөгдөл мэдээллийг олон нийтийн хэлэлцүүлэг, бодлого боловсруулахад зориулан ашиглахыг дэмжих, үүнд олборлох үйлдвэрлэлийн гэрээ хэлцэл хийх, ТӨК-иудын хяналтад шинэтгэл хийх, төрийн албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг болон бусад чиглэлд ашиглахыг дэмжих боломж нээлттэй байна.</p>
<p><b>Мэдээллийн хүртээмж, нээлттэй өгөгдөл (Шаардлага #7.2)</b></p> <p><i>Бүрэн биелсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 7.2 бүрэн биелэгдсэн хэмээн дүгнэж байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч талын зүгээс олборлох үйлдвэрлэлийн мэдээллийг өргөн хүрээнд ашиглах, дүн шинжилгээ хийж байх боломжийг хангах зорилт биелэгдсэн хэмээн үзэж буй ба хэд хэдэн судлаачийн зүгээс Монголын ОУИТБС-ын өгөгдлийг нээлттэй, харилцан ажиллах форматаар нийтэлж буйг өндрөөр үнэлж байв.</p> <p>Монголын ОУИТБС нь ОУИТБС-ын мэдээллийг нийтлэх, ашиглах болон дахин ашиглах <a href="#">нээлттэй өгөгдлийн бодлогоо</a> зөвшилцөн, ил тод хэвлэн нийтэлсэн байна. Монголын <a href="#">ОУИТБС-ын тайлангууд</a> нь pdf форматаар нийтлэгдсэн хэвээр, харин дагалдах <a href="#">хавсралтууд</a>, тойм мэдээллийн файлууд нь .xls формат дээр байна. Монголын ОУИТБС-ын <a href="#">өгөгдлийн портал</a> нь ОУИТБС-ын өгөгдлийг татан авах боломжийг өөрийн Нээлттэй өгөгдлийн бодлогын дагуу нээлттэй форматаар (.csv, .xls, .json) татан авах боломжийг хангаж байна. Ярилцлагад хамрагдсан оролцогч талын зүгээс ОУИТБС-ын өгөгдөл нь цаг хугацаандаа гардаг гэж үзсэн ч үүнийг илүү сайжруулах, компаниудын зүгээс цахим тайлангийн системээр дамжуулан дараа жилийн 3 дугаар сарын 31-нээс өмнө мэдээлэл ирүүлэнгүүт шүүд ил тод нийтэлж байх хүсэлтэй байна. Монголын ОУИТБС-ын тайлангийн Тойм мэдээллийн файл (SDF) нь цаг хугацаандаа бэлтгэгдэн гардаг ба 2020 оны тойм мэдээлэл нь энэхүү Баталгаажуулалт эхлэх хугацаанд эцэслэн бэлтгэгдэж байсан. Гэвч сүүлд гарсан ОУИТБС-ын тайлангийн хоёр хавсралт нь .xls форматаар гарч, тойм мэдээлэл хүлээгдэж байна. Энэхүү Баталгаажуулалтад зориулан Монголын ОУИТБС-ын зүгээс “Үр дүн, үр нөлөө” хэмээх маягтаар ирүүлсэн мэдээлэл нь нийт тайланг</p>



	<p>хэрэглэгчид ашиглах боломжийн талаар шүүмжлэлтэй хандаж, үүнийг ОУИТБС-ын өгөгдлийн хүртээмжид буй гол сорилт гэж үзжээ. Мөн тэрхүү маягтад мөн сэтгүүлчид зэрэг гол зорилтот бүлгүүдэд зориулсан чадавх хөгжүүлэх сургалтуудын хүртээмж сайжруулах гол арга зам хэмээн үзжээ. Гэвч энэ чиглэлийн арга хэмжээ нь КОВИД-19 цар тахлын үеэр ихээхэн удааширчээ.</p> <p>ОУИТБС-ын өгөгдлийг Засгийн газар болон ТӨК-иудын вэбсайт, порталуудаар өргөн хүрээнд системтэйгээр ил тод болгож буй ч нээлттэй мэдээллийн нийтээр нь бүхэлд нь татан авах боломж нь ялгаатай байна. Ийнхүү системтэйгээр ил тод болгож буй байдал нь олон янзаар жишээ нь АМГТГ-ын кадастрын <a href="#">портал</a> дээрх тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Монголын ОУИТБС-ын нээлттэй мэдээллийн <a href="#">портал</a>, нээлттэй гэрээний <a href="#">портал</a> дээрх иж бүрэн гэрээнүүд, Шилэн дансны <a href="#">портал</a> дээр буй ТӨК-иудын хийсэн гүйлгээний мэдээлэл, АМГТГ-ын сар тутмын <a href="#">тайлан мэдээ</a> дээрх эрдэс баялгийн үйлдвэрлэлийн мэдээлэл, ГЕГ-ын мэдээллийн <a href="#">портал</a> дээрх эрдэс баялгийн экспортын мэдээлэл, <a href="#">төсөв</a>, <a href="#">худалдан авалт</a> болон <a href="#">аудитын</a> үйл ажиллагааны мэдээлэл, болон Сангийн яамны <a href="#">портал</a> дээрх орон нутагт хуваарилж буй төсвийн мэдээлэл, Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээлэл зэрэг байна. Олборлох салбараас төрийн хүлээн авч буй татварын болон татварын бус орлого, компанийн төлбөрийн мэдээллийг Монголын ОУИТБС-ын <a href="#">цахим тайлангийн порталаар</a> цуглуулж, нээлттэй мэдээллийн порталаар дамжуулан ил тод болгож буй ч төрийн байгууллагууд болон ОУИТБС-ын портал хоорондын автоматаар мэдээлэл солилцох боломж бүрдээгүй байна. Үүний зэрэгцээ ОУИТБС-ын дата портал дээрх нээлттэй мэдээллийг бүхлээр нь татан авах боломжийн хувьд ялгаатай, үүнд татварын орлогын мэдээллийг нийтэд нь бус харин татвар төлөгч нэг бүрээр л татан авах боломжтой байна. Портал дээрх өгөгдлийг бүтнээр нь татан авах боломжийг сайжруулах боломж байна.</p> <p>Монгол улс нь Нээлттэй засгийн түншлэлийн (НЗТ) гишүүн орон бөгөөд нийт 4 удаагийн <a href="#">Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний</a> хүрээнд хэд хэдэн чиглэлээр мэдээллийн ил тод байдлыг хангах үүрэг амлалт авч хэрэгжүүлжээ. Засгийн газрын <a href="#">2018 оны Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ</a> нь тухайн үеийн нээлттэй өгөгдлийн статусын талаар үр дүнтэй тойм мэдээлэл гаргажээ. Үүнээс хойш шинээр байгуулагдсан <a href="#">Цахим хөгжил, харилцаа холбооны яамны</a> зүгээс өгөгдөл мэдээлэл болон төрийн үйлчилгээний <a href="#">портал</a> бүхий цахим засаглалын санаачилгыг (<a href="#">e-Mongolia</a>) эхлүүлжээ. Монголын ОУИТБС-ыг энэхүү өргөн хүрээнд ажиллаж буй цахим Монгол шинэчлэлтэй холбон үялдуулж, төр болон ОУИТБС-ын өгөгдөлд харилцан нэвтрэх, харилцан ажиллах боломжийг цаашид сайжруулах боломжтой.</p>
<p><b>ОУИТБС-ын хэрэгжилтээс гарч буй зөвлөмжүүд (Шаардлага #7.3)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 7.3-ын ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээн үзэж байна. Ярилцлагад хамруулсан оролцогч талуудын санал бодол нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үр дүнтэй механизм бүрдсэн эсэх дээр зөрүүтэй буй ба иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс ОУИТБС-ын үйл явцад Засгийн газрыг төлөөлж буй албан тушаалтнуудын зэрэглэл бүүрсаар буй нь Монголын ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл явцын үр дүнтэй байдлыг бүүруулсан хэмээн үзэж байв. Харин ярилцлагад хамрагдсан Засгийн газар болон компанийн төлөөллийн зүгээс мөн аль болох</p>

	<p>өндөр албан тушаалтан хамрагдан оролцох тусам хэрэгжилт улам сайжирна гэдэгтэй санал нийлж, ОУИТБС-ын зөвлөмжүүдийн хэрэгжилтийн хувьд өнөөгийн механизм хангалттай гэж үзсэн. Олон улсын Ажлын албаны хувьд Баталгаажуулалтад хамаарах хугацаанд ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх механизм суларч, өргөн хүрээний шинэтгэлтэй холбоотой зөвлөмжүүдийн хэрэгжилт удааширч, үүн дээр нэмээд ОУИТБС-д оролцох төрийн өндөр албан тушаалтны оролцоо буурч, Монголын ОУИТБС дээрх чадавхын асуудал мөн нэрмээс болж байна. Гэвч КОВИД-19 цар тахал нь мөн ОУИТБС-ын зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдалд сөргөөр нөлөөлж, энэ нь талуудын хяналтаас гадуурх хүчин зүйл байжээ. Тиймээс Олон улсын Ажлын албаны дүгнэлт нь ярилцлагад хамрагдсан олон талуудын үзэл бодолтой нийцэж, ОУИТБС-ын хэрэгжилтийн баталгаажуулах зорилтууд нь байнгын суралцах үйл явц байж, бодлого боловсруулах үйл явцад хувь нэмэр оруулах байдлаар ихэнх хэсэг нь ханган биелэгджээ. Үнэлгээний төсөл дээр ирүүлсэн тайлбартаа иргэний нийгмийн зүгээс Шаардлага 7.3 дээр өгсөн урьдчилсан үнэлгээг “хэсэгчлэн хангасан” болгож бууруулахыг хүссэн нь ОУИТБС-ын зүгээс өмнө өгсөн зөвлөмжүүдийн биелэлттэй холбоотой байна. Гэвч Олон улсын Ажлын албаны хувьд одоогоор ОУИТБС-ын тайлагналтай холбоотойгоор хязгаарлагдмал хэмжээнд ашиглаж буй ч ОУИТБС-ын өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх механизм бүрдэж бий болсон хэмээн үзэж байна.</p> <p>Монголын ОУИТБС-ын тайлангууд нь санаачилгын тайлагнал, салбарын өргөн хүрээний шинэтгэлийг тусгасан төрөл бүрийн чиглэлийн зөвлөмжүүдийг багтааж байдаг. Тиймээс 2020 оны ОУИТБС-ын тайлангаар өгсөн 4 зөвлөмжийн 2 нь олборлох үйлдвэрлэлийн салбарт тулгарч буй өргөн хүрээний сорилтуудыг хамарсан бол өмнөх тайлангаар өгсөн 9 зөвлөмжийн 4 нь салбарын илүү өргөн хүрээний асуудлыг хамарчээ. Гэвч Монголын ОУИТБС-ын хурлын тэмдэглэлүүдийг судлан үзэхэд Ажлын хэсэг нь талуудын зүгээс, ялангуяа иргэний нийгмийн зүгээс санаачилгын хэрэгжилтийг сайжруулах, орон нутгийн түвшинд хүрч ажиллах, мэдээлэл хүргэх зэрэг зөвлөмжүүдийг хэлэлцэж байжээ.</p> <p>ОУИТБС-ын тайлан болон Баталгаажуулалтаас гарсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх иж бүрэн механизм байгаа гэх баримт нотолгоо бага, зөвхөн Ажлын хэсэг тохиолдлын байдлаар хэлэлцэж, арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүргийг Ажлын албанд өгч буйгаар хязгаарлагдаж байна. Оролцогч талуудтай хийсэн ярилцлагаар ОУИТБС-ын гаргаж буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх механизм нь юуны өмнө Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл эдгээрийг хэлэлцэн, зөвшөөрөх, улмаар Монголын ОУИТБС-ын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах (жишээ нь 2018 болон 2019 оны ОУИТБС-ын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажил 2021 оны ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан), үүнийг Ажлын алба хэрэгжүүлэх дараалалтай явагдаж байна. Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2018- 2020 оны Ажлын төлөвлөгөөнд тусгагдсан, дараа дараагийн төлөвлөгөөний хүрээнд гарсан үр дүнг үнэлж ирснийг дурдсан.</p>
--	--

	<p>Монголын ОУИТБС-ын жил тутмын тайлангууд нь өмнөх тайлангийн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн талаарх тойм мэдээлэл тусгадаг ба мөн санаачилгаас 2018 болон 2019 оны ОУИТБС-ын тайланд туссан зөвлөмжүүдийн хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшлийг судлан бие даасан <a href="#">матриц</a> бэлтгэжээ. Санаачилгын жил тутмын ажлын тайлан нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээрх нэмэлт үйл ажиллагааг тусгаж буй ч эдгээр нь зөвлөмжүүдийн бодит хэрэгжилтийг бус харин үйл ажиллагааны ерөнхий тойм хэлбэртэй байна. Тиймээс ч хамгийн сүүлийн жилийн ажлын тайлангууд (2020 болон 2021) нь системтэйгээр ил тод болгох, орон нутагт төлж буй орлогын ил тод байдлыг хангах, ОУИТБС-ыг институцчилах зэрэг зөвлөмжүүдэд гарсан ахиц дэвшлийг тусган харуулсан.</p> <p>ОУИТБС-ын тайлагналыг сайжруулахтай холбоотой ихэнх зөвлөмж дээр тусгагдсан, мөн Монголын ОУИТБС-ын хурлуудын тэмдэглэл зэргээс үзвэл Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэг нь сургамжууд дээр арга хэмжээ авч, мэдээллийн хийдэл, зөрүүтэй байдлыг шалтгааныг олж тогтоох, судлах, шийдэх чиглэлд ажиллажээ. Эдгээр зөвлөмжүүд нь компани болон Засгийн газрын ил тод болгож буй мэдээллийн иж бүрэн байдлыг хангах болон ил тод болгож буй мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулахтай хамаарах ч 2020 оны Монголын ОУИТБС-ын тайлан дээр бүгд “Цаашид арга хэмжээ авах шаардлагатай” хэмээн тэмдэглэгджээ.</p> <p>Баримт нотолгооноос үзвэл Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлаа өргөн хүрээний шинэтгэлд, жишээ нь ТӨК-үүд өөрийн санхүүгийн тайланг олон нийт ил тод нийтэлж байх хуулийн хэрэгжилт зэрэг чиглэлд бус харин ОУИТБС-ын хэрэгжилтэд явцуу байдлаар төвлөрүүлэн эрэмбэлжээ. Тиймээс 2020 оны ОУИТБС-ын тайланд дурдсан 9 зөвлөмжийн зөвхөн гурав нь “хэрэгжсэн” эсвэл “хэрэгжиж буй” статустай байгаа ба эд бүгд ОУИТБС-ын жил тутмын тайлагналтай холбоотой, харин өргөн хүрээний шинэтгэлд хандсан зөвлөмжүүд, жишээ нь ТӨК-иудын ил тод байдал зэрэг зөвлөмж нь “Цаашид арга хэмжээ авах шаардлагатай” гэсэн нөхцөлтэй байна. “Хэрэгжсэн” хэмээх статус бүхий ОУИТБС-ын цорын ганц зөвлөмж нь Хараат бус аудитыг цаг тухайд нь томилон ажиллуулж байх зөвлөмж байна. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс ирүүлсэн тайлбартаа Хараат бус аудитыг сонгох үйл явцыг цаг тухайд нь хийж байх зөвлөмжийг 2021-2022 онд хэрэгжүүлсэн ба үүнийг бүрэн хэрэгжүүлэх ОУИТБС-ын зөвлөмж хэмээн дурджээ. Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 7.3 дээр хийсэн үнэлгээ нь хэсэгчлэн хангасан эсвэл ихэнх хэсгийг хангасан хэмээн үнэлгээний заагт байна хэмээн үзсэн. ОУИТБС-ын гаргасан зөвлөмжүүдийн ихэнх дээр бодит ахиц дутмаг буй нь санаа зовних асуудал тул Ажлын алба нь ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх механизм нь санаачилгын үйл явц дахь талуудын оролцооны хийдэл, ялангуяа төрийн оролцоо (<i>Шаардлага 1.1 дээр үзнэ үү</i>) тааруу буйгаас үүдэн суларсан, Ажлын хэсгийн зүгээс хэрэгжилтийн бүхий л хэсэгт хяналт тавих ажил (<i>Шаардлага 1.4 дээр үзнэ үү</i>) хангалтгүй буйгаас үүдэн сүл байна хэмээн үзсэн. КОВИД-19 цар тахал нь ОУИТБС-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх механизмыг сулруулж буй ч Монголын ОУИТБС-ын 2019 оны тайланд дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд сорилтууд тулгарч байсан зэргээс үзвэл энэхүү байдал нь цар тахлаас ч өмнө давтагдаж</p>
--	--

	байжээ. Тиймээс Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 7.3-д хамаарах ихэнх хэсгийг биелэгдсэн хэмээн дүгнэж байна.
<p><b>ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг судлан үзэх (Шаардлага #7.4)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны дүгнэлтээр Монгол улс нь Шаардлага 7.4-ийн ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээн үзэж байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч талын зүгээс хэрэгжилтэд олон нийтийн байнгын хяналт, үнэлгээ хийлгэж байх зорилт бүрэн хэрэгжсэн эсэх дээр ямар нэгэн санал бодол илэрхийлээгүй. Харин хөгжлийн түншлэгч байгууллагууд, төрийн албан тушаалтны зүгээс Монголын ОУИТБС-ын зүгээс өөрийн үйл ажиллагааг олон нийтэд байнга тайлагнадаг хэмээн цохон тэмдэглэсэн. Иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс Монголын ОУИТБС нь өнөөг хүртэл иж бүрэн нөлөөллийн үнэлгээ хийгээгүй, 15 жил хэрэгжүүлсэн ч энэ үнэлгээ хийгдээгүй хэмээн мэдээлсэн. Санаачилгын үр дүн, нөлөөлөлд саналаа өгөх хугацаа ийнхүү богино буй нь зөвхөн цар тахлаас хамаарсан бус, өмнө нь ийм байсныг дурдсан. Олон улсын Ажлын албаны зүгээс Монголын ОУИТБС-ын жил тутмын үр дүн, үр нөлөөг судлан үзэхэд олон талуудтай зөвлөлдөх чиглэлд буй энэхүү сул талыг Ажлын хэсэг дэх нэг төлөөллийн зүгээс шаардаж буй нөлөөллийн үнэлгээтэй холбон үзвэл мониторинг, үнэлгээ хийж байх зорилтын ихэнх хэсэг нь биелэгдсэн хэмээн үзэж байна.</p> <p>Монгол улс нь өөрийн жил тутмын ажлын тайланг вэбсайт дээрээ Баталгаажуулалтад хамаарах жил бүрийн эцэст нийтэлж ирсэн ба <a href="#">2018</a>, <a href="#">2019</a>, <a href="#">2020</a> болон <a href="#">2021</a> оны тайлангууд тавигджээ. Эдгээр жилийн тайлангууд нь ОУИТБС-ын үйл ажиллагааны тойм, ОУИТБС-ын өгсөн зөвлөмжүүдийн дагуу Ажлын хэсгийн авсан хариу арга хэмжээ, ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтуудыг хангасан талаарх үнэлгээ зэрэг Шаардлага 7.4а дээрх бүхий л сэдвийг хамарчээ. Тайлангууд нь ОУИТБС-ын шаардлагуудыг хангасан эсэх дээр шууд үнэлгээ өгөөгүйн зэрэгцээ тодорхой шаардлагуудыг хангах чиглэлд хийсэн үйл ажиллагаа, тодорхойлсон сул талуудыг дурджээ. Тайлан нь мөн ОУИТБС-ын үзүүлэх нөлөөллийг сайжруулах чиглэлээрх хүчин чармайлтыг тайлагнаж, ялангуяа ОУИТБС-ын үйл явцыг институцилах хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар түлхүү дурджээ. Тайлан нь мөн ОУИТБС-ын үр дүн, үр нөлөөг бэхжүүлэх чиглэлээрх арга хэмжээг заасны тоонд орон нутгийн ажлын байр, худалдан авалтаас эхлээд олборлох салбараас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, төлөөгүй татвар төлбөрийг олж тогтоох, авлигын эрсдэлийг илрүүлэх зэрэг багтжээ. Азийн Хөгжлийн Банк зэрэг хөгжлийн түнш байгууллагуудад зориулсан Монголын ОУИТБС-ын улирлын тайлангууд нь санаачилгын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг багтааж байна. Жилийн ажлын тайлангуудад ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй саад тотгорын дурдсаны тоонд санхүүгийн нөөц эх үүсвэрийн боломж, орон нутагт мэдээлэл түгээх үйл ажиллагааг гүнзгийрүүлэх зэргийг тусгасан. Гэвч иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс энэхүү санаачилга 15 жил хэрэгжсэн ч иргэний нийгмийн зүгээс дэвшүүлж буй 15 жилийн хугацааны үр дүн, нөлөөлөлтэй хамаарах асуудал, сул талуудыг хамруулан нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн. Тэдний зүгээс нөлөөллийн үнэлгээ хийхийг иргэний нийгэм олон удаа шаардсан ч Ажлын хэсгийн зүгээс КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал сайжиртал хойшлуулаад буйг дурдсан.</p>

	<p>Жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэн гаргах үйл явц нь хамаарах өргөн хэмжээний талуудтай зөвхөн хязгаарлагдмал хэмжээнд зөвлөлдөх арга хэмжээ явуулж байна. Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь тайлангийн төслийг 4 дүгээр улиралд багтаан бэлтгэж, тус төслийн Ажлын хэсэг 11 дүгээр сард хэлэлцэж, улмаар Үндэсний зөвлөл нь 12 дугаар сарын хурлаараа эцэслэн баталж байна. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн төлөөллийн зүгээс жилийн ажлын тайланг боловсруулах үйл явцад сэтгэл хангалуун буй байгааг илэрхийлж, 2021 оны тайлангийн төслийг Ажлын хэсгийн гишүүдэд хурлаас нэг хоногийн өмнө л тараасан нь өөрийн хамаарах талуудтай зөвлөлдөх, санал авах хангалттай хугацаа олгоогүй хэмээн үзсэн. Тэдний зүгээс ажлын төлөвлөгөөний төслийг мөн цар тахлын үеэр батлагдахаас өмнөхөн хүргүүлсэн хэмээн хэлж буй бөгөөд энэхүү хандлага нь 2020 оноос ч өмнө хадгалагдаж байсан хэмээн хэлж байв. Иргэний нийгмийн зүгээс ОУИТБС-ын баримт бичгүүдийг тараах, хүргүүлэх цаг хугацааны хувьд (<i>Шаардлага 1.4 дээр үзнэ үү</i>) ихээхэн сэтгэл дундуур буйгаа илэрхийлж буй бол нөгөө талаар Засгийн газрын төлөөллийн зүгээс ийнхүү саатсан нь КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс үүдсэн хэмээн үзжээ. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд өгсөн тайлбартаа иргэний нийгмийн оролцогч талууд Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн түвшинд ОУИТБС-ын тайлагнал, эрх зүйн шинэчлэлийн үр дүн, засаглалын үнэлгээг хийх, хэлэлцэж байхыг санал болгосон. Иргэний нийгмийн гаргасан санал нь мөн ОУИТБС-ын хэрэгжилтийн үр дүн, нөлөөлөлд жил тутамд үнэлгээ хийж, илүү олон талуудыг хамруулан оролцуулахад анхаарах нь зүйтэйг дурдсан.</p>
<p><b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• Санаачилгын хэрэгжилтийг улам бэхжүүлэхийн тулд Монгол улс нь өөрийн ажлын төлөвлөгөөнд заасан буй зорилтуудыг байнга эргэн харж, эдгээр зорилтууд нь ОУИТБС-ын Зарчмууд, стратегийн тэргүүлэх чиглэлүүд болон үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлд нийцэж буй эсэхийг шалган баталгаажуулж байх шаардлагатай. ОУИТБС-д оролцож буй талууд нь жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад зөвхөн ОУИТБС-ын хэрэгжилтэд шууд оролцдог ч бус илүү өргөн хүрээнд өөрийнхөө төлөөлж буй гол талуудтай зөвлөлдөх арга хэмжээг авч хэрэгжүүлж байх шаардлагатай. Санаачилгын хэрэгжилтийг бэхжүүлэхийн тулд Монгол улс нь байгалийн баялгийн засаглалын асуудлаарх олон нийтийн хэлэлцүүлгийг мэдээллээр хангах шинэлэг арга хандлагыг эрэлхийлж, олон нийт, төр болон бизнесийн үйл хэрэгт ил тод байдлын өндөр стандартыг хангаж байх нь зүйтэй. Монгол улс нь мөн мониторингийн хүрээлэлд ажлын төлөвлөгөөгөө холбон өгөх нь зүйтэй байна.</li> <li>• Шаардлага 7.1-ийн дагуу Монгол улс нь бүхий л гурван талын төлөөлөл, тэр дундаа Засгийн газар болон компаниудын төлөөлөл нь ОУИТБС-ын хүрээнд ил тод болсон мэдээлэлд үндэслэн, нийгмийн хариуцлагаа ухамсарлан нийтэд мэдээлэл түгээх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох замаар мэдлэг түгээх, олборлох үйлдвэрлэлийн засаглалын талаарх хэлэлцүүлэг өрнүүлэх чиглэлээр оролцож байхыг баталгаажуулах шаардлагатай байна. Санаачилгын хэрэгжилтийг улам бэхжүүлэхийн тулд Монгол улс нь чадавч бэхжүүлэх үйл ажиллагааг, ялангуяа иргэний нийгэмтэй хамтран, иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан тайланд тусгагдсан өгөгдөл мэдээллийг иргэд, хэвлэл мэдээлэл болон бусад талууд ойлгох, онлайн хэлбэрээр ил тод болгох, ашиглахыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай. Ажлын хэсэг нь ОУИТБС-ын мэдээлэл нь олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглалын талаарх үндэсний болон орон</li> </ul>	

<p>нутгийн түвшний хэлэлцүүлгийг мэдээллээр ханган байхыг баталгаажуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санаачилгын хэрэгжилтийн улам бэхжүүлэн сайжруулахын тулд Монгол улс нь Монголын ОУИТБС болон хамаарах төрийн байгууллага, компаниуд хоорондын хамтын ажиллагааг дэмжин, тухайн талуудын зүгээс системтэйгээр ил тод болгож буй өгөгдөл мэдээллийг машинд уншигдахуйц, харилцан нийцэж ажиллах боломжтой болгох, ОУИТБС-ын болон бусад өгөгдөл мэдээллийг кодлон тухайн мэдээллийг олон нийтэд нээлттэй бусад өгөгдөл мэдээлэлтэй харьцуулах боломжийг хангах нь зүйтэй.</li> <li>• Шаардлага 7.3 дээр заасны дагуу Монгол улс нь ОУИТБС-ын хэрэгжилтээс гарч буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, байгалийн баялгийн засаглалд ОУИТБС-ын хэрэгжилтийн үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх иж бүрэн механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.</li> <li>• Шаардлага 7.4 дээр заасны дагуу Монгол улс нь ОУИТБС-ын хэрэгжилтийн үзүүлж буй үр нөлөөнд жил тутамд үнэлгээ өгч, баримтжуулж, үүнийг олон нийтэд нээлттэй баримт бичиг болгох шаардлагатай. ОУИТБС-ын оролцогч иргэний нийгмийн бүлгүүд, салбар нь, ялангуяа төлөөлөл нь Үндэсний зөвлөлд ажиллаж буй талууд мөн ОУИТБС-ын үйл явцын талаар саналаа өгч, энэхүү саналыг нь үр дүн, үр нөлөөний жил тутмын үнэлгээнд тусгаж байх шаардлагатай. Үр дүн, үр нөлөөнд хийх жил тутмын үнэлгээнд байгалийн баялгийн засаглалд ОУИТБС-ын үзүүлэх нөлөөллийг сайжруулах, үүнд ОУИТБС-ын тайлагналын дэлгэрэнгүй байдал, цар хүрээг өргөжүүлэх, талуудын оролцоог нэмэгдүүлэх зэргийг багтаах нь зүйтэй. Санаачилгын хэрэгжилтийг бэхжүүлэхийн тулд Монгол улс нь сүүлийн 15 жилийн хугацаанд ОУИТБС-ын үзүүлсэн нөлөөллийн үнэлгээг тусгайлан хийх нь зүйтэй бөгөөд үүний ОУИТБС-ын үйл явцад оролцож буй иргэний нийгмийн төлөөллийн зүгээс дэмжиж буй юм.</li> </ul>
--

### 3. Талуудын оролцоо

Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь ОУИТБС-ын үйл явц дахь талуудын оролцоо болон олон талуудын хяналтад хамаарах Шаардлага 1.1- 1.4-ийг үнэлдэг.

#### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Төрийн оролцоо (Шаардлага #1.1)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Ажлын албаны үнэлгээгээр Шаардлага 1.1-д хамаарах ихэнх хэсэг нь биелэгдсэн хэмээн үзэж байна. Салбар болон засгийн газрыг төлөөлсөн хэд хэдэн оролцогч талын зүгээс УУХҮЯ-ны зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтэд үйл ажиллагааны түвшний оролцоог хангаж ирсэн ч тухайн хамаарах хугацаанд Засгийн газрыг төлөөлсөн нийт оролцогчид нь иж бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцоотой байгаагүйг дурдсан. Бүхий л талыг төлөөлсөн хэд хэдэн гишүүдийн зүгээс Засгийн газрын оролцоо ийнхүү буурч буй нь зарим талаар</p>



	<p>ОУИТБС-ыг 2018 оны 11 дүгээр сард Ерөнхий сайдын Ажлын албанаас УУХҮЯ-нд шилжүүлсэнтэй холбон тайлбарлаж байна. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн төлөөллийн зүгээс Засгийн газар нь өндөр түвшний улс төрийн манлайлал үзүүлсэн, ОУИТБС-ын хэрэгжилтэд шаардлагатай үйл ажиллагааны түвшний оролцоог хангасан хэмээн огт үзэхгүй байна.</p> <p>Баталгаажуулалтын хамрах хугацаанд төрийн өндөр албан тушаалтнуудын зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтийн дэмжин мэдэгдэл хийсэн баримт нотолгоо бага байна. Хамгийн сүүлд олон нийтэд хандан хийсэн мэдэгдэл нь өмнө хийгдсэн Баталгаажуулалтын хүрээнд буюу Засгийн газрын 2017 оны <a href="#">263</a> болон <a href="#">308</a> дугаар тогтоолд хамаарч байна. <a href="#">2019 оны 4 дүгээр сард ResourceContracts.mn</a> хэмээх гэрээний порталын албан ёсны нээлт дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав Засгийн газрын зүгээс энэ салбарт хийгдсэн гэрээ хэлэлцээрийг ил тод болгох эрмэлзэлтэй буй талаар дурджээ. 2021 онд “Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь” хөтөлбөрт нэгдэн орох хүсэлтээ илэрхийлэн Олон улсын Ажлын албанд илгээсэн захидалдаа УУХҮЯ-ны ТНБД Г.Нандинжаргал мөн ОУИТБС-ын хэрэгжилтийг хангах хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн ч энэхүү баримт бичиг олон нийтэд нээлттэй болоогүй. Засгийн газрын <a href="#">289</a> дүгээр тогтоолоор ОУИТБС-ыг хариуцах чиг үүргийг Ерөнхий сайдын Ажлын албанаас 2018 оны 9 дүгээр сард УУХҮЯ-нд шилжүүлжээ. Үүний нөлөөгөөр ОУИТБС-ын үйл ажиллагааг удирдан манлайлах үүрэг Ерөнхий сайдаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад шилжсэн байна. Энэхүү удирдан манлайлах чиг үүргийг хүлээн авсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон энэхүү албан тушаалд 2020 оны 6 дугаар сараас хойш хуучин сайд Д.Сумьяабазар нь 2017 оны 10 дугаар сараас хойш ажилласан. Сайд Г.Ёндон ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг даргалдаг бол Ажлын хэсгийг ТНБД Г.Нандинжаргал ахалж байна. Сайд болон ТНБД нар хамаарах хурлуудад оролцож, сайд Г.Ёндон Үндэсний зөвлөлийн хоёр удаагийн (2020 болон 2021 оны 12 дугаар сар) хуралд, ТНБД Г.Нандинжаргал Ажлын хэсгийн найман удаагийн хуралд (2021 оны 5 хурал үүнд багтсан) оролцжээ. Бодит байдал дээр ОУИТБС-ын оролцоонд сайдыг төлөөлөн Дэд сайд О.Батнайрамдал оролцож ирсэн бол УУХҮЯ-ны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд ТНБД-ын оролцож амжаагүй хурал, уулзалтуудад түүнийг төлөөлөн оролцож иржээ. Энэхүү Баталгаажуулалтын үнэлгээний маягаар иргэний нийгмийн зүгээс ирүүлсэн мэдээллээр ОУИТБС-ыг хариуцан хэрэгжүүлэх чиг үүргийг Ерөнхий сайдын Ажлын албанаас УУХҮЯ-нд шилжүүлсэн явдал нь ОУИТБС-ын хэрэгжилтийн хувьд үхралт болсон гэж үзсэн ба үүний улмаас төрийн төлөөлөх өндөр албан тушаалтны түвшин буурсан гэж үзжээ.</p> <p>Үйл ажиллагааны түвшинд Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт зохих шатны төрийн төлөөлөл- албан тушаалтан оролцож ирсэн ба 2018- 2021 онуудад тэдний Ажлын хэсгийн хуралдаануудад оролцсон байдал нь зөв зохистой, харьцангуй өндөр түвшний албан тушаалтны хэмжээнд байна (жишээ нь газар, хэлтсийн дарга). Гэвч Ажлын хэсэг дэх төрийн оролцоо нь ЗГХЭГ, СЯ, БОАЖЯ, орон нутгийн (Сэлэнгэ аймаг) төлөөллөөс илүүтэйгээр УУХҮЯ, ТЕГ, АМГТГ-ын төлөөллийн хувьд илүү өндөр байна. Монголын ОУИТБС-ын <a href="#">2019 оны жилийн ажлын тайлан</a> нь Ажлын хэсгийн үйл ажиллагаанд доод</p>
--	---

	<p>тушаалын албан тушаалтныг төлөөлүүлэн оролцуулж буй асуудлыг гарган ирсэн. Хэд хэдэн төрийн албан тушаалтны зүгээс энэхүү Баталгаажуулалтын хамаарах хугацаанд бусад яам, агентлагтай харьцуулбал УУХҮЯ-ны оролцоо нь илүү зөв зохистой хэмжээнд хадгалагдаж буй гэж үзжээ. Үнэлгээний “Оролцогч талуудын оролцоо” хэмээх маягтаар иргэний нийгмийн ирүүлсэн мэдээллээр ОУИТБС-ын үйл ажиллагаанд шийдвэр гаргах эрхгүй доод тушаалын ажилтнууд оролцох байдал 2020- 2021 онуудад нэмэгдэж буй санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Гэвч ОУИТБС-ын орон нутагт хүрэх, мэдээлэл түгээх үйл ажиллагаанд УУХҮЯ-ны төлөөлөл сайн оролцож буйг энэхүү Баталгаажуулалтад зориулсан “Үр дүн, үр нөлөө” маягтаар Ажлын хэсгийн ирүүлсэн мэдээллээр баталгаажиж буй ч бусад төрийн байгууллагуудын оролцоо тодорхойгүй хэвээр байна.</p> <p>Төрийн байгууллагуудын зүгээс ОУИТБС-ын өгөгдөл мэдээллийг ирүүлэх байдал үндсэндээ шаардлагад нийцсэн, Ажлын хэсгийн зүгээс төрийн байгууллагуудын тайлан гаргах байдалд “80% сэтгэл ханамжтай” хэмээн 2020 оны <a href="#">жилийн ажлын тайландаа</a> дүгнэжээ. Хамгийн сүүлд гарсан ОУИТБС-ын тайланд (2020) материаллаг төлбөр хүлээн авдаг төрийн байгууллагуудын дийлэнх нь (8 байгууллагын 7 нь) тайлангаа гаргасан бол орон нутгийн төрийн байгууллагуудын тайлагнал дахь оролцоо сүл (21 аймгийн 17 нь, 10 дүүргийн 6 нь) буйг тэмдэглэжээ. Ярилцлагад хамрагдсан төрийн албан тушаалтнуудын зүгээс үйл ажиллагааг уялдуулах болон өгөгдөл ирүүлэх үйл явцыг сайжруулах зорилгоор 2022 онд төрийн бүх байгууллага дээр ОУИТБС хариуцсан ажилтныг томилох төлөвлөгөөтэй буйг дурдсан. Үүний зэрэгцээ Засгийн газрын зүгээс тайлан гаргаагүй компаниуд, төрийн байгууллагуудад хандан үйл ажиллагаа явуулан мэдээллийг иж бүрэн ил тод болгох чиглэлээр ажиллаж буй баримт нотолгоо хомс байна. Төрийг төлөөлөн ОУИТБС-д ажиллаж буй төлөөлөлд Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт шууд хамаарахгүй буй талаар баримтжуулсан нотолгоо бага буй ч ярилцлагад хамрагдсан төрийн зарим төлөөллийн зүгээс ОУИТБС нь УУХҮЯ дотроо бүрэн институт болсноор төрийн бүх байгууллагыг хамруулан өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийгдэж буй хэмээн мэдээлсэн.</p> <p>Засгийн газрын зүгээс энэ хугацаанд ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй саад тотгоруудыг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлсний тоонд УУХҮЯ нь Хараат бус аудиторыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг жил тутамд гүйцэтгэж байжээ. Гэрээний ил тод байдал, эцсийн өмчлөгч болон системтэйгээр ил тод болгох чиглэлээрх Засгийн газрын бодлого нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх өргөн хүрээний орчныг бий болгож байна. УУХҮЯ-ны зүгээс Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг (ОУИТБС-ын хууль хэмээн нэрлэж буй) боловсруулсан ба үүнийг УИХ-ын хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр төлөвлөж буй ч ярилцлагад хамрагдсан төр болон салбарын хэд хэдэн төлөөллийн зүгээс Ашигт малтмалын тухай хууль, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг өмнө нь батлах төлөвлөгөөтэй тул тухайн хууль хойшлогдож магад хэмээн үзжээ. Гэвч ОУИТБС-ын хэрэгжилтийн орчныг бий болгоход Засгийн газрын үйл ажиллагааны оролцоо нь янз бүр байна. Хэд хэдэн төрийн албан тушаалтны зүгээс Засгийн газар нь хэрэгжилтэд тулгарч буй саад тотгорыг даван түүлах</p>
--	--



	<p>арга хэмжээг хэрэгжүүлсэн гэж үзэж буй ч ярилцлагад хамрагдсан хэд хэдэн иргэний нийгмийн байгууллагын хувьд ОУИТБС-ын хэрэгжилтийн цар хүрээ, зөвлөмжүүдийн хэрэгжилтийн чиглэлээрх Ажлын хэсэг дээр хэлэлцэж буй хэлэлцүүлэгт төрийн манлайлал дутмаг буй хэмээн үзэж байна (<i>Шаардлага 7.3 дээр үзнэ үү</i>).</p> <p>Засгийн газраас 2018- 2021 онуудад ОУИТБС-ын хэрэгжилтэд зориулсан санхүүжилтийг хуваарилж ирсэн ч мөнгөн дүнгийн хувьд буурсан хандлагатай байв. Засгийн газраас ОУИТБС-ын санхүүжилтэд хуваарилж буй төсөв 2018 онд 436.3 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 205.9 тэрбум болж буурсан бол 2022 онд 202.6 тэрбум төгрөгийг хуваарилжээ. Үүнд ОУИТБС-ын жил тутмын тайлан бэлтгэн гаргах зардал, Ажлын албаны зардлыг багтаажээ. Дэлхийн Банкнаас олгож байсан санхүүжилт 2018 онд дуусгавар болсноор Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зүгээс (ЕСБХБ) 2019 онд санаачилгын хэрэгжилтэд зориулан санхүүжилт олгосон бол Азийн хөгжлийн банкны зүгээс 2020- 2021 онд донорын санхүүжилтийн үүргийг хүлээн авчээ. ОУИТБС-д зориулсан хандивлагч байгууллагуудын нийт санхүүжилт нь 2018 онд 203,643 ам.доллар (Дэлхийн Банк) байснаас 2019 онд 46,450 ам.доллар (ЕСБХБ) болж буурсан бол 2020 онд 87,034 ам.доллар (АХБ) болж нэмэгджээ. Дэлхийн Банкны зүгээс нийт 500,000 ам.долларын тэтгэлэг 2022- 2023 онд олгохоор баталгаажуулаад буй нь ОУИТБС-ын хэрэгжилтэд хамаарах үйл ажиллагааны зардлыг бус харин тодорхой төслүүдийг санхүүжүүлж, системтэйгээр ил тод болгоход тусгайлан төвлөрөхөөр төлөвлөжээ. Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч тал нь төрийн зүгээс хуваарилж буй санхүүжилт хангалттай бус, буурч буй гэж үзсэн бол бусад оролцогчид нь хамаарах хугацаанд ОУИТБС-ын хэрэгжилтэд энэхүү төрийн санхүүжилт чухал үүрэгтэй байсан гэж үзжээ. Гэвч иргэний нийгмийн зүгээс баталгаажуулалтад зориулан гарган өгсөн маягтын мэдээлэл, ярилцлагын үр дүн зэрэг дээр ОУИТБС-ын Ажлын албаны ажилтнуудын цалинг 2019 онд олгоогүй, 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан олон үйл ажиллагаа хэрэгжээгүй ажээ. Нээлтэй нийгэм форумын зүгээс Ажлын албаны Мэдээллийн технологийн зөвлөхийн цалинг 2019 онд хэдэн сарын түршид төлснөөр цахим тайлагналын системийн платформын хэвийн ажиллагаа хангагдсан байна. Нөгөө талаар Засгийн газрын зүгээс Олон улсын Ажлын албанд жил тутамд 10,000 ам.долларын санхүүжилт олгож буйг төрийн зарим өндөр албан тушаалтны зүгээс Засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрмэлзэлтэй буйг харуулж буй гэж үзжээ. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбарт ОУИТБС-ын үйл явц дахь төрийн байгууллагуудын оролцооны сул талуудыг шийдэх засан залруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, өндөр түвшний мэдэгдэл гаргах зэрэг үйл ажиллагааг төлөвлөж буйг дурдсан. Харин өөрийн ирүүлсэн тайлбартаа иргэний нийгмийн төлөөллийн зүгээс Баталгаажуулалтын хамаарах хугацаанд төрийн өндөр түвшний хүсэлт эрмэлзэл, дэмжлэг буурсан ба үүнийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн чиг үүргийг Ерөнхий сайдын Ажлын албанаас УУХҮЯ-нд шилжүүлснээр нотлогдож байна хэмээн үзжээ. Иргэний нийгмийн зүгээс мөн УУХҮЯ нь ОУИТБС-ыг “олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу хэрэгжүүлэх” бус харин</p>
--	---

	<p>нэг удаагийн “төсөл” хэмээн үзэж буйг шүүмжилж, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж, ОУИТБС-ын Ажлын албыг байнгын бүтэц болгох нь чухал хэмээн үзжээ. Иргэний нийгмийн зүгээс мөн Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг 2020 онд боловсруулсан ч өнөөг хүртэл УИХ-д өргөн мэдүүлээгүй буйл сэтгэл дундуур буйгаа илэрхийлсэн. Мөн иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд хамрагдаж буй бүх төрийн байгууллагын үйл ажиллагаа, оролцоог уялдуулан зохицуулах нь чухал болохыг цохон тэмдэглэжээ.</p>
<p><b>Салбарын оролцоо (Шаардлага #1.2)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 1.2 дээр тусгасан ихэнх шаардлага ханган биелэгдсэн хэмээх дүгнэлт гаргаж байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогчийн зүгээс, тэр дундаа салбарын төлөөллийн хувьд Ажлын хэсэгт салбарыг төлөөлж буй талууд нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй гэж үзсэн ч салбар дахь өргөн хүрээний олон талуудын зүгээс ОУИТБС-ын үйл явцад бүрэн хэмжээнд, идэвхтэй оролцож буйг харуулах баримт нотолгоо бага байна. Ярилцлагад хамрагдсан талууд нь байгалийн хий, газрын тосны компаниудын оролцоо бага гэдэгтэй санал нийлж, үүнийг нийт уул уурхайн салбарын төлөөлөлд хамруулан ойлгож байна. Гэвч ярилцлагад хамрагдсан талуудын аль нь ОУИТБС-д компаниуд идэвхтэй оролцоход саад тотгор байхгүй гэж үзсэн ч салбарын төлөөллийн зүгээс ОУИТБС-ын тайлан гаргах талаар өнөөг хүртэл эрх зүйн иж бүрэн үндэс бүрдээгүй хэмээн үзжээ.</p> <p>Салбарын зүгээс ОУИТБС-ын тайлагнал дахь салбарын оролцоо, ялангуяа томоохон компаниудын оролцоо сайн буйг баримт нотолгоо харуулж буй ч хэрэгжилтийн бусад хэсэгт салбарын оролцооны хувьд бага, жишээ нь орон нутагт хүрч ажиллах, мэдээлэл түгээх чиглэлээр тэдний оролцоо дутмаг байна. Ажлын хэсэгт буй салбарын төлөөлөл нь олборлох/ эрдэс баялгийн салбарын нийтлэг бүтцийг төлөөлөх ба нийт 11 гишүүний 9 нь уул уурхайн, 2 нь газрын тос, байгалийн хийн компаниудын төлөөлөл байна. Ажлын хэсэгт шууд төлөөлөл бүхий бүх компани хэдийн үйлдвэрлэлийн шатанд явж буй бол Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУА), Монгол нүүрс ассоциаци (МНА) хайгуулын шатанд буй компанийг мөн төлөөлнө хэмээн үзэж болно. Бодит хэрэг дээр Ажлын хэсэгт буй хоёр холбоо, Оюу Толгой, Эрдэнэс Монгол, Рио Тинто компаниудын 5 төлөөллийн Ажлын хэсгийн хуралд оролцсон оролцоо нь бусад 6 гишүүнээс илүү өндөр байв. Уул уул салбарыг төлөөлөн ОУИТБС-ын Ажлын хэсэгт ажиллах гишүүдийн томилох/сонгох журмыг МУУА тогтоосон ч Ажлын хэсэг дэх байгалийн хий, газрын тосны компаниудын төлөөллийг сонгох журам тодорхойгүй байна (<i>Шаардлага 1.4 дээр үзнэ үү</i>). Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг судлан үзвэл салбарыг төлөөлж Ажлын хэсэгт буй гишүүд нь өөрийн ажлыг ОУИТБС-ын хэрэгжилтийн бусад хэсгээс илүүтэйгээр тайлан гаргахтай холбоотой асуудалд төвлөрүүлж байна.</p> <p>ОУИТБС-ын асуудлыг бүхий өргөн хүрээний сонгогч талуудтай уялдуулан зохицуулах механизмыг МУУА хариуцан ажиллаж буй ч тус ассоциацийн гишүүн бус компаниуд, байгалийн хий, газрын тосны компаниудтай уялдуулан зохицуулах механизм тодорхойгүй байна. Салбарын зүгээс</p>

	<p>ОУИТБС-ын орон нутагт хүрч ажиллах, мэдээлэл түгээх чиглэлийн үйл ажиллагаанд оролцож буй баримт нотолгоо бага ч ОУИТБС-ын жилийн тайлангуудад 2020 болон 2021 онд зохион байгуулсан, цахим тайлагналын системийн маягтуудын талаарх 4 удаагийн сургалтад олборлох үйлдвэрлэлийн компаниуд хамрагдан оролцсоныг тэмдэглэжээ. Талуудтай хийсэн ярилцлагаар мэдээлэл түгээх, орон нутагт хүрч ажиллах чиглэлээр компаниуд идэвх, санаачилгатай оролцдогийг харуулаагүй ч зарим компанийн хувьд өөрийн үйл ажиллагаа явуулж буй газруудад зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцож ирсэн байна.</p> <p>ОУИТБС-ын үйл явцад компаниудын оролцоог хангасан орчин бий болж, энэхүү орчин нь өмнөх баталгаажуулалтаар тогтоогдсон орчинтой ижил буй нь ярилцлагад оролцсон салбарын төлөөллийн үзэл бодол, Баталгаажуулалтад зориулсан “Оролцогч талуудын оролцоо” маягтад дурдсан мэдээллээр нотлогдсон. Бодит байдал дээр ОУИТБС-д хамрагдаж буй, материаллаг төлбөр төлдөг компаниудын дийлэнх нь буюу 2018 онд материаллаг түвшнээс дээр хэмжээний татвар, төлбөр төлсөн 202 компанийн 179 нь, 2019 оны 171 компанийн 161 нь, 2020 оны 60 компанийн 57 нь ОУИТБС-ын тайлангаа гаргасан. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх компани заавал тайлагнах үүрэг бүхий Цахим тайлангийн порталд компаниуд мэдээллээ ирүүлж буй түвшин үндсэндээ материаллаг түвшнээс дээш гарч, нэгтгэлд хамруулж буй компаниудын тооноос хавьгүй өндөр байдаг. Цахим тайлагналын системээр тайлангаа ирүүлэх үүрэг хүлээсэн нийт 2,093 аж ахуйн нэгжийн 1,472 нь 2019 онд шаардлагатай өгөгдөл, мэдээлэл ирүүлсэн ба энэхүү харьцаа 2020 онд ч тогтвортой хадгалагдаж 2,363 компаниас 1,419 нь тайлангаа ирүүлжээ. Ярилцлагад хамрагдан салбарын төлөөллийн зүгээс ОУИТБС-ын тайлан гаргаж байх шаардлага нь томоохон компаниудын хувьд хангалттай буй ч жижиг компаниудын хувьд санаа зовних асуудал байгааг илэрхийлсэн. Салбарын төлөөлөл нь салбар нь өөрийн хамаарах тайлан гаргахгүй буй компаниудтай хэрхэн ажиллаж буй талаарх ямар нэгэн арга хэмжээний талаар дурдаагүй, ерөнхийд нь энэхүү арга хэмжээг авах үүрэг нь Засгийн газарт хамаарна гэсэн бодолтой байна. Засгийн газар, салбарыг төлөөлсөн хэд хэдэн оролцогчийн зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ихэнх нь хөрөнгө оруулалт хайж буй шатанд буй тул 2020 оны байдлаар нийт 250 уул уурхайн компани л идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй гэж мэдээлсэн. Төрийн албан тушаалтнуудын зүгээс ч компаниудын зүгээс тайлан гаргахтай холбоотой асуудал буй ба заримдаа 20 орчим төрлийн өгөгдөл мэдээлэл жил тутам гарган өгөх нь тэдэнд ачаалал нэмдэг хэмээн гомдол гаргадаг болохыг дурдсан. Төрийн албан тушаалтнуудын хэлж буйгаар 2020 онд Ил тод байдлын шагнал гардуулсан нь компаниуд ОУИТБС-ын үйл явцад оролцоход нь түлхэц үзүүлжээ. Тэдний зүгээс хэлэхдээ өнөөгийн байдлаар тайлан ирүүлээгүй компаниудад ямар нэгэн хариуцлага тооцоогүй, харин Засгийн газрын зүгээс тэдний оролцоог урамшуулан дэмжих чиглэлд анхаарч буй ажээ. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь ОУИТБС-ын үйл явц дахь төрийн салбарын компаниудын оролцооны сул талуудыг шийдэх засан залруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, өндөр түвшний мэдэгдэл гаргах</p>
--	---

	<p>зэрэг үйл ажиллагааг төлөвлөж буйг дурдсан. Харин иргэний нийгмийн зүгээс салбарын холбоод нь компаниудын оролцоог илүү сайн уялдуулан зохицуулах хэрэгтэйг дурдаж, ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцож буй томоохон компаниуд нь сайн жишиг тогтоон, улмаар жижиг, дунд хэмжээний компаниудын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатайг тэмдэглэсэн. Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн зүгээс цаашид ОУИТБС-ын үйл ажиллагаанд салбарын компаниудын оролцоог бэхжүүлэх чиглэлээр ажиллах болохоо мэдэгдсэн.</p>
<p><b>Иргэний нийгмийн оролцоо (Шаардлага #1.3)</b></p> <p><i>Бүрэн ханган биелсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны дүгнэлтээр Шаардлага 1.3 бүрэн ханган биелэгдсэн хэмээн үзэж байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч талын зүгээс ОУИТБС-д иргэний нийгмийн иж бүрэн, идэвх санаачилгатай, үр дүнтэй оролцоог хангах зорилт бүрэн биелэгдсэн гэж үзжээ. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн олон төлөөлөл бусад талуудын оролцооны түвшин, цаашид иргэний нийгмийн оролцоог хязгаарлахаар УИХ дээр хэлэлцэж буй хуулийн төслийн талаар сэтгэл дундуур буйгаа илэрхийлж байсан. Гэвч Баталгаажуулалтад хамаарах хугацаанд байгалийн баялгийн засаглалын чиглэлээр иргэний нийгмийн оролцоон төрийн зүгээс ямар нэгэн саад тотгор учруулж буй эсэх дээр ярилцлагад хамруулсан иргэний нийгмийн төлөөллийн зүгээс өгсөн санал олон янз байв. Харин салбар, төрийн төлөөллийн аль нь ч байгалийн баялгийн засаглалын асуудлаарх иргэний нийгмийн оролцоонд төрийн зүгээс учруулж буй ямар нэгэн саад тотгор буй гэж үзээгүй. Ажлын хэсгийн гишүүн болон гишүүн бус ИНБ-үүд нь иргэний нийгмийн зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбартай хамаарах нийтийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргах үед үг хэлэх эрх чөлөөг нь тухайн байгууллага ОУИТБС-д хамаардаг эсэхээс үл хамааран төрийн зүгээс боомилдог, мөн ОУИТБС-ын хүрээнд болон илүү өргөн хүрээнд иргэдэд шийдвэр гаргалтад оролцох хүртээмжийг хангах эрх зүйн процедурыг зөрчдөг байна. Олон улсын Ажлын албаны зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтэд иргэний нийгмийн иж бүрэн, идэвх санаачилгатай, үр дүнтэй оролцоог хангах зорилт бүрэн хангагдсан гэж үзэж байна.</p> <p>Өмнө хийгдсэн Баталгаажуулалтаас хойш хугацаанд ОУИТБС-ын үйл явцтай холбоотой олон нийтийн хэлэлцүүлэгт төрийн зүгээс саад тотгор учруулж буй ямар нэгэн шинж тэмдэг ажиглагдаагүй. <a href="#">Дэлхийн эрх чөлөөний индексээр</a> Монгол улсын рейтинг 2018 онд “чөлөөт” гэж тогтоогдсоноос хойш хэвээр хадгалагдаж буй бол <a href="#">Civicus</a> байгууллагын хийсэн үнэлгээгээр “саад тотгор учруулдаг” гэж 2018 онд үнэлэгдсэн бол 2021 онд “багассан” гэж дүгнэгджээ. 2019 оны 11 дүгээр сараас хойш УИХ ТББ-ын тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлсэн ба үүнийг дараа нь Олон нийтийн төлөө үйл ажиллагаа, Холбооны тухай болон Сангийн тухай хуулийн төслүүдээр сольж хэлэлцэж байна. Энэхүү санал болгож буй шинэтгэл нь ТББ-ын бүртгэл дээрх төрийн хяналтын нэмэгдүүлэх, ТББ-ын үйл ажиллагаанд хязгаарлалт хийх боломжийг нээх, ТББ-уудыг нэг бол холбоо эсвэл сан болох шаардлага тавьж буй нь иргэний нийгмийн санаа зовоож буй асуудал байна (мөн <a href="#">Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн олон улсын төв</a>). Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн олон тооны төлөөлөл энэхүү хуулийн төсөл нь үйл ажиллагаа явуулах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд ихээхэн сөрөг нөлөөлөл учруулна</p>

	<p>хэмээн үзсэн. Хэдий одоо төсөл хэлбэрээр буй ч ИНБ-үүдын хэлж буйгаар 2022 оны 4 дүгээр сарын 1-нд эхлэх УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэхээр оруулжээ. Нөгөө талаар ярилцлагад хамрагдсан ИНБ-үүд хэлэхдээ ТББ-үүд болон Засгийн газар хоорондын зөвлөлдөх үйл ажиллагаа 2022 оны 3 дугаар сарын байдлаар үргэлжлэн хийгдэж байгааг дурдсан. Монгол УИХ нь 2021 оны 4 дүгээр сард Ази тивд анхдагч Хүний эрхийн хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргасныг олон улсын ТББ-үүд <a href="#">талархан хүлээн авч</a>, хүний эрхийн төлөө тэмцэгчдэд шинэ хамгаалалт бий болгосон явдлыг сайшаасан. Гэвч ярилцлагад харагдсан иргэний нийгмийн оролцогчдын зүгээс энэхүү хуулийн хамгаалалт хараахан хэрэгжиж эхлээгүй байна.</p> <p>ОУИТБС-ын үйл ажиллагаанд иргэний нийгэм иж бүрэн, идэвх санаачилгатай, үр дүнтэй оролцоо хангагдсан болохыг харуулах хангалттай баримт нотолгоо байгаа ба үүнд байгалийн баялгийн засаглалын асуудлаарх олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох боломж зэрэг багтана. Энэхүү баталгаажуулалтад зориулан иргэний нийгмийн зүгээс “Оролцогч талуудын оролцоо” маягтаар ирүүлсэн мэдээлэлд иргэний нийгмийн зүгээс Засгийн газар болон салбарт чухал ая холбогдол бүхий олон нийтийн санал бодлыг дамжуулсан дуу хоолой болж, үүний хүрээнд төрөл бүрийн тайлан, мэдээл, нийтлэл, иргэлтэй ажиллах зэрэг жишээ багтжээ. ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцож буй бүх ИНБ, тэднийг сонгон ажиллуулж буй бусад байгууллагууд нь өөрийн үйл ажиллагаанд ямар нэгэн сорилттой тулгарч буй байдал байхгүй, ялангуяа олон улсын эх үүсвэрээс хөрөнгө босгоход ямар нэгэн саад тотгоргүй байна. Үүнийг иргэний нийгмийн зүгээс маягтаар ирүүлсэн мэдээлэл баталсан. Үүний зэрэгцээ ярилцлагад хамрагдсан, Ажлын хэсэгт шууд төлөөлөлгүй зарим иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс нийтийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргаж буй зарим ТББ нь энэхүү эрхээ олборлох салбар дээр ашигласны төлөө ямар нэгэн байдлаар дарамт, сүрдүүлэгд өртдөг хэмээн хэлж байна. Хэд хэдэн ИНБ-ын зүгээс тэдэнд дарамт шахалт үзүүлсэн, ялгаварлан гадуурхсан, олон нийтийн сүлжээгээр сөрөг мэдээлэл тараасан зэрэг тохиолдлын талаарх ярьж буй үүнийг зөвхөн төрд хамаатуулах бус мөн компаниуд болон иргэдийн зүгээс үзүүлж буй дарамт шахалт хэмээн үзэж болно. Гэхдээ ИНБ-үүдын зүгээс ийнхүү тэднийг дарамтлах, сүрдүүлэх үйлдэл нь Засгийн газрын зүгээс зохион байгуулалттай хийж буй зүйл бус харин зарим төрийн албан хаагч уул уурхайн компанитай холбоотой байдгаас хамаардаг гэж үзжээ. ТАН эвслийн гишүүн, нийтийн эрх ашгийг хамгаалах нэхэмжлэл гаргаж буй ИНБ-үүдын зүгээс тэднийг нэхэмжлэл гаргахад дагаж мөрдсөн, холбоо харилцааг нь хянасан тохиолдлын талаар дурдсан ч тухайн ТНБ-үүд нь үүнд төр оролцсон хэмээн сэжиглэж буйгаас бус үүнийг нотлох ямар нэгэн баримт материал байхгүй. Монголын ОУИТБС-ын зүгээс үүнийг нотлох ямар нэгэн баримт бичиг ирүүлээгүй эсвэл энэ талаарх хэвлэл мэдээллээр гарсан зүйлс байхгүй. Гэвч компаниудтай зөрчилдөж, нийтийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргаж ИНБ-үүд нь тухайн нэхэмжлэлийг гаргуулахгүй байх арга хэмжээг төрийн албан тушаалтнууд авч, тэднийг дарамталж байна хэмээн үзсэн. Ярилцлагад хамрагдсан ИНБ-үүдын зүгээс энэхүү асуудлыг Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн анхааралд хүргээгүй, Баталгаажуулалтын маягтад оруулаагүй буй бөгөөд энэхүү үйлдэл нь ОУИТБС-</p>
--	---

	<p>ын үйл явцад шууд хамааралгүй хэмээн үзжээ. Нөгөө талаар ОУИТБС-д оролцож буй хэд хэдэн ИНБ нь Иргэний нийгмийн оролцоо нь ОУИТБС-ын бүхий л чиглэлийг хамарна хэмээх ОУИТБС-ын Иргэний нийгмийн протоколын талаар дурдаж буй ба нийтийн эрх ашгийг хамгаалсан нэхэмжлэл гаргахад дарамт шахалт үзүүлж буй нь протоколыг зөрчсөн хэрэг хэмээн үзжээ. Ярилцлагад хамрагдсан бусад ИНБ-уудын зүгээс хэлэхдээ төрийн байгууллагууд саад тотгор учруулах эсвэл дарамт шахалт үзүүлэхээс илүүтэйгээр мэдээлэл авах хүсэлт гаргасан тэдний хүсэлтийг хайхардаггүй байдал элбэг байна.</p> <p>ОУИТБС-ын үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог үндсэндээ ТАН эвсэл болон үүний гишүүн байгууллагууд чиглүүлж буй бол Баталгаажуулалтад зориулан иргэний нийгмийн зүгээс ирүүлсэн мэдээлэлд Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн оролцоо сул, гишүүд нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд 2020- 2021 онд оролцоогүй болохыг дурдсан. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн ИНБ-ын зүгээс Байгаль орчны иргэний зөвлөл нь компаниуд, төрөөс санхүүжилт авдаг тул сонирхлын зөрчилтэй (өмнөх Баталгаажуулалтад заасантай ижил) ч 2019 оноос хойш Байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүд ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцоогүй нь өмнө нь ч оролцдоггүй байсан тул ямар нэгэн сорилт, хүндрэл учруулаагүй гэж үзжээ. ТАН эвсэл нь ОУИТБС-д оролцож буй иргэний нийгмийн үндсэн байгууллагуудын дийлэнхийг эгнээндээ нэгтгэсэн, Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт төлөөлөлтэй ажиллаж байна (<i>Шаардлага 1.4 дээр үзнэ үү</i>). ОУИТБС-тай холбоотой асуудлаар өөрийнхөө төлөөлж буй бусад байгууллага, талуудтай үйл ажиллагааг зөвлөлдөх, зохицуулах асуудлын хувьд 2021 онд улам сайжруулан, илүү олон талуудаас, ялангуяа орон нутгаас санал хүсэлт хүлээн авах зорилго бүхий <a href="http://miningwatch.mn">miningwatch.mn</a> вэбсайтыг ажиллуулж эхэлжээ.</p> <p>2018- 2021 оны хугацаанд иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл явцын гол хөдөлгөгч байжээ. ОУИТБС-д хамааран оролцож буй иргэний нийгмийг үндэсний хэмжээнд төлөөлөх талууд нь хангалттай чадавхтай, харин орон нутгийн иргэний нийгмийн чадавх нь ялгаатай, ТАН эвслийн гишүүн байгууллагуудын хувьд бусад байгууллагатай харьцуулбал илүү өндөр чадавхтай байна. Энэхүү оролцогч талууд нь ОУИТБС-ын хэрэгжилтэд түлхэц болж буй хэд хэдэн шинэ вэбсайт нээсний тоонд ил тод <a href="#">гэрээний портал</a>, ОУИТБС-ийн тайлангаар ил тод болгосон эцсийн өмчлөгчийн <a href="#">онлайн мэдээллийн сан</a> болон Дорноговь аймгийн иргэд уул уурхайн гол төслүүд, өөрсдийн эрхийн талаар мэдээлэл ирүүлэх <a href="#">онлайн өргөдлийн</a> сайт багтаж байна.</p> <p>Баталгаажуулалтад зориулан иргэний нийгмийн зүгээс ирүүлсэн баримтад тухайн тал нь ОУИТБС-ын санаачилгын үйл явцыг олон нийтийн арга хэмжээ, сургалт семинараар дамжуулан олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, энэхүү ажиллагааг 2020-2021 онд үндсэндээ онлайн хэлбэрээр хийж гүйцэтгэжээ. Иргэний нийгэм нь мэдээлэл түгээх, орон нутагт хүрч ажиллах (<i>Шаардлага 7.1 дээр үзнэ үү</i>) гол хөдөлгөгч хүч байна. Нөгөө талаар иргэний нийгмийн ирүүлсэн “Оролцогч талуудын оролцоо” хэмээх маягтын мэдээлэл, ярилцлагуудын үр дүн нь Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг дээрх шийдвэр</p>
--	--



	<p>гаргалтад нөлөөлөхөд тулгарч буй асуудлуудаар иргэний нийгэм ихээхэн бүхимдалтай буйг харуулсан (<i>Шаардлага 1.4 дээр үзнэ үү</i>). Засгийн газрын зүгээс бодлого, хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг, сонсох ажиллагаа хийж байх хуулийн заалт Нийтийн сонсголын хуульд тусгагдсан. Хэд хэдэн иргэний нийгмийн зүгээс шинээр бүрдсэн Засгийн газар нь 2020 оноос хойш энэхүү хуулийн заалтыг үл ойшоож, нийтийн сонсолд ямар ТББ-ыг хамруулахыг өөрсдөө сонгох, эсвэл иргэний нийгмийн зүгээс нөлөөлөл ажил хийсний дараа л хуулийн төслийг (жишээ нь Баялгийн сангийн тухай хууль) нийтэд түгээж буй зэрэг дээр бүхимдлаа илэрхийлсэн. Ярилцлагад хамрагдсан нэг ИНБ-ын зүгээс 2020 оноос хойш төрийн байгууллагууд бодлого, эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр иргэний нийгэмтэй хамтран ажиллахад татгалзах хандлагатай болсон гэж үзэж байна. Гэвч Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа иргэний нийгмийн төлөөллийн зүгээс УУХҮЯ нь эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр олон нийттэй зөвлөлдөх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай гэж үзжээ. Олон улсын Ажлын албаны зүгээс бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зүйл заалтуудын хэрэглээний талаарх иргэний нийгмийн гарган тавьсан асуудлыг анхааралдаа авсан ч Баталгаажуулалтын хөтчийн Шаардлага 1.3, заалт 2.5 дээр заасан тухайн үр дүнг үнэлгээний зорилгоор бус харин тухайн нөхцөл байдлын талаарх мэдээлэл өгөх зорилгоор дурдана гэснийг удирдлага болгосон. Олборлох салбартай холбоотойгоор нийтийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргаж буй зарим ИНБ-уудыг дарамтлах, шахалт үзүүлэх байдал нь асуудал бөгөөд Олон улсын Ажлын алба нь Засгийн газрын зүгээс тэдэнд саад тотгор учруулж буй баримт нотолгоо нь тодорхой нөхцөл байдалд хамаарах ба төрийн зүгээс иргэний нийгмийн ОУИТБС болон баялгийн засаглал дахь оролцоог саатуулах зохион байгуулалттай үйлдэл хэмээн үзэхгүй байна. Тиймээс Олон улсын Ажлын албаны зүгээс иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл явцад идэвх санаачилгатай оролцож ирсэн, Баталгаажуулалтад хамаарах хугацаанд Иргэний нийгмийн протокол: Иргэний нийгмийн оролцоо гэсэн заалтуудыг зөрчсөн ямар нэгэн баримт нотолгоо байхгүй гэж үзсэн. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайландаа Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс санаачилгын үйл ажиллагаа дахь иргэний нийгмийн оролцоонд тухайн талын төлөөлөл сэтгэл ханамжтай буйг дурдсан ба энэ нь эерэг үр дүн байна.</p>
<p><b>Олон талын оролцоот бүлэг (Шаардлага #1.4)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс 1.4 дүгээр шаардлагын ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээн дүгнэж байна. Ярилцлага хийсэн ихэнх оролцогч талуудын зүгээс Ажлын хэсэг дээр хамаарах зөв талууд нь өөрийн төлөөлөлтэй хэмээн үзсэн ч дийлэнх хэсэг нь Ажлын хэсгийн гишүүн нэг бүрийн хувьд оролцооны түвшин нь ялгаатай хэмээн үзэж байна. Талуудын дийлэнх нь Баталгаажуулалтад хамаарах хугацаанд Ажлын хэсэг ОУИТБС-ын хэрэгжилтийн бүхий л чиглэлд хяналт тавьж байх нь суларсан хэмээн үзэж буй ч шалтгааны хувьд ялгаатай байна. Ажлын албаны зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтэд олон талуудын хяналт сул буй нь ОУИТБС-ын үйл явцын бусад хэсэгт хийдэл үүсгэж буй ба үүнд тодорхой төрийн байгууллага, компаниудын зүгээс өгөгдөл мэдээлэл гарган өгөх (<i>Шаардлага 4.1</i>), ажлын төлөвлөгөө, жилийн тайлан зэрэг ОУИТБС-ын баримт бичгүүдэд төр болон салбарын</p>

	<p>талуудаас оруулах хувь нэмэр (<i>Шаардлага 1.5 болон 7.4</i>) мэдээлэл түгээх үйл ажиллагаанд талууд оролцох (<i>Шаардлага 7.1</i>) зэрэг дээр хяналт сул байна. Гэвч Ажлын хэсгийн зүгээс ОУИТБС-ын хэрэгжилтийн бүхий л чиглэлд ахиц дэвшил гаргасаар буй тул ОУИТБС-ын үйл явцад олон талуудын хяналтын бий болгох зорилтын ихэнх хэсэг биелэгдсэн хэмээн үзсэн.</p> <p>Өмнөх Баталгаажуулалтад хамрагдах хугацаанаас хойш Ажлын хэсэгт ажиллах гишүүдийн тухайн хамаарах өргөн хүрээний хамрах талууд нь сонгох үйл явц, процедурт ямар нэгэн өөрчлөлт гараагүй харин төрийн өндөр түвшинд (Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийг өндөр албан тушаалтан даргалах) санаачилгыг удирдан хэрэгжүүлж байсан нь УУХҮЯ-нд шилжжээ (<i>Шаардлага 1.1 дээр үзнэ үү</i>). 2019 оны ОУИТБС-ын Стандарт гарсантай холбоотойгоор аль ч тал нь өөрийн төлөөллийг Ажлын хэсэгт нэр дэвшүүлэх журмаа эргэн хараагүй, ялангуяа Ажлын хэсэгт буй төлөөллийн жендерийн асуудлаар ямар нэгэн зүйл хийгдээгүй байна. Бодит байдал дээр 2019 оны 1 дүгээр сард иргэний нийгэм Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэг дэх төлөөллөө шинэчилсэн, Засгийн газар өөрийн төлөөллөө 2020 оны 6 дугаар сард шинэчилсэн бол салбарын хувьд компаниас томилогдон ажиллаж буй гишүүд нь ротаци хийхээс өөрөөр (Үндэсний зөвлөлд салбарыг төлөөлж буй гишүүдийн дийлэнх нь 2021 оны 7 сараас хойш ажиллаж буй) шинэчлэл хийгээгүй. Талууд өөрийн төлөөллөө нэр дэвшүүлэх үйл явцад өөрчлөлт оруулах ямар нэгэн санал гараагүй. Баримт нотолгооноос үзвэл иргэний нийгэм хамгийн сүүлд 2019 оны 1 дүгээр сард өөрийн төлөөллөө шинэчлэн томилоход Ажлын хэсэгт орж ажиллах урилга бүх талуудад нээлттэй, ил тод хүрчээ. Иргэний нийгмийн хийсэн томилгоо тодорхой, Үндэсний зөвлөлийн 8 гишүүн, Ажлын хэсгийн 9 гишүүн ТАН эвслээс сонгогдож, энэхүү томилгооны процессыг ТАН эвслийн дүрэмд тусгасан болохыг Баталгаажуулалтад зориулсан ирүүлсэн “Оролцогч талуудын оролцоо” хэмээх маягтын мэдээлэл харуулсан. Харин иргэний нийгмийг төлөөлөх бусад гишүүдийг томилох журам, ялангуяа Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн журам нь тодорхойгүй байна. Ажлын хэсэгт салбарыг төлөөлөн ажиллах төлөөллийг нэр дэвшүүлэх ажлыг МУУҮА уул уурхайн компаниудын дунд зохион байгуулдаг ч үүнийг олон нийтэд нээлттэй журамласан баримт бичиг байхгүй, газрын тос, байгалийн хийн салбарын төлөөллийг нэр дэвшүүлэх явцыг журамлаагүй байна. Салбар болон иргэний нийгмээс нэр дэвшигчийг Ажлын хэсэг баталдаг ба энэ процедурын нэг шат байх ба ярилцлагад хамрагдсан талуудын аль нь ч Ажлын хэсэг нь талуудын нэр дэвшигчээс татгалзаж байсан тохиолдол байхгүй.</p> <p>ОУИТБС-ын <a href="#">Үндэсний зөвлөл</a> болон <a href="#">Ажлын хэсгийн</a> Ажиллах журамд 2017 оноос хойш буюу өмнө хийгдсэн Баталгаажуулалтаас хойш хугацаанд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Тиймээс Ажлын хэсгийн засаглалын баримт бичгүүдийг ОУИТБС-ын 2019 оны Стандартын 1.4b дээр шаардлагыг хангасан хэмээн үнэлсэн ч ОУИТБС-ын 2019 оны Стандартад заасан ОУИТБС-ын Ёс зүйн дүрэмд хамаарах шаардлагад нийцүүлэн тухайн баримт бичгийг шинэчлээгүй байна. Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь 2020 оноос КОВИД-19 цар тахлын улмаас байнга онлайн хэлбэрээр хүралдаж иржээ. Энэхүү Үйл ажиллагааны журамд заасан заалтуудаас, ялангуяа Ажлын хэсгийг</p>
--	--



	<p>түвшинд гажсан зүйл 2018- 2021 оны хугацаанд ажиглагдаж байна. Ялангуяа оролцогч талуудтай зөвлөлдөж байх, Ажлын хэсгийн хурлууд дахь оролцоо, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож буй талуудын чадавх, Ажлын хэсгийн гишүүд нь өөрийн төлөөлж буй сонгогч талуудтай холбоотой ажиллах, Ажлын хэсэг дээрх шийдвэр гаргалт, баримт бичгийг урьдчилан хүргүүлэх зэрэг дээр зөрчил байна.</p> <p>Энэхүү Баталгаажуулалтад зориулан “Оролцогч талуудын оролцоо” хэмээх маягтаар ирүүлсэн Ажлын хэсгийн хурлын оролцооны бүртгэл мэдээллийг судлан үзэхэд Засгийн газар болон салбарыг төлөөлсөн оролцогч талуудын оролцооны тэгш бус, харин иргэний нийгмийн дийлэнхийн хувьд зөв зохистой хэрэгжиж буйг харуулсан (Монголын байгаль орчны иргэний зөвлөлийг төлөөлсөн гишүүд 2020- 2021 онд хуралд огт оролцоогүйгээс бусдаар). Энэ хугацаанд зохион байгуулагдсан хуралд төрийн төлөөллийн оролцоог УУХҮЯ, ТЕГ, АМГТГ-ын төлөөлөл голлон хангаж ирсэн бол салбарын төлөөллийн оролцоог хоёр холбоо, Оюу Толгой, Эрдэнэс Монгол болон Рио Тинто компаниуд хангаж иржээ. Эдгээр талуудыг төлөөлсөн бусад оролцогч нар нь зөвхөн тодорхой хурлуудад л оролцож иржээ. Ярилцлагад хамрагдсан бүхий л талууд болон “Оролцогч талуудын оролцоо” маягтад дурдсан мэдээлэлд үндэслэн үзвэл ОУИТБС-ын асуудлыг УУХҮЯ хариуцдаг болсноос хойш төрийн албан тушаалтнуудын хурал дахь оролцоо буурч иржээ. Ихэнх өндөр албан тушаалтан өөрийн орны хүнийг томилон хуралд оролцуулж буйг ихэнх талуудын зүгээс ОУИТБС-ын хурлаар шийдвэр гаргах боломжид сөргөөр нөлөөлж байна хэмээн үзэж байна. “Оролцогч талуудын оролцоо” маягтаар иргэний нийгмийн зүгээс ирүүлсэн мэдээллээр хуралд оролцоогүй байх эсвэл шийдвэр гаргах эрхгүй бусдыг орондоо оролцуулах нь 2020- 2021 онд нэмэгдсэн санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Ажлын хэсгийн хурлуудын тэмдэглэлийг судлан үзэхэд Ажлын хэсэг дээр хийгдэж буй хэлэлцүүлэгт бусад талтай нь харьцуулбал иргэний нийгэм болон УУХҮЯ илүү идэвхтэй оролцож байна. Баталгаажуулалтад хамаарах хугацаанд Ажлын хэсэг нь ОУИТБС-ын хэрэгжилтийн гол хэсгүүд дээр өөрийн хяналтыг хэрэгжүүлж, үүний хүрээнд жил тутамд тайлагнаж, тайланг түгээж, олборлох үйлдвэрлэлийн засаглалын өргөн хүрээний зарим асуудлаар (жишээ нь Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт) хэлэлцүүлэг хийж иржээ. Гэвч Ажлын хэсэг нь ОУИТБС-ын хэрэгжилтийн цар хүрээг тогтоох, тайлан гаргах үйл явцад хяналт тавих чиг үүргийг Ажлын албандаа даалгах хандлагатай байна. Ажлын хэсэг нь ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлд гарч буй ахиц дэвшлийн талаар байнга хэлэлцэж буй ч ажлын төлөвлөгөөний төсөл бэлтгэх, төлөвлөх үйл ажиллагааг Ажлын албанд даатгаж, үүнд иргэний нийгмийн саналыг тусгаж байна.</p> <p>Иргэний нийгмийг төлөөлөх ТАН эвслийн гишүүдийн хувьд өөрийн хамаарах сонгогч талуудтай байнга зөвлөлддөг ч Байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүдийн хувьд энэхүү зөвлөлдөх арга хэмжээ хийгддэг гэх баримт нотолгоо байхгүй. Салбарын хувьд МУУҮА нь өөрийн хамаарах оролцогчдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад гол үүрэг гүйцэтгэдэг ч дотроо зөвлөлдөх механизмын хувьд албан бус, тохиолдлын чанартай, газрын тос болон байгалийн хий зэрэг бусад салбарын талуудтай зөвлөлдөж буй ямар нэгэн</p>
--	--

	<p>баримт нотолгоо байхгүй. Харин төрийг төлөөлж буй гишүүдийн хувьд бусад талуудтай, үүнд Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт шууд хамааралгүй бусад байгууллагатай зөвлөлдөх ямар нэгэн журам, арга ажиллагаа байхгүй ажээ.</p> <p>Энэхүү Баталгаажуулалтад зориулан ирүүлсэн ‘Оролцогч талуудын оролцоо’ маягтад дурдсанаар Ажлын хэсгийн гишүүд нь хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад бараг санал оруулдаггүй нь тэдний мэдлэг, чадавхын ялгаатай байдлаас хамаардаг ажээ. Гэвч иргэний нийгмийн зүгээс Баталгаажуулалтад зориулан гарган өгсөн мэдээллээс үзвэл Ажлын хэсэг дэх иргэний нийгмийг төлөөлсөн гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудлын жагсаалтад нэмэлтээр сэдэв оруулах санал гаргадаг ч Ажлын хэсэг дээр хэлэлцсэний дараа бусад талуудын дэмжлэггүй тул бодит ажил болдоггүй байна. Жишээ нь ярилцлагад хамрагдсан хэд хэдэн ИНБ-ын зүгээс 2020 оны ОУИТБС-ын тайланд “уян хатан” хандлага баримтлахыг эсэргүүцсэн ч Ажлын хэсэг дэх бусад хоёр оролцогч талын дэмжлэгийг хүлээгээгүй байна. Өмнөх Баталгаажуулалтаас хойш зөвшилцлөөр шийдвэр гаргах, гуравны хоёрын саналаар шийдвэр гаргах журам өөрчлөгдөөгүй, үүнийг бодит хэрэг дээр баримтлан хэрэгжүүлж байна. Гэвч иргэний нийгмийн зүгээс Баталгаажуулалтад гарган ирүүлсэн мэдээллээс үзвэл иргэний нийгмийн гаргасан санал дээр шийдвэр гаргалт бага буй нь тэднийг бүхмидэхэд хүргэж байна. Ярилцлагад хамрагдсан Засгийн газар болон салбарын төлөөлөл нь Ажлын хэсгийн үйл ажиллагаа явуулж буй байдалд сэтгэл ханамжтай буйгаа илэрхийлсэн бол Баталгаажуулалтад зориулан иргэний нийгмээс гарган ирүүлсэн “Оролцогч талуудын оролцоо” маягтад дурдсан мэдээлэлд ОУИТБС-ын тайлангийн төсөл, ажлын төлөвлөгөө, жилийн тайлан зэргийг 2020- 2021 онд Ажлын хэсгийн гишүүдэд хурлаас нэг өдрийн өмнө ирүүлж байсан нь гишүүд хоорондоо ч урьдчилан зөвлөлдөх хугацаа олгодоггүй байна.</p>
--	--

**Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд**

- Шаардлага 1.1 дээр заасны дагуу Монгол улс нь ОУИТБС-ын үйл явцад Засгийн газрын бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох байдлыг хангах шаардлагатай ба үүнд ОУИТБС-ын хэрэгжилтэд бодит хяналт тавьж байх, хэрэгжилтийг хангах зорилгоор техникийн болон санхүүгийн нөөц эх үүсвэрээр хангаж байх өндөр түвшний оролцоог хангах шаардлагатай. Засгийн газар нь ОУИТБС-ыг дэмжиж буй талаар өндөр албан тушаалтан байнгын мэдэгдлийг олон нийтэд хандан хийж байх нь зөв. ОУИТБС-ыг тэргүүлэн ажиллахаар томилогдсон төрийн өндөр албан тушаалтан ОУИТБС-ын үйл ажиллагааг яам, агентлаг хооронд зохицуулан уялдуулах, хэрэгжилтийг ханган нөөц эх үүсвэрийг дайчлах эрх мэдэл бүхий, бие даасан хараат бус албан тушаалтан байх ёстой.
- Шаардлага 1.2 дээр заасны дагуу Монгол улс нь өөрийн олборлох үйлдвэрлэлийн салбарын компаниудыг тус санаачилгын үйл явцад идэвхтэй, санаачилгатай, үр дүнтэй оролцуулж байх, үүнд шаардлагатай өгөгдөл мэдээлэл ил тод болгох, ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох, санаачилгын үйл явцын бүхий л хэсгийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах зэрэг багтана.
- Санаачилгын хэрэгжилтийн сайжруулахын тулд Монгол улс нь эрдэс баялгийн салбарын засаглалын асуудлаар олон нийтийн оролцоог хангаж байх хуульд заасан заалтыг бодит хэрэг дээр хэрэгжүүлэх нь зүйтэй. ОУИТБС-ын хэрэгжилтийн ашиглан төр, салбар, иргэний нийгмийн

хооронд байгалийн баялгийн засаглалын бүхий л чиглэлээр нээлттэй хэлэлцүүлэг хийж байх форумыг бий болгох, үүний хүрээнд ОУИТБС-ын үйл явц болон олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох оролцооны орчныг хангах нь зүйтэй.

- Шаардлага 1.4 дээр заасны дагуу Монгол улс нь ОУИТБС-ын засаглалын баримт бичгүүд, үүнд Үндэсний зөвлөл болон ОТОБ-ын (Ажлын хэсгийн) хийх ажлын тодорхойлолтыг ОУИТБС-ын 2019 оны Стандартад заасан ОУИТБС дахь Ажлын хэсгийн хяналт хэмээх шинэ заалтын хүрээнд шинэчлэн, үүнд төлөөллийн жендерийн харьцаа, Ёс зүйн дүрмийн даган мөрдөлт зэрэг зүйлсийг тусгах шаардлагатай. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүд нь өөрийн чиг үүргийг гүйцэтгэх чадамж, чадавхтай, ОУИТБС-д тэдний орооцоо нь ОУИТБС-ын олон талын хяналтын үйд явцыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэмжээнд байх шаардлагатай. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүд нь өөрийнхөө төлөөлж буй бүлэгтэй, ялангуяа салбар болон төрийн бусад байгууллагатай нягт холбоотой байх нь зүйтэй. Монгол улс нь хэрэгжилтийн явцад бүх талыг хүртээмжтэй оролцуулсан шийдвэр гаргах үйл явцыг хангаж, оролцогч тал нэгийг түнш хэмээн хандаж, аль ч тал нь хэлэлцэх асуудлын санал оруулах боломжийг нээлттэй байлгах нь чухал. Хурлуудын товыг хангалттай хугацааны өмнө мэдэгдэж, ямар нэгэн баримт бичиг хэлэлцэх, батлах бол төслийг нь эртнээс тарааж байх нь зүйтэй. Ажлын хэсэг нь ОУИТБС-ын тайлагнах үйл явцад хангалттай хэмжээнд оролцож, явцын тайлан болон ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд мониторинг хийх замаар хэрэгжилтэд хяналт тавьж байх ёстой. Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-ын Ажлын хэсгийг байгалийн баялгийн засаглалын өргөн хүрээний сэдвээр (үүнд иргэний оролцооны орчин, шийдвэр гаргалт) хэлэлцүүлэг өрнүүлдэг платформ болгож болно.

## 4. Ил тод байдал

Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь өгөгдөл мэдээлэл ил тод болгохтой холбоотой ОУИТБС-ын шаардлагууд болох Шаардлага 2-6 дээр үнэлгээ хийдэг.

### Олборлох үйлдвэрлэлийн салбарын тойм (Шаардлага 3.1, 6.3)

#### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Монгол улс нь олборлох үйлдвэрлэлийн салбар болон түс салбараас эдийн засагт оруулж буй хувь нэмрийн тухай мэдээллийг төрийн байгууллагуудын төрөл бүрийн порталаар дамжуулан ил тод нийтэлж байна. ОУИТБС-ын хүрээнд өгөгдөл мэдээлэл ил тод болгож буй нь тухайн хугацаанд явагдаж буй томоохон хэмжээний хайгуулын ажил, олборлох салбараас төвлөрүүлж буй Засгийн газрын орлого, салбарын ажил эрхлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг жил тутмын шинэчилсэн мэдээлэл гаргах байдлаар мөн үр дүнтэй байна. Гэвч геологийн мэдээлэл, хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл зэрэг АМГТГ-ын зүгээс өмнө нь ажиллуулж байсан бие даасан портал ажиллахаа больсон харагдаж байна. Монголын ОУИТБС нь өөрийн хэрэгжилтийн хүрээнд АМГТГ, Сангийн яам, ҮСХ болон бусад хамаарах байгууллагуудтай хамтран ажиллаж олборлох салбар, макро эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийн талаарх мэдээллийг системтэйгээр ил тод болгоход дэмжлэг үзүүлэх нь чухал.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Хайгуул (Шаардлага #3.1)</b></p> <p><i>Давуулан ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 3.1 давж биелэгдсэн хэмээх дүгнэлтийг гаргаж байна. Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарын талаарх тойм мэдээллийн олон нийтийн хүртээмж хангагдсан эсэх дээр ямар нэгэн санал илэрхийлээгүй. Ажлын албаны хувьд энэхүү зорилт давж биелэгдсэн, Засгийн газрын зүгээс шаардлагатай ихэнх мэдээллийг системтэйгээр ил тод болгож байна хэмээн дүгнэсэн.</p> <p>Олборлох салбарын гол зохицуулагч байгууллага болох АМГТГ нь өөрийн бэлтгэдэг сар тутмын <a href="#">статистик мэдээлэлд</a> уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарын мэдээллийг нийтэлдэг. АМГТГ нь өмнө нь хөрөнгө оруулагчдад зориулсан болон геологийн мэдээллийн вэбсайтуудыг ажиллуулж байсан ч энэ нь одоо үйл ажиллагаа явуулахгүй байна. Гэвч АМГТГ-ын сар тутмын мэдээ нь хийгдэж буй хайгуулын үйл ажиллагааны мэдээллийг хязгаарлагдмал байдлаар багтаадаг. Монголын ОУИТБС-ын тайлагнал нь олборлох үйлдвэрлэлийн салбарын талаар тойм мэдээлэл гаргаж, үүнд томоохон төсөл, компаниудын үйл ажиллагааны тойм мэдээлэл, мөн томоохон хэмжээний хайгуулын ажлын үр дүнгийн мэдээг багтааж байна. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь мөн бичил уурхайн талаар ихээхэн мэдээллийг тусган, ил тод болгожээ. Монголын ОУИТБС-ын хувьд АМГТГ-тай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн энэхүү мэдээллийг АМГТГ-ынхтай ижил төстэй засгийн газрын ажиллуулдаг платформоор дамжуулан системтэйгээр ил тод болгож байх нь зүйтэй. Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа ОУИТБС-ын Ажлын алба нь АМГТГ-ын зүгээс сар тутамд ашигт малтмалын нөөц, орд (ангиллаар), тусгай зөвшөөрлийн тоог мэдээлдэг хэмээжээ (жишээ нь 2020 оны 5 дугаар сарын мэдээлэл энд байна). Ажлын алба нь мөн компаниудын тайлангийн маягтад өөрчлөлт оруулан жил тутам өөрийн нөөцийн мэдээллийг ирүүлж байхаар болжээ.</p>
<p><b>Олборлох үйлдвэрлэлийн салбараас эдийн засагт оруулж буй хувь нэмэр (Шаардлага #6.3)</b></p> <p><i>Бүрэн ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 6.3 бүрэн биелэгдсэн хэмээн дүгнэж байна. Энэ талаар ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн салбарын оруулж буй хувь нэмрийн талаарх олон нийтийн ойлголт бий болгох зорилт биелэгдсэн эсэх дээр ямар нэгэн санал бодол илэрхийлээгүй. Ажлын албаны зүгээс ОУИТБС-ын хүрээнд болон Засгийн газрын мэдээллийн эх сурвалж дээр үндэслэн ихээхэн мэдээлэл ил тод болгож буй ч шаардлагатай бүхий л мэдээллийг төрийн порталуудад бүрэн хэмжээгээр, системтэйгээр хараахан ил тод болгоогүй гэж үзсэн.</p>

	<p>Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг эрдэс баялгийн салбараас эдийн засагт оруулж буй хувь нэмрийн тухай мэдээллийг абсолют болон харьцангуй утгаар нь төвлөрүүлэн, үүнд олборлох үйлдвэрлэлийн салбарын хувь нэмэр, ДНБ-д эзлэх хувь, засгийн газрын төвлөрүүлж буй орлого, экспортын мэдээлэл багтаж байна. Монгол улс нь мөн ОУИТБС-ын хүрээнд 500 гаруй компани дахь ажил эрхлэлтийн мэдээллийг ажил мэргэжлийн төрөл, хүйс болон орон нутгийн болон бусад (мөн гадаад ажиллагсад) иргэдээр задлан харуулж буй ч зарим компанийн зүгээс тайлан гаргахгүй буй нь тодорхой хийдэл бий болгож байна. Тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс компаниудын тайлангийн маягтуудад нэмэлт өөрчлөлт оруулж хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, дундаж цалингийн мэдээллийг оруулах болжээ. Гэсэн ч хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл нь абсолют болон харьцангуй дүнгээр ҮСХ-ны вэбсайт дээр ил тод байна. Иргэний нийгэмтэй хийсэн ярилцлагаар олон нийтийн зүгээс ажил эрхлэлтийн мэдээллийг ихээр сонирхдог ба учир нь олборлох үйлдвэрлэлд хийгдэж буй хөрөнгө оруулалттай холбоотой орон нутгийн ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл хомс байдаг ажээ. АМГТГ-ын кадастрын бүртгэл зэрэг төрийн порталууд, ОУИТБС-ын нээлттэй мэдээллийн портал нь олборлох үйлдвэрлэл явагдаж буй байршлын талаар ихээхэн мэдээлэл ил тод болгон нийтэлжээ.</p>
<b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b>	
<ul style="list-style-type: none"><li>• ОУИТБС-ын хэрэгжилтийн сайжруулахын тулд Монгол улс нь одоо явагдаж буй болон төлөвлөгдөж буй хайгуулын үйл ажиллагаа, геологийн мэдээллийг системтэйгээр ил тод болгох чиглэлээр ажиллаж, энэхүү ил тод болгож буй байдал нь уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарын хөрөнгө оруулагчдад зориулагдах нь зүйтэй.</li><li>• Санаачилгын хэрэгжилтийн сайжруулах зорилгоор Монгол улс нь салбарын зүгээс үндэсний эдийн засагт оруулж буй хувь нэмэр, үүнд хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг хүйс, компани, ажлын байраар нь, мөн албан бус олборлолтын үйл ажиллагааг задаргаатайгаар системтэйгээр ил тод болгох чиглэлээр хамаарах төрийн байгууллага, олборлох үйлдвэрлэлийн салбарын холбоодтой хамтран ажиллах нь зүйтэй.</li></ul>	

## Эрх зүйн орчин болон санхүүгийн горим (Шаардлага 2.1, 2.4, 6.4)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Олборлох үйлдвэрлэлийн салбарын эрх зүй, зохицуулалтын орчны талаарх мэдээлэл, үүнд санхүүгийн горимын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, гэрээний хугацаа болон нөхцөлүүд, төрийн байгууллагуудын чиг үүрэг зэргийг Монгол улсын төрийн байгууллагуудын вэбсайтаар системтэйгээр ил тод болгож байна. Монгол улс нь өөрийн ОУИТБС-ны тайланг тухайн мэдээллийн хүртээмжийг төвлөрүүлэх хангах, салбартай холбоотой хийгдэж буй болон төлөвлөж буй шинэтгэлд жил тутам хяналт тавих зорилгоор ашиглаад байна.

Монгол улс нь ОУИТБС-ын хэрэгжилтийг Засгийн газрын зүгээс баримталж буй ил тод байдлыг хангах бодлогын албажуулах, иргэний нийгмийн хэрэгжүүлж буй үйл явцын хүрээнд гэрээний ил тод байдлын порталыг нээн ажиллуулахад ашиглажээ. Монгол улс нь эрдэс баялаг хайх болон олборлохоос эхлээд компани, нутгийн захиргаа болон иргэдийн хооронд хийгдсэн орон нутгийн хөгжлийн гэрээ зэрэг олон тооны гэрээ хэлэлцээрийг ил тод болгоод байна. Үүний зэрэгцээ олон нийтэд тодорхой болгох зорилгоор бүхий л хүчин төгөлдөр, нийтэд дэлгээгүй гэрээг системтэйгээр хянан үзэх, үүнд гэрээний бүрэн эх, хавсралт болон баримт бичгийг бүрэн хянан үзэх үйл явц хийгдээгүй байна. 2019 оноос хойш шинээр гэрээг нийтэд зориулан ил тод болгоогүй. Гэрээний ил тод байдлын чиглэлээрх Монголын ОУИТБС-ын үйл ажиллагааг Шаардлага 2.4 дээр заасанчлан ашигт малтмал, уул уурхайн тусгай зөвшөөрлийг багтаан өргөжүүлээгүй хэвээр байна. Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэг нь өөрийн 2022 оны ажлын төлөвлөгөөнд 2020- 2022 онд хийсэн бүхий л гэрээг ил тод болгохоор тусгажээ. Гэвч Монголын ОУИТБС-ын хувьд хуучин хийгдсэн гэрээнүүд (жишээ нь газрын тос, байгалийн хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ), мөн зарим гэрээний хавсралт болон нэмэлт өөрчлөлт зэргийг бүрэн ил тод болгох чиглэлээр хэрхэн ажиллаж буй нь тодорхойгүй байгаа ч Шаардлага 2.4а дээр зөвхөн 2021 оноос өмнө байгуулагдсан гэрээг ил тод болгохыг зөвлөмж болгодог. Тиймээс Монгол улс нь 2021 оноос өмнө болон хойш хийгдсэн гэрээнүүдийг ил тод болгох журам, арга ажиллагааг тодорхой болгох, үүнд хүртээмжийг сайжруулах чиглэлээр ахиц дэвшил гаргасан ба Олон улсын Ажлын албаны зүгээс олборлох үйлдвэрлэлийн компаниудын гэрээнд заасан эрх, үүргийг талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах энэхүү зорилтын ихэнх хэсэг биелэгдсэн хэмээн үзсэн.

Монгол улс нь 2015 оноос ОУИТБС-ын тайлагналаар дамжуулан компаниудын зүгээс байгаль орчны нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлж буй мөнгөн дүнд хяналт хийж ирсэн ч энэхүү мэдээллийг саяхнаас улам өргөжүүлж, байгаль орчны менежмент, хөрөнгө оруулалтын мониторингийн хамаарах хуулийн зүйл заалт, захиргааны акт, мөн бодит практикийг ил тод болгож байна. Байгаль орчны мэдээллийн төвийн вэбсайт нь батлагдсан [байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ](#) болон [байгаль орчны аудитын тайлангуудыг](#) ил тод нийтэлж буй ч компаниудын [байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг](#) онлайн хэлбэрээр орж үзэх боломжгүй байна. Монголын ОУИТБС-ын тайлан нь компаниудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөө, байгаль орчны нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлсэн хөрөнгө зэргийг тусгаж буй ч иргэний нийгмийн зүгээс хамгийн ихээр сонирхож буй мэдээлэл болох байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй компаниудын жишээг оруулахгүй байна. Монголын ОУИТБС-ын хувьд өөрийн мэдээллийн хүрээнд уул уурхайн компаниуд хуулиар болон гэрээгээр хүлээсэн байгаль орчны үүргүүдээ даган мөрдөж буйг хянах, хариуцлагын механизмын үр ашигтай байдлыг талаар үнэлэх зэрэг боломж байна.

### **Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ**

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.



ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Эрх зүйн орчин болон санхүүгийн горим (Шаардлага #2.1)</b></p> <p><i>Давуулан ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 2.1-ыг давуулан ханган биелүүлсэн хэмээн дүгнэж байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарын эрх зүй, зохицуулалтын орчны талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилт ханган биелэгдсэн эсэх дээр ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс ямар нэгэн санал бодол илэрхийлээгүй ч хууль, журмууд хэрэгжиж эхлэнгүүт тэднийг олон нийтэд ил тод болгодог ерөнхий орчин бүрдсэнийг зөвшөөрч байна (иргэний нийгмийн зүгээс Шаардлага 1.3-д хамаарах хууль, журмын төслүүдийг хүргүүлэхэд асуудалтай буйг илэрхийлснээс бусдаар). Хатуу шатах түлш болон эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчин, санхүүгийн горим, институцын орчны талаарх тойм тайлбарыг төрийн вэбсайтууд болон ОУИТБС-ын тайлангаар ил тод мэдээлдэг. Монгол улс нь мөн жил тутамд олборлох үйлдвэрлэлийн салбарт хийж буй болон хийгдэхээр төлөвлөж буй шинэчлэлийн талаар тойм мэдээлэл гаргах зэргээр илүү үр дүнг гаргаж буй ч олборлох үйлдвэрлэлийн салбарт хийгдэж буй болон хийгдэх эрх зүй, зохицуулалтын шинэчлэлийг хараахан системтэйгээр ил тод болгохгүй байна. Зарим талын зүгээс 2021 оноос эхлэн хууль, журмуудын Англи хэл дээрх хувилбарыг эхийг хамтаар нийтэлж эхэлсэн хэмээн буй ба үүнийг салбарт ихээр хийгдэж буй гадаадын хөрөнгө оруулалтын хувьд чухал алхам гэж үзжээ. Монголын ОУИТБС-ны Ажлын албаны зүгээс өгсөн тайлбарт 2022 оны 5 дугаар сараас шинээр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр хамаарах төрийн байгууллагууд нь эцсийн өмчлөгч, худалдан авалт, гэрээ, тусгай зөвшөөрөл болон ТӨК-иудын мэдээллийг ил тод болгох үүрэг хүлээх болсон нь ОУИТБС-ын шаардлагыг давуулан хангасан хэрэг хэмээн үзжээ. Харин иргэний нийгмийн зүгээс анхдагч үнэлгээг “ихэнх хэсгийг хангасан” болгон харгалзах оноон бууруулах санал гаргасан ба учир нь хийгдэж буй болон төлөвлөж буй эрх зүй, зохицуулалтын шинэчлэлийн талаар системтэй ил тод болгох явц дутмаг буй хэмээн үзжээ. Эдгээрийг тэнцвэржүүлэн Ажлын албаны зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбартай хамаарах хийгдэж буй шинэчлэл, өөрчлөлтийг цаг тухайд нь шуурхай ил тод, системтэй мэдээлж буй, санаачилгын тайлан нь үүнийг судлан тогтоож буй тул Шаардлага 2.1-ийг давуулан биелүүлсэн хэмээн үзсэн.</p>
<p><b>Гэрээ (Шаардлага #2.4)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албанаас Шаардлага 2.4-ийн ихэнх хэсгийг бүрэн ханган биелүүлсэн хэмээх дүгнэлт өгч байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх оролцогч талын зүгээс олборлох салбарын компаниудын гэрээгээр хүлээсэн эрх, үүргийн талаарх олон нийтийн нийтлэг ойлголтыг бүрдүүлэх зорилтын ихэнх хэсгийг ханган биелүүлсэн ч 2020 оноос хойш хийгдсэн гэрээнүүд ил тод болоогүй гэж үзжээ. 2021 оноос өмнө хийгдсэн олон тооны гэрээ ил тод болсны зэрэгцээ хэд хэдэн гэрээний хувьд гол хугацаа, нөхцөлүүдийг багтаасан хамаарах хавсралт нь байхгүй. 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн чиглэлээр шинэ гэрээ хийгдсэн эсвэл хуучин гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон эсэх тодорхойгүйн зэрэгцээ энэ хугацаанд олон зуун хайгуул,</p>

	<p>ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгожээ. Хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн текстээр нь ил тод болгосон тохиолдол байхгүй.</p> <p>Портал дээр нийт 895 гэрээ болон 162 хураангуйг ил тод болгоод буй ч үүнд Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнээс эхлээд компани болон орон нутаг хооронд хийгдсэн Орон нутгийн хөгжлийн гэрээ зэрэг олон төрлийн гэрээ багтжээ. Монголын ОУИТБС нь бүх гэрээг ил тод болгох зорилт дэвшүүлсэн ба үүнд 2022 оны <a href="#">Ажлын төлөвлөгөөний</a> Зорилт 6 нь 2020- 2022 онуудад хийгдсэн бүх гэрээг ил тод болгохоор заажээ. Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг ашиглан ашигт малтмал, газрын тос болон байгалийн хийн хайгуул, олборлолтод хамаарах бүхий гэрээг ил тод болгох төрийн бодлогын хэрэгжилтийг баримтжуулан, түгээж байна. Гэвч төрийн зүгээс тусгай зөвшөөрлийг бүрэн текстээр нь ил тод болгох бодлого, бодит үйл ажиллагаа н тодорхойгүй хэвээр байна. Гэсэн ч иргэний нийгмийн (ННФ, ТАН эвсэл) Монгол улсын нээлттэй гэрээний <a href="#">порталыг</a> бий болгох үйл ажиллагааг ОУИТБС болон УУХҮЯ-тай хамтран санаачлан хэрэгжүүлжээ. Энэ нь үүл уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт хийгдсэн гол гэрээнүүдийг ил тод болгох чиглэлээр томоохон алхам болжээ. Ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн хайгуул, ашиглалтыг зохицуулсан гэрээнүүдийн дийлэнх нь ил тод болсон ч үйлдвэрлэлийн шатанд компаниудтай (Петро Чайна болон Доншин) хийсэн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хавсралтууд дутуу зэрэг асуудал байна. Нөгөө талаар үүл уурхайн тусгай зөвшөөрлийг бүрэн текстээр нь олон нийтэд ил болгоогүй, бүрэн текст гэхээс илүү тусгай зөвшөөрлийн хугацааны тухай хязгаарлагдмал текстэн мэдээлэл АМГТГ-ын кадастрын <a href="#">портал</a> болон Монголын нээлттэй мэдээллийн лаб <a href="#">портал</a> дээр нээлттэй байна. Уул уурхай, байгалийн хий болон газрын тосны салбарын хүчин төгөлдөр бүх тусгай зөвшөөрлийг, үүнд хамаарах хавсралт, нэмэлт, дагалдах нөхцөлийн хамтаар системтэйгээр судлан үзэж, аль нь ил тод, аль нь ил тод бус буйг харуулдаг (Монголын ОУИТБС эсвэл бусад тал) системтэй ханалт байхгүй. Монголын ОУИТБС нь гэрээний ил тод байдалтай холбоотой төрийн бодлого болон бодит үйл ажиллагаа хоорондын зөрүүтэй байдал, гажуудлын талаар ямар нэгэн тайлбар гаргаагүй, мөн үүнийг хийхэд тулгарч буй эрх зүйн эсвэл зохицуулалтын саад тотгорын талаар тайлбарлаагүй ч оролцогч талуудын зүгээс бүх гэрээний баримт бичгийн ил тод болгоход ямар нэгэн эрх зүйн саад тотгор байхгүй ажээ. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа шинээр батлагдан, 5 дугаар сараас эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгох, гэрээ хийхэд эдгээрийг олон нийтэд ил тод мэдээлж байхаар заасныг цохон тэмдэглэсэн. Тус тайлбарт мөн Нээлттэй гэрээний вэбсайт болон АМГТГ-ын кадастрын порталын ач холбогдлыг тэмдэглэсэн.</p>
<p><b>Байгаль орчинд нөлөөлөх байдал (Шаардлага #6.4)</b></p> <p><i>Үнэлээгүй</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 6.4 дээр Баталгаажуулалтын хамаарах хугацааны хэрэгжилт дээр нь үнэлгээ хийгээгүй. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгэм, хөгжлийн түнш байгууллагуудын зүгээс сүүлд гарсан ОУИТБС-ын тайланд байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаар нэмэлт мэдээлэл гарган өгснийг өндрөөр үнэлсэн ч иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарын компаниудын</p>

	<p>байгаль орчны үүрэг хариуцлагаа хэрхэн даган мөрдөж буйг үнэлж байх зорилго бүрэн биелэгдсэн хэмээн үзэхгүй, байгаль орчны менежментийн хэрэгжилтийн чиглэлээр илүү их хяналт тавих шаардлагатай хэмээн үзжээ. Хэд хэдэн ИНБ-ын зүгээс мөн компаниудын зүгээс байгаль орчны нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлж буй хөрөнгөний менежментийн талаар асууж, энэ чиглэлээр ил тод байдлыг илүүтэй сайжруулах хэрэгцээтэй буйг дурдсан. Ярилцлагад хамрагдсан салбар болон төрийн төлөөлөл нь энэ асуудлаар алив санал бодол илэрхийлээгүй, харин ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцож буй иргэний нийгмийн хувьд энэ нь тэргүүлэх асуудал гэдгийг тэмдэглэсэн. Олон улсын Ажлын албаны зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарт байгаль орчны менежментийн дүрэм, журмуудын тодорхой болгохоор гаргаж буй хичээл зүтгэлийг үнэлж буй ч олон нийтийн зүгээс мэдээлэл шаардаж буй эрэлтэд нийцэхүйц хэмжээнд шаардлагыг хангаагүй, ялангуяа байгаль орчны менежментийн үүрэг хариуцлагаа даган мөрдөөгүй компаниудыг ил тод болгох чиглэлд хангалтгүй хэмээн үзсэн.</p> <p>Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг ашиглан нь байгаль орчны менежмент болон олборлох салбараас хийж буй хөрөнгө оруулалтыг хянах эрх зүйн зүйл заалтууд, захиргааны актууд болон бодит үйл ажиллагааг тодруулахад ашиглаж иржээ. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь ус ашиглалт, хог хаягдлын удирдлагын асуудлыг тусгажээ. Гэвч энэ чиглэлд хийгдэж буй болон төлөвлөгдөж буй шинэчлэлийн талаар өргөжүүлэх, мөн Байгаль орчны мэдээллийн сан зэрэг төрийн байгууллагатай хамтран ажиллаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайлангуудын онлайн хэлбэрээр ил тод болгох боломж байна. Монголын ОУИТБС нь байгаль орчны байнгын мониторингийн журам, захиргааны процесс, болон байгаль орчныг нөхөн сэргээх хөтөлбөрийн талаарх мэдээллийг ил тод болгож байна. Энэхүү цар хүрээ нь хараахан зөрчил гаргасан тохиолдолд тооцох хариуцлагыг хамраагүй, олборлох үйлдвэрлэлийн компаниудын байгаль орчны чиглэлийн үүрэг хариуцлагын талаарх иж бүрэн тоймыг тусгаагүй. Эдгээр асуудлаар мэдээлэл авах олон нийтийн сонирхол өндөр буйг ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс дурдсан. Шаардлагад хамаарах зарим зүйлсийг бүрэн дүүрэн хангаагүй тул Шаардлага 4.6-г бүрэн хангасан хэмээн үзэх боломжгүй тул үнэлээгүй үлдээсэн. Гэвч Монголын ОУИТБС-ын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн чиглэлээр хэрэгжүүлж буй ажил нь үндэсний хэмжээний тэргүүлэх чиглэлтэй уялдаа холбоотой буйг энэхүү тайлангийн эхэн хэсэгт буй үр дүнтэй байдал, тогтвортой байдлын үзүүлэлт дээр цохон тэмдэглэсэн болно.</p>
<p><b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• ОУИТБС-ын хэрэгжилтийг улам сайжруулах зорилгоор Монгол улс нь олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглал болон төсвийн удирдлагын менежментэд хийгдэхээр төлөвлөж буй болон хийгдэж буй шинэчлэлийг хамаарах төрийн байгууллагууд системтэйгээр ил тод болгож байх арга замыг эрэлхийлж болно. Сүүлийн жилүүдэд олборлох үйлдвэрлэлийн салбарт шинэтгэл хурдацтай хийгдэж буйг, зохицуулалтын чиглэлээр шинэчлэл хийх олон нийтийн сонирхол өндөр буйг харгалзан Монгол улс нь Ажлын хэсэг болон орон нутагт хүрч ажиллах боломжоо</li> </ul>	

ашиглан эрх зүй, зохицуулалтын шинэчлэлийн хэрэгжилтэд зөвлөмж өгөх, мониторинг хийх боломжуудыг иргэдэд ханган өгөх боломжтой.

- Шаардлага 2.4 дээр заасны дагуу Монгол улс нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш газрын тос, байгалийн хий, ашигт малтмал ашиглах чиглэлээр хийгдсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан, хүчин төгөлдөр болсон бүх гэрээ эсвэл тусгай зөвшөөрлийг бүтэн текст, хамаарах хавсралт, баримт бичиг, нэмэлт өөрчлөлтийн хамтаар иж бүрнээр нь ил тод болгох шаардлагатай. Монгол улс нь хүчин төгөлдөр буй бүхий л гэрээ, тусгай зөвшөөрлийн жагсаалтыг гаргаж, аль нь олон нийтэд нээлттэй, аль нь хаалттай болохыг тодорхойлон гаргах нь зөв. Олон нийтэд ил тод болсон бүхий гэрээ, тусгай зөвшөөрлийн хувьд эдгээрийг ил болгосон буй холбоос эсвэл байршлыг заан өгсөн байх шаардлагатай. Хэрэв гэрээ, тусгай зөвшөөрлийг нийтэд ил болгоогүй буй бол үүнд тулгарч буй эрх зүйн болон практик саад тогторыг тодорхойлон баримтжуулсан байх нь зүйтэй. Ил тод болгож буй арга ажиллагаа нь гэрээ, тусгай зөвшөөрлийг ил тод болгох төрийн бодлого эсвэл хууль тогтоомжоос гажиж буй бол үүний талаарх тайлбарыг заавал оруулсан байх нь зөв.
- Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь Монгол улс дахь олборлох салбарын байгаль орчны менежмент болон хөрөнгө оруулалтын мониторингтой холбоотой эрх зүйн зүйл заалтууд, захиргааны актыг ил тод болгоход өөрийн ОУИТБС-ын хэрэгжилтийг ашиглах боломжтой. Монгол улс нь мөн байнга хийгддэг байгаль орчны мониторингийн процедурууд, Засгийн газрын захиргааны болон хариуцлагын үйл явцыг, түүнчлэн байгаль орчны хамааралтай үүрэг хариуцлага, нөхөн сэргээлтийн хөтөлбөр зэрэгт хамаарах мэдээллийг ил тод болгож байх нь зүйтэй.

## Тусгай зөвшөөрөл, хөрөнгийн эрх (Шаардлага 2.2, 2.3)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Монгол улсын уул уурхайн салбарт өмнө нь олон тооны тусгай зөвшөөрөл олгосон түүхтэй ч байгалийн хий, газрын тосны салбарын хамгийн сүүлийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ 2016 онд байгуулагджээ. Өмнө хийгдсэн Баталгаажуулалтад хамаарах хугацаанд (2016) нийт уул уурхай, газрын тос, байгалийн хийн чиглэлээр 716 тусгай зөвшөөрөл олгогдож, 148 уул уурхайн тусгай зөвшөөрөл шилжсэн байна. Энэ удаагийн Баталгаажуулалтад хамаарах хугацаанд (2020) нийт 90 тусгай зөвшөөрөл олгогдож, 83 тусгай зөвшөөрөл шилжсэн ч байгалийн хий, газрын тосны салбарт шинээр зөвшөөрөл олгогдоогүй. 2016- 2020 оны хугацаанд нийт хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо харьцангуй тогтвортой 2000-2500 орчимд байсан нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах болон шинээр олгох тоо ойролцоо байсантай холбоотой.

Монгол улс нь ОУИТБС-ын тайланг ашиглан уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхэд баримтлах процедурыг тодорхой болгож ирсэн. Гэвч хамгийн сүүлийн (2019-2020) ОУИТБС-ын тайланд тусгай зөвшөөрөл олгож буй үйл ажиллагааг тусган мэдээлэхээ зогсжээ. 2020 оны ОУИТБС-ын тайлангийн нэг хавсралт дээр Засгийн газрын тогтоолоор ТӨК-иудад шууд олгосон 6 тусгай зөвшөөрлийг тусгасан ба эдгээр нь АМГТГ-ын зохион байгуулдаг сонгон шалгаруулалтын журмаас гажсан үйлдлийг харуулж байна. 2016- 2017 оны ОУИТБС-ын тайланд Хараат бус аудиторын тайлбарласан дүрэм журам, арга ажиллагаа нь

2019- 2020 онд өөр Хараат бус аудитор ажилласантай холбоотойгоор ихээхэн ялгаатай буй нь ажиглагдаж байна. ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэг засгийн газрын (АМГТГ, УУХҮЯ) хамаарах вэбсайтаар системтэй ил тод болгох явдлыг баталгаажуулснаар ил тод байдлын чиглэлээр үр дүн гаргах тодорхой боломж байна.

Монгол улс дахь олборлох салбарын мэдээллийн гол хоёр портал болох АМГТГ-ын [кадастрын портал](#), ОУИТБС-ын [нээлтэй мэдээллийн портал](#) нь тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргасан огнооноос бусад ОУИТБС-ын Стандартад заасан, шаардлагатай бүх мэдээллийг хангаж байна. Шинээр тусгай зөвшөөрөл авах өргөдөл, олгосон тухай мэдээллийг АМГТГ-ын сар тутмын мэдээлэл дээр гаргадаг ч өргөдөл гаргасан огнооны хувьд хуучин олгогдсон тусгай зөвшөөрлүүд дээр өнөөг хүртэл ил тод бус байна. АМГТГ-ын порталд шинэчлэл сайн хийгдэхгүй буй нь кадастрын системийн программ хангамжийн асуудал, төсөв дутмаг буйтай холбоотой. Ажлын албаны зүгээс эдгээр техникийн шинжтэй асуудал нь материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй, олборлох үйлдвэрлэлийн салбарын хөрөнгийн эрхийн мэдээллийг ил тод болгох зорилго баталгаажуулалтын хугацаанд биелэгдсэн хэмээн үзэж байна.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Гэрээ болон тусгай зөвшөөрөл авах эрх хуваарилалт (Шаардлага #2.2)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны үнэлгээгээр Шаардлага 2.2-ын ихэнх хэсгийг Монгол улс ханган биелүүлсэн хэмээн дүгнэж байна. Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан эсэх дээр ямар нэгэн санал илэрхийлээгүй ч бүх талын төлөөллөөс АМГТГ-ын тусгай зөвшөөрөл олгох дүрэм жураас гажсан үйл ажиллагаа баталгаажуулалтад хамаарах хугацаанд явагдсан гэж үзсэн ба жишээ нь Засгийн газраас тогтоол гарган ТӨК-д ямар нэгэн сонгон шалгаруулалтгүй тусгай зөвшөөрөл олгосон байна. Олон улсын Ажлын алба нь өмнө нь Монголын ОУИТБС-ын зүгээс хийж байсан тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хийх шинжилгээг 2019, 2020 онуудын санхүүгийн жилд хийгээгүй тул тусгай зөвшөөрөл олгох процесст буй сул талуудыг олж тогтоох зорилтын ихэнх хэсэг энэхүү баталгаажуулалтын хугацаанд хангагдсан хэмээн үзсэн.</p> <p>Салбарын зохицуулагч байгууллага болох АМГТГ-ын зүгээс өөрийн сар тутмын <a href="#">статистикийн мэдээгээр</a> системтэйгээр ил тод болгодог нь олгосон тусгай зөвшөөрлүүдийг олж тогтоох боломжийг олгодог бол ОУИТБС-ын тайлан нь тусгай зөвшөөрөл, гэрээ болон шилжүүлсэн байдлыг ил тод мэдээлдэг. 2020 онд нийт 90 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 83 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн ч газрын тос, байгалийн хийн салбарт тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаа хийгдээгүй. Монголын ОУИТБС-ын 2020 оны тайланд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх хуульд заасан процедурыг</p>

	<p>тайлбарласан ч зөвхөн сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгоход баримтлах техникийн шалгуур үзүүлэлтүүдийг тусгаж, тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд тавигдах техникийн болон санхүүгийн шаардлагуудыг орхигдуулжээ. Төрийн албан тушаалтнууд болон Хараат бус аудиторын зүгээс Ашигт малтмалын хуульд тусгай зөвшөөрөл олгоход тавигдах техникийн болон санхүүгийн шаардлагуудыг ерөнхийлөн тусгасан ч үүнийг дагалдан гарсан журам нь зөвхөн техникийн шаардлагыг дэлгэрэнгүй зааж өгсөн болохын ОУИТБС-ын тайланд тоймлон оруулсан ба санхүүгийн шаардлагыг оруулаагүй байна. Тиймээс ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс уул уурхайн тусгай зөвшөөрөл олгоход санхүүгийн шаардлагуудын бодит байдал дээр үнэлдэггүй гэж үзжээ. Ярилцлагаар мөн 2020 оны ОУИТБС-ын тайланд дурдсан тусгай зөвшөөрөл шилжүүлэх процессын талаарх тайлбар нь үнэн зөв бус, тусгай зөвшөөрөл шилжүүлэн авч буй компанид ямар нэгэн техникийн болон санхүүгийн шаардлага тавигдахгүй байна. Баталгаажуулалтын тайланд өгсөн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь хамгийн сүүлд гарсан тайлан (2020) нь тусгай зөвшөөрөл олгох шалгууруудыг багтаасан ба цаашид улам сайжруулна хэмээн дурджээ. Гэвч сүүлд гарсан (2019 болон 2020 оны) ОУИТБС-ын тайлангууд нь хамаарах хугацаанд тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх үйл ажиллагааны талаарх тоймыг өмнөх тайлангуудын (2016 болон 2017) адил оруулаагүй. Түүнчлэн 2020 онд олгосон тусгай зөвшөөрөл нэг бүрээр өргөдөл гаргасан сонгон шалгаруулалтад орсон талуудын бүрэн жагсаалт нь олон нийтэд ил тод болоогүй. Зарим оролцогч талын зүгээс тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь <a href="#">авлигын эрсдэлтэй</a> хэмээн олон нийтийн зүгээс үздэг болохыг дурдсан. Бүх талыг төлөөлөн ярилцсан талуудын зүгээс 2022 онд Засгийн газар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан тусгай зөвшөөрлийг цахимаар олгох системд шилжихийн зэрэгцээ түрүүлж ирсэн нь түрүүлж авах өргөдлийн системийг сэргээхээр төлөвлөж буйг дурдсан. Энэ нь Монголын ОУИТБС-д хяналтын механизмыг тусгай зөвшөөрөл олгох үйл явцтай уялдуулж, ингэснээр жил тутмын тайлагнал нь тодорхой үр дүнд хүрч болох юм.</p> <p>2020 онд газрын тос, байгалийн хийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгоогүй ч ОУИТБС-ын тайлан нь газрын тос, байгалийн хийн салбарт тусгай зөвшөөрөл олгох хуульд заасан журмын талаар тайлбарласан. Гэвч тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд анх авсантай нь адил техникийн болон санхүүгийн шаардлага тавигддаг эсэх нь тодорхойгүй байна. Ярилцлагад хамрагдсан төрийн албан хаагчдын зүгээс Бүтээгдэхүүн хуваах гэрээн дээр тухайн өмнөх нөхцөл л хэвээр буй бол эрх шилжүүлэхэд ямар нэгэн шаардлагыг үнэлэн үздэггүйг хэлсэн. Албан тушаалтнуудын хэлж буйгаар АМГТГ нь гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд шинээр хийж буй хэмээн үздэг болохыг цохон тэмдэглэсэн. Тиймээс Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь өөрийн ОУИТБС-ын тайлагналыг тусгай зөвшөөрөл олгох, гэрээ хийх процессыг тодорхой болгоход ашиглаж ирсэн ч үүнийг 2018 оноос хойш гарсан тайлангийн тусгай зөвшөөрөлтэй хамаарах хэсэг дээр баримтжуулан оруулаагүй гэж үзсэн.</p>
<p><b>Тусгай зөвшөөрлийн</b></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс Шаардлага 2.3-ыг бүрэн ханган биелүүлсэн хэмээх дүгнэлтийг өгч байна. Ярилцлагад хамрагдсан бүх талуудын зүгээс Монгол улс дах тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийн хүртээмжид сэтгэл ханамжтай байна. Олон улсын Ажлын албаны зүгээс олборлох салбарын</p>



<p><b>бүртгэл (Шаардлага #2.3)</b></p> <p><i>Бүрэн ханган биелүүлсэн</i></p>	<p>орд газар, төслүүдийн хөрөнгийн эрхийн талаарх иж бүрэн мэдээллийн хүртээмжийг хангах зорилт биелэгдсэн хэмээн үзсэн.</p> <p>Монгол улсад уул уурхай, газрын тос болон байгалийн хийн кадастрын мэдээллийн хоёр гол эх үүсвэр буй бөгөөд эдгээр нь анхдагч эх үүсвэр нь нэг гэхдээ мэдээлэл ил тод болгож буй түвшин нь ялгаатай байна. Салбарын зохицуулагч байгууллага АМГТГ нь үндсэн <a href="#">кадастрын порталыг</a> ажиллуулдаг ба бусад байгууллагууд үүнийг гол мэдээллийн эх сурвалж болгон ашигладаг. Энэ портал нь бүх тусгай зөвшөөрлийн мэдээллийг Шаардлага 2.3b дээр заасны дагуу түгээдэг ч өргөдөл гаргасан огноо, олгосон огноо болон дуусах огноо нь ил тод бус. Монголын ОУИТБС-ын <a href="#">нээлтэй өгөгдлийн портал</a> нь АМГТГ-аас кадастрын мэдээлэл авдаг ч нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгосон огноо болон дуусах хугацааг нь ил тод мэдээлдэг. Өмнө олгогдсон хайгуул, ашиглалтын хуучин зөвшөөрлүүд дээр өргөдөл гаргасан огноо нь ил тод бусын зэрэгцээ АМГТГ-ын <a href="#">статистикийн мэдээлэл</a> сар тутмын тусгай зөвшөөрөл авахаар гарсан өргөдөл болон олгосон байдлыг мэдээлдэг. Ярилцлагад хамрагдсан төрийн албан тушаалтнуудын зүгээс АМГТГ-ын кадастрын системийн анхлан хөгжүүлсэн байгууллагатай гэрээ байгуулан тус порталыг шинэчлэн өргөдөл гаргасан огноо, олгосон огноо, дуусах огноог ил тод болгох зардал нь маш өндөр гэж буй ч ОУИТБС-ын портал нь олгосон болон дуусах огноог ил болгож байна. Олон улсын Ажлын албаны зүгээс хуучин олгосон тусгай зөвшөөрлүүдийн анх өргөдөл гаргасан огноо байхгүй нь материаллаг зөрүү үүсгэхгүй хэмээн үзэж байна.</p>
<p><b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлага 2.2 дээр заасны дагуу Монгол улс нь хамгийн сүүлд бэлтгэгдсэн ОУИТБС-ын тайланд хамрах хугацаанд шинээр олгосон эсвэл шилжүүлсэн бүхий л тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил тод болгож, үүнд тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой хууль болон журмаар заасан процессоос гажсан ямар нэгэн үйлдэл гарсан эсэх дээр үнэлгээ хийн ил тод мэдээлж байх нь зүйтэй. Ашигт малтмалтай холбоотой гэрээ хэлцэл хийх, тусгай зөвшөөрөл олгох өөр арга замыг (жишээ нь өрсөлдөөнт сонгон шалгаруулалт эсвэл шууд гэрээ) Засгийн газар сонгон хэрэгжүүлэх тохиолдолд, тусгай зөвшөөрөл олгох эсвэл шилжүүлэх үйл явцын талаарх тайлбарыг гаргаж, үүнд тухайн үйлдэлд ямар журам баримтлах ёстой болон яагаад тухайн журмаар олгосон/шилжүүлсэн болохыг тайлбарлаж байх шаардлагатай. Тусгай зөвшөөрлийг тендерээр олгосон бол Засгийн газар нь тендерт оролцогчдын жагсаалт, тавигдсан шалгуур зэргийг ил тод мэдээлэх шаардлагатай. Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-ын хүрээнд тусгай зөвшөөрөл олголтыг нэмэлтээр шаарддаг мэдээлэл болгож болно. Үүнд тусгай зөвшөөрөл олгох процедурын үр дүнтэй, үр ашигтай байдлын талаарх тайлбар, процедурын тайлбар, бодит практик болон тусгай зөвшөөрөл, гэрээг шинэчлэх, түдгэлзүүлэх болон цуцлах үндэслэл зэргийг багтааж болно.</li> <li>• Санаачилгын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Монгол улс нь олон нийтэд бүртгэлтэй кадастрын систем эсвэл бүртгэлийг ажиллуулж, үүнд уул уурхай, газрын тос, байгалийн хийн бүхий л хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл нэг бүрийн өргөдөл гаргасан болон олгосон огноо, дуусах огноог багтаасан шуурхай, иж бүрэн мэдээллийг түгээж байх шаардлагатай. Тухайн кадастрын систем эсвэл бүртгэл байхгүй бол олон нийтэд ил тод болгоход гарч буй алив хийдлийг ил тод мэдээлж, системийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй хүчин чармайлтаа баримтжуулж байх шаардлагатай.</li> </ul>	

## Эцсийн өмчлөгч (Шаардлага 2.5)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын талаарх Шаардлага 2.5-ийг биелэлтийг 2019 оны 6 дугаар сард Удирдах зөвлөлийн зөвшөөрсөн хүрээнд багтаан 2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үнэлсэн.<sup>1</sup> Үнэлгээ нь техникийн болон үр дүнтэй байдлын үнэлгээнээс бүрдсэн.

#### Техникийн үнэлгээ

Техникийн үнэлгээ нь Шаардлага 2.5-д хамаарах хэсгийн Ил тод байдлын маягтад тусгагдсан. Энд өгөгдсөн мэдээлэл нь Монгол улс эдийн засгийн бүх салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эцсийн эзэмшигчийн мэдээллийг цуглуулах эрх зүйн орчныг бий болгосныг харуулж байна. Хэдий энэхүү Баталгаажуулалт нь Шаардлага 2.5-д хамаарах бүхий л заалтын хүрээнд хийгдсэн ч эцсийн өмчлөгчийн талаарх Баталгаажуулалтын хүрээний 1 дүгээр шатны ихэнх шалгуур биелэгджээ. Эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулах, ил тод болгох эрх зүй, зохицуулалтын орчин бүрдэж, өмчлөлийн мэдээллийг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх компаниас гаргуулах ажил ид явагдаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий хууль нь эцсийн өмчлөгчийг тайлагнах босгыг 33% (гуравны нэг) байхаар заасан ч Монголын ОУИТБС нь олборлох үйлдвэрлэлийн компаниудад 5% байхаар тогтоон, энэхүү мэдээллийг цахим тайлагналын системээр авч байна. Өнөөгийн байдлаар уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 2263 компанийн 426-ынх нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг Монголын ОУИТБС-ын 2020 оны тайлангаар ил тод болгож, [вэбсайт](#) дээр дахин байршуулсны зэрэгцээ 2022 онд эхлүүлэх иргэний нийгмийн бие даасан вэбсайтад мөн ОУИТБС-ын мэдээллийг оруулахаар болжээ. Улсын бүртгэлийн ерөнхий газрын (УБЕГ) цуглуулсан эзэмшигчийн мэдээллийг 2022 оны 5 дугаар сараас эхлэн 2021 онд батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд нээлттэй болгох ба тухайн хуулиар бүх салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын талаарх төрд буй мэдээллийг олон нийтэд ил тод болгохоор заажээ. Гэвч баталгаажуулалтын ярилцлагаар ил тод болгох мэдээлэл нь зөвхөн эзэмшигчийн нар байх ба харин хувь эзэмшил/хяналтын хувь, эзэмшигчийн харьяалах улс болон хаягийг ил тод болгохгүй ажээ. Одоо УБЕГ-ын хуулийн этгээдийн [бүртгэл](#) нь хуулийн этгээдийн хууль ёсны эзэмшигчийн мэдээллийг ил тод болгохдоо зөвхөн нэрийг ил болгож, хувь хэмжээг ил болгодоггүй. ОУИТБС-ын Ажлын хэсэг нь Монгол улсад олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудын Монгол дахь салбар компаниудын жагсаалтыг гаргасан ч тухайн хөрөнгийн бирж дээрх бүртгэлийн мэдээллийг багтаагаагүй.

#### Үр дүнтэй байдлын үнэлгээ

Монгол улс нь Шаардлага 2.5-ын ихэнх хэсгийг ханган биелүүлэх чиглэлээр ахиц дэвшил гаргажээ. Үүний үр дүнд эрдэс баялгийн салбарт тусгай зөвшөөрөл авах, гэрээ хэлцэл хийх хүсэлт

---

<sup>1</sup> <https://eiti.org/document/assessing-implementation-of-eitis-beneficial-ownership-requirement>.

гаргаж буй бүх компани одоо өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг УБЕГ-т гарган өгсөн байх үүрэгтэй болжээ.

2017 онд Монгол улс нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга хэмжээг ФАТФ-ын хамтын үнэлгээний хүрээнд үнэлүүлсэн. Энэхүү үнэлгээгээр Монгол улс нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулах чиглэлээр “үндсэндээ шаардлага хангасан” хэмээн дүгнэгдсэн ч эдгээр арга хэмжээний үр дүнгийн хувьд ФАТФ-ын Үр дүн 5-д хамаарах шалгуур үзүүлэлтээр “доогуур” гэсэн үнэлгээг авсан. Үүний улмаас Монгол улсыг ФАТФ-ын “нэмэгдүүлсэн хяналтад хамрагдах улсын” (саарал жагсаалт) жагсаалтад оруулж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулж, төрийн зүгээс эцсийн өмчлөгчийн мэдээллийг системтэйгээр цуглуулах боломжийг нээжээ. 2021 оны 9 дүгээр сард гарсан LTRC төслийн [тайланд](#) Монгол улс саарал жагсаалтаас гарснаар боломжийг алдаж, төрийн зүгээс тухайн асуудлыг хариуцах байгууллагагүй буйг дурджээ.

Монгол улс дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдалд тулгарч буй өөр нэгэн сорилт нь хууль ёсны болон эцсийн өмчлөгчийн алийг ил тод болгох дээр тулгарч байна. УБЕГ нь Шаардлага 2.5d дээр заасан өгөгдлийг цуглуулж буй ч зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдийн нэр, харьяалах улсыг л ил болгосон. Ярилцлагад хамрагдсан төрийн албан тушаалтнуудын зүгээс батлан хэлснээр 2022 оны 5 дугаар сараас ил тод болгох эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь эзэмшигчийн нэрийг л заах ба харин эзэмшиж эсвэл хяналтдаа байлгаж буй хувь, хяналтдаа байлгаж буй хэлбэр, харьяалах улс эсвэл хаяг зэргийг ил тод болгохгүй ажээ. Хэрэв зөв тооцсон бол энэхүү байдал нь Монгол улс дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах хүчин чармайлтад томоохон сул талыг авчирна.

Одоо нийтэлж буй хууль ёсны эзэмшлийн талаар судлан үзэхэд зарим томоохон уул уурхайн компаниуд нь УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлд ороогүй харагдаж байна. Хайлтын систем нь нэг бол УБЕГ-т бүртгэгдсэн буй компанийн улсын бүртгэлийн дугаараар эсвэл компанийн нэрээр хайх боломжтой ч үсгийг оруулах (том, жижиг үсэг гэх мэт) байдал нь хүндрэлтэй, компанийн нэрийн тодорхой хэсгийг оруулан хайлт хийх боломжгүй байна. Монголын ОУИТБС-ын цахим тайлангийн порталаар дамжуулан цуглуулсан одоогийн эцсийн өмчлөгчийн ил тод мэдээлэл нь (уул уурхайн 426 компанийн) ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх компанийг бүрэн хамраагүй. Гэсэн ч Монголын ОУИТБС-ын портал нь УБЕГ-ын компанийн бүртгэлтэй харьцуулбал хайлт хийх боломж нь илүү өндөр байв.

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад эцсийн өмчлөгчийн эзэмшиж буй хувь хэмжээг өөр өөрөөр тогтоосон буй нь ил тод болгон мэдээлэхэд хийдэл үүсгэж байна. УБЕГ нь бүх аж ахуйн нэгжээс эзэмшлийн 33%-тайгаар эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулж буй бол Монголын ОУИТБС нь 5%-ийн босготойгоор уул уурхайн компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллийг хүлээн авдаг. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн төлөөллийн зүгээс энэхүү зөрүүтэй байдлын талаар асуудалтай буйгаа илэрхийлсэн бол төрийн албан хаагчдын хувьд ялгаатай тодорхойлолтууд, босго хувь зэргийн талаар төөрөлдөж буйгаа илэрхийлсэн.

Монгол улсад ил тод байдлыг хангах чиглэлээр гарч буй үр дүнтэй байдлын талаарх дурдах шаардлагатай нэг зүйл нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг тайлагнаагүй тохиолдолд аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцож буй явдал ба захиргааны бусад зөрчлийн нэгэн адил 500,000

төгрөгийн (172 ам.доллар) торгууль ноогдуулж буй юм. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн талын зүгээс энэ нь хууль зөрчсөн хөрөнгө оруулагчийн хувьд бага мөнгөн дүн бөгөөд үр дүнтэй арга байж чадахгүй гэж үзжээ. Гэсэн ч Монгол улс нь олон нийтэд нээлттэй эцсийн өмчлөгчийн бүртгэл бий болгоход техникийн туслалцаа үзүүлдэг Олборлох үйлдвэрлэлийг ил тод болгох нь хөтөлбөрт 2021 онд нэгдэн орсон байна.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Эцсийн өмчлөгч (Шаардлага #2.5)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 2.5-ын ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээх дүгнэлтийг гаргаж байна. Ярилцлагад хамрагдсан ихэнх талуудын зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшиж, өргөдөл гаргаж буй бүх компанийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох зорилтын ихэнх хэсэг биелэгдсэн гэж үзсэн ч энэ зорилтыг хангахад гарч буй ахицын хувьд санал зөрүүтэй байна. Хэд хэдэн төрийн албан тушаалтны зүгээс 2022 оны 5 дугаар сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх, эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд ил тод болгохоор заасан хууль хэрэгжиж эхлэхэд энэхүү зорилт хангагдана гэж үзэж буй. Харин иргэний нийгмийн зүгээс эцсийн өмчлөгчийн тодорхойлолтууд хуульд янз бүрээр туссан, ил тод болгох босго хувь хэмжээ нь хуульд өөр өөрөөр заагдсан буй нь ил тод болгох мэдээллийн төрөл болон үнэн зөв байдалд сорилт учруулан гэж үзжээ.</p> <p>Засгийн газрын зүгээс эцсийн өмчлөгчийн ил тод байдлын чиглэлээр тодорхой бодлого батлан гаргаж, бүх салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг системтэйгээр цуглуулах, ил тод болгох үйл ажиллагааг 2018 онд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд хийсэн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд явуулж байна. Монгол улсын хууль тогтоомжуудад эцсийн өмчлөгчийг 4 өөр янзаар тодорхойлжээ. 2013 оны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль нь 2018 оны Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн үндэс болсон ба эдгээр нь тодорхойлолтын хувьд ОУИТБС-ын 2.5 дээр заасан тодорхойлолттой илүү ойр, аль нэг салбарыг дурдаагүй тодорхойлолтуудыг тусгажээ. 2010 оны Банкны тухай хууль, 2019 оны Татварын ерөнхий хууль болон 2013 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хууль нь эдийн засгийн үйл ажиллагаанаас нь хамааруулан өөр өөр тодорхойлолт ашигласан. Улс төрд нөлөө бүхий этгээд хэмээх ойлголтыг Монгол улсын хууль тогтоомжид хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг хүлээсэн албан тушаалтан хэмээн тодорхойлсон ч Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй компанийн улс төрд нөлөө бүхий эзэмшигчийг тодорхойлох ямар нэгэн процесс байхгүй. Мөн хуулиудад өөр өөр босго дүнг заасан нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 33%, Банкны тухай</p>

	<p>хуульд 5- 20%, Татварын ерөнхий хууль 30% зэрэг ялгаатай байна. Монголын ОУИТБС нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулах, ил тод болгоход өөрийн зүгээс 5%-ийн босго тогтоожээ. УБЕГ нь ил тод болгоходоо 33%-ийн босго баримталж байна.</p> <p>Бодит байдал дээр бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг УБЕГ-т хүргүүлэх үүргийг хүлээлгээд байна. Мөн уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх компани эцсийн өмчлөгчийн мэдээллээ Монголын ОУИТБС-ын цахим тайлангийн системд тайлагнах ёстой ч ОУИТБС-ын 2020 оны тайланд дурдсанаар нийт тусгай зөвшөөрөл эзэмшигч 2263 компанийн дөнгөж 426 нь л 2021 оны 12 дугаар сарын байдлаар тухайн мэдээллийг тайлагнажээ. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийт ил тод болгох ажлын одоо зөвхөн ОУИТБС л өөрийн жилийн тайлангаас эцсийн өмчлөгчийн мэдээллийг авч бүрдүүлсэн өөрийн бүртгэлийг ашиглан гүйцэтгэж байна. Ил тод сан ТББ нь мөн ОУИТБС-ын эцсийн өмчлөгчийн мэдээлэл ашиглан бие даасан <a href="#">вэбсайт</a> хөгжүүлжээ.</p> <p>2021 оны 10 дугаар сард батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба энэхүү хуулиар эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох үүргийг оногдуулжээ. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн зарим оролцогчийн зүгээс ямар мэдээллийг ил тод болгох дээр төрийн байгууллага өөрийн үзэмжээр шийдэх боломжтой буйг асуудал хэмээн үзэж, энэхүү шинэ хууль нь 2011 онд батлагдсан, зөвхөн улсын нууцтай холбоотой асуудлыг л үл хамаарах Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний хуулиас илүү хязгаарлалттай болсон хэмээн үзжээ. УБЕГ-ын зүгээс энэхүү мэдээллийг 2022 оны 5 дугаар сараас эхлэн ил тод болгож эхлэхэд дээрхийн ижил хийдэл мөн л үүсэх ба учир нь УБЕГ дээрх бүртгэлд буй хууль ёсны эзэмшигчийг ил тод болгож, үүнд зөвхөн эзэмшигчийн нэр орохоос эзэмшиж буй хувьцааг нээлттэй болгохгүй ажээ.</p> <p>Монголын ОУИТБС-ын зүгээс өнөөг хүртэл эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулж, ил тод болгож буй байдалд иж бүрэн шинжилгээ хийж гүйцэтгээгүй. Гэвч ОУИТБС-ын 2020 оны тайлан нь нийт 2263 компаниас 426 компанийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тусгасан нь үнэн зөв гэхээс илүүтэй иж бүрэн байдалд түлхүү төвлөрчээ. LTCR төслөөс 2021 оны 9 дүгээр сард хийсэн дэлгэрэнгүй судалгаа нь мэдээлэл цуглуулах явц болон эрх зүйн орчинтой холбоотой судалгаа хийсэн ч ярилцлагад хамрагдсан төрийн албан тушаалтнуудын зүгээс 2022 оны 3 дугаар сарын байдлаар 200,000 хуулийн этгээдийн 60% нь мэдээллээ ирүүлсэн хэмээн мэдээлсэн. Тиймээс эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгоход иж бүрэн байдал, дэлгэрэнгүй байдалтай холбоотой техникийн асуудлууд л үлдээд буй Ажлын албаны зүгээс тус улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хэн эцсийн байдлаар эзэмшиж, хянаж буйг олон нийтэд ил тод болгох зорилт биелэгдэх шатандаа байна хэмээн үзэж байна.</p>
--	---

### Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд

- Шаардлага 2.5 дээр заасны дагуу Монгол улс нь ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн хайгуул болон олборлолтын тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргаж буй болон тусгай зөвшөөрөл эзэмшиж буй, эсвэл гэрээ хийсэн буй аж ахуйн нэгжүүдийн олон нийтэд нээлттэй бүртгэлийг ажиллуулах ёстой ба үүнд эцсийн өмчлөгчийн мэдээлэл, эзэмшлийн түвшин, эзэмшил эсвэл хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг тухай дэлгэрэнгүй мэдээлэл багтаж байх шаардлагатай. Эцсийн өмчлөгчийн талаар олон нийтэд ил тод болгож буй мэдээлэлд түүний нэр, харьяалах улс, иргэншил, оршин суугаа улс болон улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тусгасан байна. Түүнчлэн тухайн өмчлөгчийн иргэний паспортын дугаар, төрсөн огноо, оршин суугаа болон ажлын хаяг, холбоо барих мэдээлэл зэргийг оруулсан байхыг зөвлөмж болгодог. Монголын ОУИТБС нь эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах механизмыг үнэлж, олборлох үйлдвэрлэлийн салбарын компаниудын зүгээс гарган ирүүлж буй эцсийн өмчлөгчийн мэдээллийг хэрхэн баталгаажуулах тухай зөвшилцөн шийдэх шаардлагатай. Монгол улс нь мөн хууль ёсны өмчлөгч, тэдгээрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар олон нийтэд мэдээж байх ёстой. Санаачилгын хэрэгжилтийн сайжруулахын тулд Монгол улс нь олборлох салбарын компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлын талаар үнэлгээ хийж, үр дүнг ил тод нийтэлж байх шаардлагатай ба үүнд Монголын ОУИТБС-ын зүгээс “өндөр эрсдэлтэй” хэмээн үзэж буй компаниудыг хамруулан, улмаар ил тод болгох үйл явцын улам нэмэгдүүлэн, сайжруулж байх нь зүйтэй. Монгол улс нь мөн эцсийн өмчлөгчийн мэдээллийн хүртээмжийг улам сайжруулах арга замыг, жишээ нь Ил тод сангийн ажиллуулж буй бие даасан [вэбсайтыг](#) Монголын ОУИТБС-ын порталтай уялдуулах арга замыг хайх шаардлагатай.

## Төрийн оролцоо (Шаардлага 2.6, 4.2, 4.5, 6.2)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын (ТӨК) үйл ажиллагааг 1997 оны Төрийн өмчийн тухай хуулиар зохицуулж буй бөгөөд 2022 онд энэхүү эрх зүйн орчинд [шинэчлэл](#) хийх төлөвлөгөөтэй байна. Монгол улсад гурван төрлийн ТӨК олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Эхнийх нь 100% төрийн өмчит компани бөгөөд үүнд зэсийн үйлдвэрлэлийн томоохон компани болох Эрдэнэт, Монголросцветмет зэрэг компани багтана. Хоёрдугаар төрөлд хамтарсан компаниуд багтах ба төрийн өмчийн оролцоотой, үлдэх хэсгийг нь хувийн хэвшил эзэмшдэг, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд байх үүнд Багануур ХК, Шивээ Овоо ХК, эсвэл хувийн хэвшил болон Монгол улсын иргэд эзэмшдэг Эрдэнэс Таван Толгой, Эрдэнэс Голд, Эрдэнэс Стийл, МонАтом зэрэг орно. Гуравдугаар ангиллын ТӨК-д стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслүүдийг эзэмших зориулалт бүхий компанийн охин компани, жишээ нь Эрдэнэс Монгол багтдаг.

2017 оноос хойш төрийн байгууллагууд, үүнд төрийн өмчит компаниуд (100% төрийн эзэмшлийн) 5 сая төгрөгөөс дээш хэмжээний (1,700 ам.доллар орчим) санхүүгийн бүх гүйлгээг ил тод мэдээлж байх үүргийг хуулиар ноогдуулсан ба үүнд хүлээн авсан орлого, худалдан авалт,



төрд төлсөн төлбөр багтаж, үүний зэрэгцээ өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг ил тод болгож байх үүргийг мөн ноогдуулсан. Ийнхүү ил тод болгож буй мэдээллийг Шилэн дансны [портал](#) дээр байршуулдаг. Гэвч ББЗХ ([2019](#) болон [2021](#)) зэрэг байгууллагууд Шилэн дансны порталд уул уурхайн салбарын ТӨК-иудын ил тод болгож буй мэдээлэлд үнэлгээ хийж, улмаар санхүүгийн тайлангаа ил тод болгох тал дээр хийдэл бүйг тогтоожээ. Энэхүү хийдлийг Монголын ОУИТБС-ын 2020 оны тайланд тусгасан ба Багануур, Эрдэнэс Монгол, Монголросцветмет зэрэг ТӨК-иуд өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаа ил тод болгоогүй талаар мэдээлжээ. Ярилцлагад хамрагдсан ТӨК-иудын төлөөллийн зүгээс энэ нь Шилэн дансны тухай хуулиар хамтарсан компани эсвэл ХХК хэлбэртэй компанийн хувьд тавигдах шаардлага бус гэж тайлбарласан ч энэ төрлийн хуулийн этгээд өөрийн сайн дурын үндсэн дээр байршуулах боломжтой хэмээн үзсэн.

Монгол улс нь ОУИТБС-ын тайланг ашиглан ТӨК болон Засгийн газар хоорондын санхүүгийн харилцааны мэдээллийг ТӨК-ийн системтэй ил тод болгох явц дээр суурилан төвлөрүүлж иржээ. Гэвч ТӨК-ийн зүгээс системтэйгээр ил тод болгох явцад гарч буй хийдэлд нэмэлт мэдээлэл ил тод болгуулах замаар бүрэн хэмжээгээр анхаарал хандуулахгүй байна. Монгол улсын сүүлд гарсан ОУИТБС-ын тайлангууд (2019 болон 2020) нь олборлох салбарын бүх 20 компанийг багтаасан ч ТӨК-иудын дахин хөрөнгө оруулалт, гуравдагч талын санхүүжилт зэрэгт хамаарах журам, арга ажиллагааг бүрэн хангалттай тодруулаагүй, мөн ТӨК-ууд нь хувь эзэмшдэг компани болон энэхүү хувьд хамаарах нөхцөл зэргийг тодруулаагүй байна. Монгол улс нь төр болон төрийн өмчит компаниудын зүгээс уул уурхайн компаниудад олгосон зээл, баталгааны нөхцөлийг тодруулах оролдлого хийж, ОУИТБС-ын тайланд ил тод байдалд тулгарч буй асуудлыг дурджээ. Иргэний нийгэм болон олон улсын байгууллагуудын зүгээс энэ төрлийн мэдээлэл ихээхэн хэрэгцээтэй буйг дурдсан ба үүний шалтгаан нь ТӨК-иудын өрийн хэмжээ ихээр нэмэгдэж буй, эдгээрт бусад төрийн байгууллагуудын зүгээс 2020- 2021 онуудад баталгаа гарган өгсөнтэй холбоотой. Монгол улс нь ТӨК-иудын компанийн засаглалын талаарх дүрэм журмуудыг тодруулах оролдлого хийсний зэрэгцээ ОУИТБС-ын ил тод мэдээллийг засаглалын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд ашиглах боломж байна. Монголын ОУИТБС нь ББЗХ-тэй хамтран ажиллаж олборлох салбарын сүлжээний шат бүрд буй, үүнд ТӨК-иудад буй авлигын эрсдэлийг үнэлэх аргачлалыг түршин хэрэгжүүлсэн.

Монгол улс нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлбөрөө бүтээгдэхүүн (Ашгийн тос) хэлбэрээр авах эрхтэй ч олборлолт явагдаж буй гурван талбайд ажиллаж буй операторууд нь Монгол улсад ногдох тосыг борлуулсан, орлогыг Сангийн яаманд шилжүүлдэг. Монгол улс нь ОУИТБС-ын тайланд оператор компаниудын олборлох, борлуулж, Засгийн газрын мөнгөн бус хэлбэрээр авах тосыг мөнгөн дүнгээр тооцож буй хэмжээ зэргийг ил тод болгож байна. Монгол улсын цаашид Засгийн газарт ноогдох тосыг тээвэрлэх, зах зээлд хүргэх болон борлуулах үйл явцыг ил тод болгох боломж байна.

Уул уурхайн салбарын ТӨК-иудад холбогдох олон тооны санхүүгийн гүйлгээ хийгдэж байдаг. Монгол улс нь ОУИТБС-ын хүрээнд ТӨК-иудын зүгээс төрд төлж буй төлбөрийг тодруулж буй ч Эрдэнэс Монгол зэрэг групп компанийн бүтцэд буй бүхий л компанийг бүрэн хамрахгүй байна. Харин Монголын ОУИТБС-ын 2020 оны тайлан нь ТӨК-иудын хуваарилж буй ногдол ашиг болон ТӨК хоорондын бараа, үйлчилгээний төлбөрийг (цахилгаан, хэрэглээ гэх мэт) холимог байдлаар

ил тод болгож байна. ТӨК доторх гүйлгээ, зээл болон урьдчилгаа төлбөрийн түвшний хувьд ОУИТБС нь илүү зорилтот арга хандлага ашиглан, ТӨК-иудын төрөл бүрийн гүйлгээг задлан харуулж байх боломж байна.

Монгол улс нь өмнөх Баталгаажуулалтаас хойш хугацаанд төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгож буй түвшнээ хадгалж ирсэн ч сүүлийн жилүүдэд ил тод болгосон төсвийн шинжтэй зарцуулалтын тоо, төрөл нь өсөж, ялангуяа КОВИД-19 цар тахлын үед их хэмжээгээр нэмэгджээ. Засгийн газрын зүгээс 2021- 2023 оны хугацаанд нийт 3.5 тэрбум ам.долларын төсвийн шинжтэй зарцуулалт хийхээр [зарласан](#) ба үүнд ТӨК-иудын зүгээс цахилгаан станц, төмөр зам, авто замд хийх хөрөнгө оруулалтыг багтаажээ. Монгол улс нь ОУИТБС-ын тайланг ашиглан Багануур ХК-ийн зүгээс төрийн өмчит цахилгаан станцуудад Засгийн газрын татаастай олгодог нүүрстэй холбоотой мэдээллийг 2018 оноос хойш мэдээлж байна. Гэвч талуудтай хийсэн ярилцлага болон нийтэд нээлттэй бус мэдээллээс үзвэл ихээхэн хэмжээний төсвийн шинжтэй зарцуулалт хийгдэж буйн тоонд Эрдэнэт компанийн зүгээс 2020 оны 12 дугаар сарын 1-нээс 2022 оныг хүртэл айл өрхүүдийн ус, цахилгааны төлбөрийг төлсөн, Эрдэнэс Таван Толгой компани бонд гаргаж төмөр зам барьж буй, Эрдэнэс Таван Толгой нь Улаанбаатар хотод үйлдвэрлэн борлуулж буй утаагүй түлшинд татаас олгож буй, Эрдэнэс Монголын ирээдүйн мөнгөний олборлолтоо барьцаалан босгосон бондоор тэтгэврийн зээлийг тэглэж, зээлгүй өндөр настнуудад 1 сая төгрөг олгосон зэрэг багтана. Иргэний нийгмийн зүгээс уул уурхайн ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалт дээр өөрийн судалгаа, нөлөөллийн ажлыг хийсэн ба ННФ 2021 онд ТӨК-иудын зарцуулалтын талаарх гаргасан [тайланд](#) хоёр ТӨК (Эрдэнэс Монгол болон Эрдэнэт) нийт 2 их наяд төгрөгийн (683 сая ам.доллар) төсвийн шинжтэй зарцуулалтыг 2020- 2021 онд хийснийг дурджээ. ОУИТБС-ын хувьд ийм төрлийн төсвийн шинжтэй зарцуулалтын ил тод болгох замаар чухал үүрэг гүйцэтгэх боломжтой ба энэ нь олборлох үйлдвэрлэлийн салбарын орлогоос санхүүжиж буй Засгийн газрын зарцуулалтыг ил тод болгох чухал хэсэг болно.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<b>Төрийн оролцоо (Шаардлага #2.6)</b> <i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i>	Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 2.6-д хамаарах ихэнх хэсэг нь биелэгдсэн хэмээх дүгнэлтийг гаргаж байна. Талуудыг төлөөлөн ярилцлагад хамрагдсан хэд хэдэн талын зүгээс, тэр дундаа иргэний нийгэм болон салбарын төлөөлөл нь уул уурхайн салбарын ТӨК-иудын ил тод, хариуцлагатай байдлын үр дүнтэй механизмыг бий болгох зорилт биелэгдсэн хэмээн үзээгүй. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн төрийн албан тушаалтны зүгээс хэлэхдээ сүүлийн 20 жилд ТӨК-иудад зээл олгох үйл явц нэмэгдэж, төрийн оролцоо хэмээх эрх зүйн орчин хуучирсан ба одоо Засгийн газрын зүгээс Төрийн өмчийн тухай хуулийг шинэчлэхээр төлөвлөж буйг дурдсан.

	<p>Монгол улс нь бүх төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж мэдээллээ ил тод болгож байх Шилэн дансны <a href="#">порталыг</a> ажиллуулж байна. Гэвч ОУИТБС-ын 2020 оны тайлан нь энэхүү системтэй ил тод болгож буй мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдлын талаар асуудал буйг гарган ирж, ТӨК-иудын зүгээс шаардлагатай мэдээллийг Шилэн дансанд байршуулаагүй хэд хэдэн тохиолдлыг гарган ирсэн. Тиймээс ОУИТБС-ын 2020 оны тайлан нь төр болон ТӨК хоорондын санхүүгийн харилцааны талаар мэдээлэл гаргаснаар чухал ач холбогдлыг бий болгож, өмнө ил тод болгосон мэдээллийг төвлөрүүлж, шинээр мэдээлэл ил тод болгожээ. Тус тайланд олборлох салбарын төрөл бүрийн ТӨК-иудын үүрэг роль, хариуцлагыг тайлбарласан. Гэвч Ажлын хэсгийн зүгээс ТӨК-ийн материаллаг түвшний талаар гаргасан шийдвэр 2020 оны ОУИТБС-ын тайланд, эхлэлийн тайлан болон Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд ч тусгагдаагүй байна. ОУИТБС-ын тайлан нь нийт 20 ТӨК-ийн жагсаалтыг гаргасан ч эдгээрийн зөвхөн 5 нь л тайлан гаргах цар хүрээнд багтсан ч төрөл бүрийн ТӨК-иудын талаарх мэдээллийг ил тод болгожээ. Ярилцлагад хамрагдсан талууд, үүнд Хараат бус аудиторын зүгээс үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний (зэс, алт, нүүрс) төрлөөс нь хамааран 5 ТӨК-ийг нэгтгэлд хамруулахаар сонгон авсан ба энэ сонголт нь 2020 онд төрд төлсөн татвар хураамж эсвэл төрийн хүлээн авсан татвар хураамжийн дүнгийн материаллаг байдлаас хамааран хийгдээгүй байна. Гэвч ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс 2020 оны ОУИТБС-ын тайланд 20 ТӨК-ийн тайлбар мэдээлэл багтаж, үүнд ТӨК болон төр хоорондын санхүүгийн харилцааг де факто материаллаг босго тэг байхад ч тусгасан байна.</p> <p>ОУИТБС-ын тайлан нь ТӨК-ийн төрд төлбөр төлөх, шилжүүлэг хийх, ашиг хуваарилах болон хуримтлагдсан ашигтай холбоотой журмыг тусгасан ч дахин хөрөнгө оруулалттай холбоотой журмыг тайлбарлаагүй. Ярилцлагын үеэр ТӨК-ийн төлөөллийн зүгээс дахин хөрөнгө оруулалттай холбоотой тухайн журам нь тухайн компанийн төрлөөс хамаарч болох ба Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд байдаг ТӨК-ийн хувьд дахин/эргүүлэн хөрөнгө оруулалт хийхдээ тус газраас урьдчилан зөвшөөрөл авах бол Эрдэнэс Монголын хамааралтай компани толгой компаниас зөвшөөрөл авдаг хэмээн тайлбарласан. ТӨК-ийн гуравдагч талын санхүүжилттэй холбоотой дүрэм журмын тайлбар нь гуравдагч талын өрийн санхүүжилтийн хувьд тодорхойгүй байна. Ярилцлагаар ТӨК-ийн төлөөллийн зүгээс тодорхой ТӨК-ийн ТУЗ нь богино хугацааны (нэг жилээс доош хугацааны) хөрөнгө оруулалтыг батлах боломжтой бол харин урт хугацааны гуравдагч талаас зээл авах бол Сангийн яамнаас урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатайг дурдсан (жишээ нь 5 жилийн хугацаатай бонд). ОУИТБС-ын тайланд буй ТӨК болон Засгийн газар хоорондын 2020 орны санхүүгийн харилцааны талаарх тайлбар нь бүрэн бус, зөвхөн зарим ТӨК-ийг хамруулжээ. Ямартай ч тайлан нь 5 ТӨК-ийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг хэрхэн авах талаар заасан боловч 2020 оны тайланд хамрагдсан үлдэх 15 компанийн хувьд энэ мэдээлэл байхгүй.</p> <p>ОУИТБС-ын тайлан нь 20 ТӨК дах төрийн оролцоог жагсаалтаар гаргаж, 2020 онд төрийн оролцоонд ямар нэгэн өөрчлөлт ороогүй болохыг баталсан ч олборлох салбарын компаниудын хувь эзэмшил бүхий ТӨК-иудын охин компани, хамтарсан компани, салбаруудыг хамруулаагүй, төр болон ТӨК-ийн хувь эзэмшдэг компани хоорондын нөхцөлийг тайлбарлаагүй. Оролцогч талуудтай</p>
--	--

	<p>хийсэн ярилцлагаар Эрдэнэс Таван Толгой болон Багануур зэрэг ТӨК нь хэд хэдэн охин компани, салбар компаниаг дурдсан. Зарим ТӨК-ийн вэбсайт нь тухайн компани хувьцаа эзэмшдэг зарим аж ахуйн нэгжийн нэрсийг тусгадаг бол ТӨК-ийн хувьцаа эзэмшдэг олборлох үйлдвэрлэлийн салбарт ажилладаг бүх компаниудын иж бүрэн жагсаалт байхгүй, компани нэг бүрээр ТӨК-ийн хувьцаанд хамаарах нөхцөл зэргийг тайлбарлаагүй.</p> <p>Монголын ОУИТБС-ын ил тод мэдээлэл нь төрөөс ТӨК-д олгосон зээлийн баталгааг багтаасан ба 5 ТӨК олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-д зээл олгосон, тухайн зээл эсвэл баталгааны хугацаа, нөхцөлийн талаар мэдээлжээ. Гэвч Засгийн газар болон ТӨК-иас авсан зээлийн тухай мэдээллийн иж бүрэн байдал асуудалтай, ихэнх ТӨК энэ чиглэлээр ямар нэгэн мэдээлэл тайлагнаагүй байна. Гэсэн ч ОУИТБС-ын Ажлын хэсэг нь ТӨК-ийн худалдан авалт, засаглалын дүрэм журам, үйл ажиллагааг тайлбарлан мэдээлэх чиглэлээр ихээхэн ахиц гаргасан ба дээрх сэдэв нь мөн олон нийтийн сонирхлын татан, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангаж байна.</p>
<p><b>Төрийн зүгээс мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан бүтээгдэхүүний борлуулалт (Шаардлага #4.2)</b></p> <p><i>Хамаарахгүй</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны үнэлгээгээр Баталгаажуулалтад хамаарах хугацаанд Шаардлага 4.2 нь Монгол улсад хамаарахгүй гэж үзэж байна. Ярилцлагад оролцсон талуудын зүгээс Засгийн газар болон ТӨК-иуд нь мөнгөн бус байдлаар ямар нэгэн орлогыг уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбараас төвлөрүүлээгүй гэж үзсэн. Засгийн газар газрын тос болох байгалийн хийн салбараас төвлөрүүлэх орлогоо мөнгөн бус хэлбэрээр, жишээ нь ашгийн тос хэлбэрээр авах боломжтой ч Монголын ОУИТБС-ын 2020 оны тайланд газрын тос, байгалийн хийн компаниуд нь төрд ноогдох бүтээгдэхүүнийг борлуулан, орлогыг нь Засгийн газарт шилжүүлдэг ажээ. Монголын ОУИТБС нь олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрд хамаарах мөнгөн бус хэлбэрийн хувийн борлуулалтын орлого зэрэг мэдээллийг ил болгосон. Тиймээс Монгол улс нь шаардагдаж буй минимум шаардлагаас давж хэрэгжүүлэх алхам хийж буй ч Шаардлага 4.2 дээр Монгол улс анхаарал хандуулан бүрэн хэрэгжүүлэх бусад хэрэгцээ байна.</p>
<p><b>ТӨК-иудтай холбоотой шилжүүлэг (Шаардлага #4.5)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.5-д хамаарах ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээх дүгнэлт гаргаж байна. Ярилцлагад хамруулсан иргэний нийгмийн хэд хэдэн оролцогчийн зүгээс ТӨК-д хамаарах төлбөр, шилжүүлгийг хянах боломжийг бий болгох зорилт биелэгдсэн гэж үзэж буй ч ТӨК-иудын зүгээс Шилэн данс болон ОУИТБС-ын 2020 оны тайланд оруулсан мэдээлэл нь дутуу байна. Ялангуяа олборлох үйлдвэрлэлийн салбарын компаниудын зүгээс ТӨК-д төлж буй төлбөрийн иж бүрэн байдал гол асуудал болж байна. Ярилцлагад хамрагдсан төрийн албан хаагчдын зүгээс энэхүү зорилт биелэгдсэн эсэх дээр ямар нэгэн санал илэрхийлээгүй бол салбарын зарим төлөөллийн зүгээс уул уурхайн салбарын ТӨК-иудын ил тод болгох үйл ажиллагаа нь янз бүрийн түвшинд байна хэмээн үзжээ. Монголын ОУИТБС-ын ил тод мэдээлэл нь ТӨК-иудын зүгээс Засгийн газарт төлж буй төлбөрт хамаарах санхүүгийн тайлангийн мэдээллийг төвлөрүүлж иржээ. ТӨК-иудын энэхүү шилжүүлгийг ОУИТБС-ын 2020 оны тайланд Засгийн газрын хүлээн авсан орлоготой нэгтгэн тулгаагүй нь ОУИТБС-ын тайлагналд “уян хатан” хандлага баримталсантай холбоотой байна. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь бараа, үйлчилгээ худалдан авах ТӨК-ийн дотоод</p>

	<p>шилжүүлгийг ТӨК-ийн шилжүүлэг хэмээн буруу ангилсан, олборлох салбарын компанийн зүгээс материаллаг хэмжээ бүхий ТӨК-д хийсэн төлбөрийг иж бүрэн ил тод болгоогүй. Тайланд олборлох үйлдвэрлэлийн бус ТӨК-иудад Засгийн газрын зүгээс хийсэн шилжүүлгийн үнийг дүнг тусгасан бол уул уурхайн ТӨК-д хийсэн шилжүүлгийг тусгаагүй. Иргэний нийгмийн зүгээс Баталгаажуулалтын тайлангийн төсөлд тайлбар ирүүлэхдээ Шаардлага 4.5 дээрх өгсөн үнэлгээг “хэсэгчлэн хангасан” болгон бууруулахыг санал болгосон ч Баталгаажуулалтын тайлангийн төслийн нэг хэсгийг дурдсанаас бусдаар ямар нэгэн тодорхой үндэслэл заан ирүүлээгүй.</p>
<p><b>Төсвийн шинжтэй зарцуулалт (Шаардлага #6.2)</b></p> <p><i>Хэсэгчлэн ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 6.2 хэсэгчлэн биелэгдсэн хэмээх дүгнэлт хийж байна. Төр болон иргэний нийгмийг төлөөлөх хэд хэдэн оролцогчийн зүгээс Монголын ОУИТБС-ын тайланд ил тод болгосон төсвийн шинжтэй зарцуулалтын ил тод мэдээлэл нь 2020 онд олборлох үйлдвэрлэлийн салбарын ТӨК-иудын хийсэн бүх хэлбэрийн төсвийн шинжтэй зарцуулалтыг иж бүрнээр хамруулаагүй гэж үзсэн. Талуудын зүгээс олборлох салбарт ажиллаж буй ТӨК-иудын төрийн өмнөөс хийж буй, улсын төсөвт бүртгэгдээгүй зарцуулалт, үүний менежментийн ил тод, эргэн тайлагнахуйц болгох зорилт хангагдсан хэмээн үзээгүй.</p> <p>Монголын ОУИТБС-ны тайланд санаачилгын Ажлын хэсэг нь төсвийн шинжтэй зарцуулалтыг хэлэлцэж, нэг төрлийн төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгосныг дурджээ. Монгол улс нь ОУИТБС-ыг ашиглан дулааны цахилгааны станцуудад татаастай үнээр нүүрс нийлүүлж буйг ил тод болгон мэдээлсэн. Гэвч Ажлын хэсгийн зүгээс төсвийн шинжтэй зарцуулалтыг иж бүрнээр судлан үзсэн эсэх нь тодорхойгүй, жишээ нь материаллаг дүнгээс дээш буй 5 ТӨК-ийн нэг нь тайлангаа гаргаагүй, ярилцлагад хамрагдсан талуудын зүгээс төсвийн шинжтэй хэмээн үзсэн ТӨК-ийн зарцуулалтын бусад хэлбэрийг Ажлын хэсэг судлан үзсэн эсэх нь мөн тодорхойгүй байна. Үүний тоонд 2020 оны 12 дугаар сараас эхлэн нийт айл өрхийн ус, цахилгааны төлбөрийг төлсөн Эрдэнэтийн төлбөр, 2020 оноос эхлэн нүүрс тээвэрлэх төмөр замын төслийг Эрдэнэс Таван Толгой санхүүжүүлэн барьж буй, Улаанбаатар хотыг утаагүй түлшээр хангахад зориулан Эрдэнэс Таван Толгойн зүгээс нүүрс татаастай үнээр нийлүүлж буй, мөн 2020 онд тэтгэврийн зээл тэглэх зориулалтаар Эрдэнэс Монгол бонд гаргасан (<i>Шаардлага 4.3 дээр үзнэ үү</i>) зэрэг багтах ба бонд босгон зээл тэглэсэн нь Засгийн газрын өрийг төлж буй төсвийн шинжтэй зарцуулалт гэж үзэх ч үүнийг нотлох мэдээлэл олон нийтэд хаалттай байна. Харин ОУИТБС-гаас гаргасан төсвийн шинжтэй зарцуулалтын тодорхойлолт дээр Шаардлага 6.2 үндэслэсэн ба тус тодорхойлолтод нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтцийн төлбөр, татаас болон улсын өрийн үйлчилгээний төлбөр зэрэг төсвөөс гадуур явагдаж буй шилжүүлгийг хамруулдаг. 2021 онд гарсан Баялгийн засаглалын индексийн <a href="#">Монгол улсад</a> хамаарах хэсэг дээр уул уурхайн ТӨК-ийн их хэмжээний арилжааны бус зардал нь томоохон асуудал болж буй бөгөөд энэ нь “<i>Засгийн газрын санхүүгийн байдлын талаар буруу дүр зургийг харуулж, Засгийн газрын зарцуулалт үр ашигтай эсэх дээрх иргэдийн хяналтыг сулруулж байна</i>” хэмээн дүгнэжээ. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа</p>

	Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь цаашид ОУИТБС-ны тайлагналын хүрээнд Шаардлага 6.2-ыг хангах байдлыг сайжруулна хэмээн мэдэгдсэн.
<b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлага 2.6 дээр заасны дагуу Монгол улс нь олборлох үйлдвэрлэлийн салбарт буй ТӨК-иудын үүрэг роль, Засгийн газар болон ТӨК хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан хамаарах дүрэм, журам, үүнд дахин хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилтийн талаар тайлбарласан жил тутмын ил тод мэдээллийг гаргаж байх шаардлагатай байна. Үүний хүрээнд ТӨК-ийн хамтарсан аж ахуйн нэгж болон салбар компаниудын шилжүүлэг, хуримтлагдсан ашиг, дахин хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт зэргийг мөн багтаана. Монгол улс нь мөн Засгийн газар болон ТӨК-ийн уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт ажиллаж буй компаниуд дахь эзэмшил, үүнд мөн ТӨК-ийн хамтарсан аж ахуйн нэгж, салбарын эзэмшиж буй хувь хэмжээ, тайлант хугацаанд тухайн эзэмшилд гарсан ямар нэгэн өөрчлөлт зэргийг тусган ил тод болгож байх нь чухал. Энэхүү мэдээлэлд тэдний эзэмшиж буй хувь хэмжээнд хамаарах нөхцөл, үүний дэлгэрэнгүй мэдээлэл багтах ба жишээ нь төслийн мөчлөг дэх шатуудад зардлыг гаргахаар хүлээсэн үүрэг, жишээ нь бүрэн төлбөр хийж эзэмшиж буй хувь хэмжээ эсвэл үнэ төлбөргүй эзэмшиж буй эсэх эсвэл үнэ төлбөргүй шилжүүлэн авч буй эсэх зэргийг багтаасан байна. Засгийн газар болон ТӨК нь тус улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудад зээл олгосон эсвэл зээлийн баталгаа гарган өгсөн бол энэхүү шилжүүлгийн дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгож, үүнд зээлийн хугацаа болон нөхцөлийг (жишээ нь эргэн төлөх хугацаа, хүүгийн хувь хэмжээ) ил тод болгосон байх ёстой. Монголын ОУИТБС нь арилжааны нөхцөлтэй зээлтэй тухайн зээл, зээлийн нөхцөлийг харьцуулан мэдээлж болно. Материаллаг төлбөр бүхий бүх ТӨК нь өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг эсвэл санхүүгийн тайлан боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлтийг (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн үрсгал) ил тод болгохоор шаардах нь зүйтэй. Санаачилгын хэрэгжилтийн сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг ашиглан ТӨК-уудын үйл ажиллагааны болон капитал зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэлийн гэрээ, компанийн засаглалд (жишээ нь ТУЗ-ын бүрэлдэхүүн, томилгоо, чиг үүрэг, ёс зүйн дүрэм гэх мэт) хамаарах дүрэм журмуудыг ил тод тайлбарлах нь зүйтэй.</li> <li>• Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-аар дамжуулан төрд ноогдох газрын тосыг компаниуд зах зээлд хүргэж, борлуулж буй мэдээллийг гаргаж, худалдан авагч компанийг сонгох үйл явцыг тайлбарлаж, Засгийн газрын өмнөөс хийгдэж буй тосны борлуулалтыг ил тод болгож, үүнийг худалдан авагч нэг бүрээр нь, боломжтой бол борлуулалт, бүтээгдэхүүний төрөл, үнээр нь задаргаатайгаар ил тод мэдээлэх боломж байна.</li> <li>• Шаардлага 4.5 дээр заасны дагуу Монгол улс нь ОУИТБС-ын үйл явц нь ТӨК-ийн үүрэг ролийг иж бүрэн хамарч, үүнд материаллаг түвшнээс дээш буй компаниудын зүгээс ТӨК-д, ТӨК-ийн зүгээс төрийн байгууллагад, Засгийн газрын зүгээс ТӨК-д хийж буй шилжүүлгүүдийн иж бүрэн, үнэн зөв мэдээллийг ил болгох нь зүйтэй. Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь Шилэн дансны портал зэрэг одоогийн боломжит дэд бүтцэд суурилан олборлох үйлдвэрлэлийн ТӨК-иудад хамаарах шилжүүлгүүдийг системтэйгээр ил тод болгохыг дэмжин ажиллах шаардлагатай.</li> <li>• Шаардлага 6.2 дээр заасанчлан Монгол улс нь материаллаг түвшний төлбөр бүхий ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод болгох ОУИТБС-ын үйл явцыг хөгжүүлж, бусад төлбөр, орлогын үрсгалтай ижил хэмжээнд ил тод болгож, үүнд ТӨК-ийн охин компаниуд болон салбарыг хамруулж байх шаардлагатай байна. Ийнхүү ил тод болгож буй нь материаллаг түвшний бүхий л ТӨК-ийн олон нийтэд зориулсан, улсын төсвөөс гадуурх нийгмийн</li> </ul>	



зарцуулалтыг, жишээ нь нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, шатахуун түлшний татаас, Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр зэргийг багтаах нь зүйтэй.

## Үйлдвэрлэл болон экспорт (Шаардлага 3.2, 3.3)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Монгол улс нь төрөл бүрийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгч бөгөөд 2020 оны байдлаар 13 төрлийн (зэс, алт, төмрийн хүдэр, молибден, мөнгө, цагаан тугалга, гянт болд, жонш, эрчим хүчний болон коксжих нүүрс, түүхий тос, хайрга болон шохойн чулуу зэрэг түгээмэл тархацтай материал) эрдэс баялгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Монгол улс нь өөрийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний дийлэнх хэсгийг экспортолдог ба нийт экспортын 95% нь БНХАУ-д хийгдэж, дотооддоо нүүрс, барилгын материалыг ихээр ашиглаж байна.

Монгол улсын Засгийн газар нь ашигт малтмалын үйлдвэрлэлийн хэмжээ, борлуулалтын үнийг тооцох арга зүйг АМГТГ-ын сар тутамд гаргадаг статистик мэдээллийн хүрээнд ил тод болгох чиглэлээр зарим ахиц дэвшил гаргаад байна. Монгол улс нь ОУИТБС-ын хүрээнд нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нийт хэмжээг АМГТГ-ын гаргаснаар нэгдмэл байдлаар олон нийтэд мэдээлж байна. Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн талаар мэдээлэл авах сонирхол олон нийтийн дунд өндөр буй тул Монголын ОУИТБС-ын хамрах хүрээнд үүнийг багтааснаар олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн үнэлгээний арга зүйн талаарх мэдээллийг ил тод болгож болно.

Гаалийн ерөнхий газрын зүгээс олон улсын бараа бүтээгдэхүүний ангиллын дагуу бүх эрдэс баялгийн бүтээгдэхүүний сар тутмын экспортын мэдээллийг ил тодоор мэдээлж байна. Үүн дээр Монголын ОУИТБС-ын тайлан экспорт хийгдэж буй (үндсэндээ Хятад) орнуудын мэдээллийг нэмэлтээр түгээх замаар ил тод байдлыг сайжруулж байна. Монголын ОУИТБС-ын хувьд экспортын хэмжээ, үнийг тооцоолох механизмыг дэлгэрэнгүй тайлбарлан ил тод мэдээлэх замаар илүү үр дүнд хүрэх боломжтой Монгол улсын экспортын статистик мэдээлэл нь бусад өгөгдөл, мэдээлэлтэй нийлүүлэн ажиллах боломжийг хангаснаар худалдааны түнш орнуудын импортын статистиктай харьцуулах боломжийг хангана.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
-------------------------------------	--

<p><b>Үйлдвэрлэл (Шаардлага #3.2)</b></p> <p><i>Бүрэн ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны дүгнэлтээр Шаардлага 3.2-ийн ихэнх хэсэг биелэгджээ. Ярилцлагад хамрагдсан төрийн зарим албан тушаалтны зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түвшин, бүтээгдэхүүний үнэлгээний талаар олон нийтийн ойлголт бий болгох зорилтыг АМГТГ-ын байнгын мэдээллийн хүрээнд ханган биелүүлж байгаа хэмээн үзсэн. Гэвч иргэний нийгмийн зарим төлөөллийн зүгээс энэхүү зорилтыг биелээгүй, 2020 онд үйлдвэрлэсэн бүх ашигт малтмалын үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл, үүнд үнэлгээ зэрэг мэдээлэл бүрэн бус гэж үзэж буй нь санаа зовних асуудал бөгөөд учир нь олон нийтийн зүгээс Монгол улсад ашигт малтмалын үнэлгээний асуудал ихээхэн анхаарал татаж буй юм. Олон улсын Ажлын албаны зүгээс үзэж буйгаар Засгийн газар ашигт малтмалын бүтээгдэхүүн нэг бүрээр, дундаж үнэтэй нь үйлдвэрлэлийн нийт хэмжээг системтэйгээр, сар тутамд ил тод болгох зорилго бүрэн хангагджээ. Гэвч иргэний нийгмийн хувьд хамгийн өндөр хэрэгцээтэй буй үйлдвэрлэлийн хэмжээ, үнийг тооцох арга зүйг олон нийтэд ил болгоогүй тул давуулан ханган биелүүлсэн хэмээн үзэх боломжгүйд хүргэж байна.</p> <p>АМГТГ-ын бэлтгэн гаргадаг сар тутмын <a href="#">статистик мэдээлэл</a> нь эрдэс баялгийн бүх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн мэдээллийг ил тод болгож, бүх ашигт малтмалын бүтээгдэхүүний жишиг үнийг мэдээлж буй ба үүнээс үйлдвэрлэлийн хэмжээ, үнийг тооцон гаргах боломжтой. Монголын ОУИТБС-ын 2020 оны тайлан нь тухайн жилд үйлдвэрлэсэн 9 бүтээгдэхүүний (нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт, жонш, хайлуур жонш, цайр, молибден, түүхий тос) үйлдвэрлэлийн зарим мэдээллийг нэмэлтээр ил тодоор мэдээлжээ. 2020 оны ОУИТБС-ын тайлан нь зөвхөн түүхий тос болон алтны үйлдвэрлэл, үнийг тусгасан ч бүх металл хүдрийг нийлүүлэн нэгдсэн дүнгээр тусгажээ. Ажлын албаны зүгээс ирүүлсэн тайлбарт АМГТГ-ын гаргаж буй сар тутмын мэдээллийн иж бүрэн хэмээн үзэж буйгаа дурдсан. Монголын ОУИТБС-ын <a href="#">цахим тайлагналын платформ</a> нь 2019 оныг хүртэл үйлдвэрлэлийн хэмжээг компани болон бүтээгдэхүүнээр дэлгэрэнгүй тусгаж ирсэн ч 2020 онд энэ мэдээлэл байхгүй. Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс ийнхүү 2020 оноос хойш үйлдвэрлэлийн хэмжээг мэдээлэхгүй болсон талаарх ямар нэгэн тайлбар гарган өгөөгүй.</p>
<p><b>Экспорт (Шаардлага #3.3)</b></p> <p><i>Бүрэн ханган биелүүлсэн</i></p>	<p>Ажлын албаны зүгээс Шаардлага 3.3-ыг Монгол улс бүрэн ханган биелүүлсэн хэмээх дүгнэлт гаргаж байна. Ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс олборлох үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын түвшин, бүтээгдэхүүний үнэлгээний талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах зорилт биелэгдсэн эсэх дээр тодорхой санал бодол илэрхийлээгүй. Ажлын албаны хувьд ОУИТБС-ын тайлангийн хүрээнд бус харин Засгийн газрын зүгээс энэ мэдээллийг системтэйгээр ил тод болгож буй хүрээнд энэ зорилго биелсэн гэж үзсэн ба Засгийн газраас түгээж буй экспортын мэдээлэл нь нээлттэй форматаар, бусад мэдээлэлтэй, жишээ нь худалдааны түнш орнуудын импортын статистикийн мэдээлэлтэй хослуулан ашиглах боломжтой байна.</p> <p>Засгийн газрын зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний экспортын мэдээллийг системтэйгээр ил тод мэдээлж байна. АМГТГ-ын сар тутмын <a href="#">статистик мэдээлэл</a> нь эрдэс баялгийн гурван бүтээгдэхүүний (нүүрс, зэс, түүхий тос) экспортыг хэмжээг мэдээлдэгч үнийн хувьд зөвхөн хоёр бүтээгдэхүүний (нүүрс, зэс) мэдээлэл байна. нөгөө талаар Гаалийн ерөнхий</p>

	газраас сар тутмын <a href="#">статистик</a> мэдээллийг нээлттэй форматаар олон улсын HS кодын ангиллын дагуу, экспортолсон бүтээгдэхүүн нэг бүрээр түгээдэг. Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг 8 гол бүтээгдэхүүний экспортын хэмжээ, үнийг ил тод болгон мэдээлэхэд ашиглаж буй бусад бүтээгдэхүүний хувьд ГЕГ-аас өөр системтэйгээр ил тод мэдээлэхгүй байна. Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг экспортын хэмжээ, үнийг тооцох арга зүйн талаарх мэдээлэл түгээхэд хараахан ашиглаагүй.
<b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b>	
<ul style="list-style-type: none"><li>• Хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь үйлдвэрлэж буй бүх эрдэс баялгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, үнийг бүтээгдэхүүн бүрээр цуглуулан, олон нийтэд ил тод болгож байх нь зөв. Энэхүү өгөгдлийг компани эсвэл төслөөр нь задлан харуулж, үйлдвэрлэлийн хэмжээ болон үнийг тооцох арга зүйг мөн мэдээлэлд багтаах боломжтой.</li><li>• Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь экспортын бүтээгдэхүүний мэдээллийг системтэйгээр ил тод болгож, энэхүү мэдээллийг бүс нутгаар, компани эсвэл төслөөр дэлгэрэнгүй задалж, экспортын хэмжээ болон үнийг тооцох арга зүйг мөн мэдээлэлд багтаах боломжтой.</li></ul>	

## Орлого төвлөрүүлэлт (Шаардлага 4.1, 4.3, 4.4, 4.7, 4.8, 4.9)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Монгол улсын уул уурхайн салбар нь олон янзын бүрдэл хэсэгтэй, нийт 2263 хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл олгогдож, 100 орчим уурхай 2020 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Харин газрын тос, байгалийн хийн салбар нь жижиг, нийт 22 компани Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулснаас хоёр компани үйлдвэрлэл, олборлолтын шатанд шилжээд байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарын компаниуд нь төрөл бүрийн татвар, төлбөрийг улсын болон орон нутгийн төсөвт төлдөг ч улсын төсөвт төлж буй татвар хураамж нь 2020 онд Засгийн газрын зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн нийт орлогын 99%-ийг бүрдүүлжээ. Засгийн газрын эрдэс баялгийн салбараас олох орлогын томоохон эх үүсвэр нь АМНАТ (2020 онд 34%), аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (28%), ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл (10%) болон төрийн өмчийн ноогдол ашиг (5%) байна. Олборлох компаниудын зүгээс төрд төлж буй татвар, төлбөрийн талаар, ялангуяа Оюу Толгойн алт, зэсийн ордоос авах татварын хэмжээний талаар мэдээллийг [ТЕГ](#) болон [ТББ-үүдээс](#) авах олон нийтийн хэрэгцээ маш өндөр байна.

Монгол улс нь ОУИТБС-ын хэрэгжилтийн хүрээнд цахим тайлагналын систем болон [нээлттэй мэдээллийн порталыг](#) 2015 онд нээсэн нь олборлох үйлдвэрлэлийн компаниуд болон төрийн байгууллагуудын зүгээс онлайн хэлбэрээр мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл болжээ. Цахим тайлагналын системийг одоо үйл ажиллагаа явуулж буй төрийн мэдээллийн (ТЕГ, АМГТГ болон бусад төрийн байгууллага) сангуудтай уялдуулан нийцүүлэх тухай хэлэлцүүлэг явагдаж байсан ч онлайн байдлаар тайлан гаргах үйл явц нь компани болон төрийн байгууллагууд өгөгдлийг гараар оруулахыг шаардсан хэвээр байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа

явуулж буй бүх компани тайлан гаргах үүрэгтэй нь Монголын ОУИТБС-ын хамрах хүрээ жил тутам мэдээлэл гарган, нэгтгэлд хамрагдаж буй компаниудаар хязгаарлагдахгүй илүү өргөн болохыг харуулж байна. Тиймээс 2019 онд тусгай зөвшөөрөл эзэмшиж буй нийт 2093 компаниас 1,472 нь мэдээллээ цахим тайлагналын платформоор дамжуулан ирүүлсэн нь 2020 онд үндсэндээ тогтвортой хэвээр хадгалагдаж 2,363 компанийн 1,419 нь тайлангаа ирүүлжээ. Энэ нь 2019 оны материаллаг түвшнээс давсан 171 компаниас нэгтгэлд хамрагдсан 161, 2020 оны 6 компаниас нэгтгэлд хамрагдсан 57 компанитай харьцуулбал хавьгүй өндөр үзүүлэлт байна. Гэвч ОУИТБС-д тайлангаа ирүүлээгүй компаниудад өнөөг хүртэл ямар нэгэн хариуцлага тооцоогүй байна.

Монгол улс нь 2020 оны ОУИТБС-ын тайланд “уян хатан” хандлага баримталсан ба үүнийг УЗ-ын зүгээс КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан зөвшөөрсөн байсан. Тиймээс нэгтгэлд хамруулах компаниудын тоог 2018 онд 202 байснаас 2019 онд 171 болтол бууруулж, улмаар 2020 онд 60 компанийг нэгтгэлд хамруулахдаа төрд төлсөн татварын хэмжээнд бус харин үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд нь (зэс, алт, нүүрс) үндэслэн сонгон авчээ. Оролцогч талуудтай хийсэн ярилцлагаар энэхүү хандлагыг Ажлын хэсэг дээрх бүх талууд дэмжээгүй, зөвшилцөлд хүрээгүй бөгөөд иргэний нийгмийн зүгээс үзэхдээ компанийн тайлангуудыг цахим тайлагналын системээр дамжуулан хэдийн цуглуулсан тул илүү олон тооны компанийг нэгтгэлд хамруулах боломжтой хэмээн үзэж байжээ. Монгол улсын хувьд ОУИТБС-ын мэдээллийн үнэн зөв байдлыг хангах алтернатив сонголтыг харгалзан үзэж, цахим тайлангийн платформ дээр үндэслэн санхүүгийн үүргийнх нь хүрээнд компаниудын төлбөрийг үнэлэх механизмыг хөгжүүлэх боломж байна. Монгол улсын хувьд мөн ОУИТБС-ын тайлагналд бусад сонголтот хандлагуудыг хөгжүүлэхэд оролцох, энэхүү шинэлэг хандлагыг боловсруулахад оролцох боломж мөн харагдаж байна.

Баталгаажуулалтад хамаарах хугацаанд (2020) нөөц барьцаалсан зээл авсан тохиолдол буй бөгөөд үүнийг ОУИТБС-ын тайланд тусгаагүй. Эрдэнэс Монгол компани өөрийн охин компанийн ирээдүйд олборлох мөнгөөр (Эрдэнэс Силвер) баталгаажсан 900 тэрбум төгрөгийн (230 сая ам.доллар) бондыг босгосон нь ярилцлагад хамрагдсан хэд хэдэн зүгээс нөөц барьцаалсан зээл хэмээн үзэж буй ч үүнийг харуулах хангалттай мэдээлэл олон нийтэд нээлттэй бус байна. Монголын ОУИТБС-ын ил тод болгож буй мэдээллийг өргөжүүлэн энэ төрлийн зээлийг хамруулах нь олборлох үйлдвэрлэлийн салбараас Засгийн газрын төвлөрүүлж буй бүх орлогыг иж бүрэн ил тод болгоход чухал үүрэгтэй байна.

Монгол улс нь өөрийн ОУИТБС-ын тайланг цаг тухайд нь буюу тухайн санхүүгийн жил дууссанаас хойш нэг жилд багтаан гаргаж буй ч ярилцлагад хамрагдсан оролцогч талуудын зүгээс тайлангийн цаг хугацаандаа, шуурхай гарах байдлыг сайжруулах, тэгснээр бодлого боловсруулахад үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр буйг илэрхийлсэн. Түүнчлэн Засгийн газрын төвлөрүүлж буй орлогыг төслөөр нь (жишээ нь АМНАТ болон тусгай зөвшөөрлийн төрлөөр) задлан харуулж байх сонирхол өндөр ч жил тутамд цуглуулж буй мэдээллийг тэр хэмжээний дэлгэрэнгүй байдлаар гаргуулах шаардлагатай цахим тайлагналын маягтуудад шинэчлэл хараахан хийгээгүй байна. Өмнө нь иргэний нийгмийн зүгээс [Оюу Толгой](#), зэрэг тодорхой гол төслүүд дээр санхүүгийн загварыг боловсруулж, төслийн хэмжээний өгөгдлийг ашиглах боломжтойг харуулж байжээ.

Монгол улс нь ОУИТБС-ын тайланг хувийн хэвшил болон ТӨК-ийн аудитын болон баталгаажуулалтын үйл ажиллагааны зураглалыг гаргахад ашиглаж ирсэн ч төрийн аудит, баталгаажуулалтыг зураглаж буйн нэгэн адил дэлгэрэнгүй, нарийвчилсан хэмжээнд хүрээгүй байна. Сүүлд гарсан ОУИТБС-ын тайлангууд (2019, 2020) нь ОУИТБС-ын хүрээнд ил тод мэдээлсэн зарим санхүүгийн мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдлын талаарх асуудлуудыг тусгасан ч олборлох үйлдвэрлэлийн салбараас Засгийн газрын бүрдүүлж буй орлогын санхүүгийн иж бүрэн багц мэдээллийн талаарх тусгагдаагүй. Монгол улсын хувьд ОУИТБС-ыг ашиглан салбар болон Засгийн газрын аудит, баталгаажуулалтын арга ажиллагааг сайжруулах зөвлөмжүүдийг боловсруулан гаргаж болно.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Татвар, орлогыг иж бүрэн ил тод болгох (Шаардлага #4.1)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.1-т хамаарах ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээх үнэлгээг өгч байна. Олборлох салбараас төвлөрүүлж буй Засгийн газрын орлогын ил тод байдлыг хангах зорилт биелэгдсэн эсэх дээр ярилцлагад хамрагдсан талууд санал зөрөлдөөнтэй, иргэний нийгмийн зүгээс 2020 оны тайланд цар тахлын улмаас сонгосон арга зүйд ихээхэн сэтгэл дундуур байв. Бусад оролцогч талын зүгээс компаниудын төлсөн төлбөр, Засгийн газрын хүлээн авсан орлогыг ил болгож буй Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын <a href="#">нээлттэй өгөгдлийн портал</a> нь зөвхөн материаллаг дүнд тулгуурлан нэгтгэлд хамруулахаар сонгон авсан цөөн тооны компаниудын мэдээллээс илүү их өргөн хүрээний өгөгдөл, мэдээлэл ил болгодог гэж үзжээ. Олон нийтэд нээлттэй буй мэдээллээс харвал Ажлын хэсэг нь орлогын үрсгал болон компаниудын нэгтгэлд сонгох арга хандлага, материаллаг босго зэргийг хэлэлцэн тогтоож байна. Монгол улс нь ОУИТБС-ын УЗ-ийн зүгээс 2020 оны 5 дугаар сард баталсан “уян хатан” хандлагыг сонгон хэрэгжүүлсэн. Гэвч энэхүү “уян хатан” хандлагад нийцүүлэн материаллаг төлбөр бүхий компаниудын сонгон авахыг Ажлын хэсэгт буй бүх талууд дэмжээгүй, жишээ нь иргэний нийгмийн зүгээс тухайн үед үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнд (алт, зэс, нүүрс) нь суурилан компаниудыг сонгон нэгтгэлд хамруулахыг эсэргүүцэж байжээ. Материаллаг төлбөр бүхий компаниудын гурваас бусад нь тайлангаа гаргасан ба тухайн тайлан гаргаагүй гурван компанид хамаарах Засгийн газрын тайлан нь 2020 оны ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлийн иж бүрэн байдалд сөрөг нөлөө үзүүлээгүй байна. Өөр нэгэн санаа зовоох асуудал нь материаллаг төлбөр хүлээн авсан төрийн долоон байгууллагуудаас хоёр нь тайлан гаргаагүйн тоонд Сангийн яам багтжээ. Тус яамны хүлээн авсан орлого нь 2020 онд материаллаг түвшнээс дээш компаниудаас хүлээн авсан орлогын 5 илүү хувьтай тэнцэж байв. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь нэгтгэлийн үеэр илэрсэн зөрүүг хангалттай шалган судалсан ба тулган нэгтгэгдээгүй зөрүүний хэмжээ бага байна. Засгийн газрын зүгээс</p>

	<p>өөрийн талаар хүлээн авсан бүхий л орлогыг тайлагнасан ба үүнд тусгайлан тайлагнаагүй ч Сангийн Яамны орлого мөн тусгагджээ. Гэвч материаллаг компаниудыг сонгосон талаарх тайлбар байхгүй явдал болон төрийн хоёр байгууллагын зүгээс тайлан ирүүлээгүй нь томоохон асуудал бөгөөд Ажлын албаны зүгээс Шаардлага 4.1 дээр заасан үүргийг бүрэн ханган биелүүлээгүй гэсэн дүгнэлтийн үндэслэл болж байна. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа цаашид ОУИТБС-ын тайлагналд Шаардлага 4.1-ийн хэрэгжилтийг сайжруулан хангах болохыг дурджээ.</p>
<p><b>Дэд бүтцийн хангалт болон бартерын зохион байгуулалт (Шаардлага #4.3)</b></p> <p><i>Хэсэгчлэн ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.3-т хамаарах ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээх үнэлгээг өгч байна. Талуудтай ярилцлага хийн тодруулга авахад ихэнх талын зүгээс Баталгаажуулалтын хугацаанд их хэмжээний нөөц барьцаалсан зээл авсан ба үүнийг Монголын ОУИТБС-ын тайланд тусгаагүй байна. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн ИНБ-ын зүгээс нөөц барьцаалсан зээл зэрэг бартерын төрлийн ажил гүйлгээг ил тод болгох зорилт биелээгүй хэмээн үзсэн.</p> <p>Монголын ОУИТБС-ын 2020 оны тайлан нь гэрээний хүрээнд компаниудад үүрэг болгосон нийгмийн шинжтэй зарцуулалтыг ашигт малтмал, газрын тос, байгалийн хийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар төлбөрт өгөх бартерын хэлцэлтэй холин буруу ангилсан харагдаж байна. Тайланд дэд бүтцэд (жишээ нь зам, төмөр зам, цахилгаан станц, сургууль, эмнэлэг гэх мэт) хөрөнгө оруулалт хийсэн хэмээн тайлагнасан 37 компанийн жагсаалт туссан ч тухайн дэд бүтцэд хийх хөрөнгө оруулалт нь ашигт малтмалын тухай хуульд шаардсан гэж тайлбарласнаас өөрөө Засгийн газрын зүгээс хүлээн авсан орлогын үрсгалыг тусган тайлбарлаагүй байна (<i>Шаардлага 6.1 дээр үзнэ үү</i>). Нөгөө талаар ОУИТБС-ын тайланд Эрдэнэс Монгол компанийн зүгээс 2018 онд улсын мэдэлд авч, Эрдэнэт Силвер компанид шилжүүлсэн Салхитын мөнгөний ордын ирээдүйн бүтээгдэхүүнээр барьцаалан <u>2020</u> онд босгосон 280 сая ам.долларын бондыг тусгаагүй нь асуудал үүсгэж байна. Энэ талаар ярилцсан төрийн ихэнх албан тушаалтан ямар нэгэн санал бодол илэрхийлээгүй ч ТӨК-иудын төлөөллийн зүгээс Эрдэнэс Монголын гаргасан энэхүү бонд нь нөөц барьцаалсан зээл мөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү гүйлгээ нь нөөц барьцаалсан зээл эсэхийг Ажлын хэсэг дээр үнэлэн үзсэн ямар нэгэн нотолгоо байхгүй, харин 2020 оны сонгуулийн өмнө тэтгэврийн зээлтэй иргэдийн зээлийг тэглэх зорилгоор гаргасан энэхүү төсийн шинжтэй өрийн талаар олон нийтийн дунд өргөн хэмжээний хэлэлцүүлэг өрнөжээ. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа цаашид ОУИТБС-ын тайлагналд Шаардлага 4.3-ын хэрэгжилтийг сайжруулан хангах болохыг дурджээ.</p>
<p><b>Тээвэрлэлтийн орлого (Шаардлага #4.4)</b></p> <p><i>Хамаарахгүй</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.4 нь энэхүү Баталгаажуулалтад хамаарахгүй гэж үзсэн. Ярилцлагад хамрагдсан талуудын зүгээс тээвэрлэлтийн орлоготой хамаарах тодорхой санал бодол илэрхийлээгүй ч зарим олон улсын байгууллагын зүгээс тээвэрлэлтийн талаарх мэдээлэл болон үүнтэй холбоотой ОУИТБС-ын өгөгдлийг ашиглах олон нийтийн сонирхол өндөр буйг илэрхийлсэн. ОУИТБС-ын тайланд сонгогдсон материаллаг түвшнээс дээш төлбөр бүхий бүх ТӨК-ийн аль ч тээвэрлэлтээс орлого олдоггүй харагдаж буйн зэрэгцээ Монголын ОУИТБС нь тээвэрлэлтийн орлогын талаар илүү өргөн хүрээний тодорхойлолт</p>



	<p>гаргаж, олборлох үйлдвэрлэлийн бус аж ахуйн нэгжүүдийн төмрийн хүдэр тээвэрлэсний орлогыг ил тод болгосон ч энэ нь жилийн нийт дүнгээр, төлбөрийн урсгалаар задлаагүй, олон нийтийн анхааралд буй асуудал болох тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаар ямар нэгэн тайлбар оруулаагүй байна. Монголын ОУИТБС-ын зүгээс тээвэрлэлтийн орлогын талаар өргөн хүрээг хамруулж байхаар зөвшилцсөн нь талархууштай бөгөөд энэ нь цаашид шаардлагыг иж бүрнээр нь хангасан тохиолдолд Шаардлага 4.4-ыг давуулан биелүүлсэн хэмээн цаашид дүгнэхэд хүргэх боломжтой.</p>
<p><b>Өгөгдлийн задаргааны түвшин (Шаардлага #4.7)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.7-т хамаарах ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээх үнэлгээг өгч байна. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн оролцогч талын зүгээс Засгийн газрын орлогыг төслийн түвшинд нь задлан харуулахгүй буй нь тодорхой нэг төслөөс үзүүлж буй хувь нэмрийг үнэлэх зэрэг боломжийг хааж байна хэмээн үзсэн. Иргэний нийгэм болон төрийн хэд хэдэн төлөөллийн зүгээс Засгийн газрын орлогыг төслийн түвшинд хүртэл задлан харуулах зорилтын ихэнх хэсэг нь биелсэн гэж үзжээ. Тэдний зүгээс орон нутгийн захиргааны төвлөрүүлж буй орлогыг илүү задаргаатайгаар ил тод болгох нь чухал болохыг хэлсэн. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь хүлээн авагч төрийн байгууллага нэг бүрээр нь задалсан санхүүгийн мэдээллийг харуулсан ч төсвийн түвшинд эдгээрийг задлан харуулаагүй. Ажлын хэсэг нь Шаардлага 4.7-д хамаарах төсөл хэмээн тодорхойлолтыг гаргаж, төсөл бүр дээр ноогдуулах татваруудын ерөнхий тоймыг харуулсан ч төсөл нэг бүрээр ноогдуулж, хурааж буй татварыг харуулаагүй, хамаарах эрх зүйн гэрээ хэлцэл зэргийг ил тод болгоогүй байна. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй тодорхой үүл үүрхэйн төслүүд нь хэд хэдэн тусгай зөвшөөрөлтэй талбайд ажиллаж буй баримт нотолгоо байна. ОУИТБС-ын тайлангийн маягтуудад улсын болон орон нутгийн төслийн орлогын төслөөр нь тайлагнах маягыг нэмж оруулаагүй. Тиймээс Монгол улс нь Засгийн газрын хүлээн авч буй орлогыг төслийн түвшинд нь хүртэл задаргаатай ил тод болгоогүй байна.</p>
<p><b>Өгөгдөл мэдээллийн цаг хугацаат байдал (Шаардлага #4.8)</b></p> <p><i>Давуулан ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.8-ыг давуулан ханган биелүүлсэн хэмээх үнэлгээг өгч байна. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн талын зүгээс ОУИТБС-ын тайлан мэдээллийн цаг хугацаандаа гарч буй байдал дээр сэтгэл зовниж буйгаа илэрхийлж, цаг хугацааны хувьд бодлого боловсруулахад хэрэгцээтэй мэдээлэл болохгүй байна хэмээн үзжээ. Гэсэн ч Олон улсын Ажлын албаны зүгээс ОУИТБС-ын тайланг цаг тухайд нь гаргаж байх зорилт нэг жилийн хугацаанд гарч буйгаараа биелэгдсэн хэмээн үзэж байна. Монгол улс нь ОУИТБС-ын тайлангаа тухайн хамаарах санхүүгийн жил дууссанаас хойш нэг жилд багтаан гаргаж ирсэн. Ажлын хэсгийн зүгээс тайлан гаргах хугацааг баталсан ба цаашид Ажлын хэсэг нь Хараат бус аудиторыг сонгон шалгаруулах үйл явцыг сайжруулах замаар цаг хугацаат байдлыг сайжруулах төлөвлөгөөтэй байна. Монгол улсын оролцогч талуудын зүгээс ОУИТБС-ын тайланг цаг тухайд нь шуурхай гаргаж байх хүсэл нь талархууштай ба Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс ОУИТБС-ын тайлангаа Шаардлага 4.8 дээр заасны дагуу цаг тухайд нь гаргаж байх шаардлагыг давуулан биелүүлсэн хэмээн үзэж байна. Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа ОУИТБС-ын Ажлын алба нь Шаардлага 4.8-ыг “сайн хангасан” гэж үзэж, цаашид Хараат бус аудиторыг цаг тухайд нь сонгон шалгаруулах, МХЕГ-тай нягт хамтран ажиллах замаар компаниудаар</p>

	<p>тайланг нь цаг тухайд нь гаргуулах, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөтэй буйгаа дурдсан. Олон улсын Ажлын албаны зүгээс ОУИТБС-ын тайланд хамаарах санхүүгийн жилээ хойш нэг жилд багтаан гаргаж буй, үүнийг санхүүгийн бус мэдээллийг тухай бүрд нь ил тод болгож байхтай хослуулан хэрэгжүүлж буй нь Шаардлага 4.8-ыг давуулан биелүүлсэн үндэслэл хэмээн үзэж байна.</p>
<p><b>Өгөгдлийн чанар, баталгаажуулалт (Шаардлага #4.9)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.9-т хамаарах ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээх үнэлгээг өгч байна. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн оролцогч талын зүгээс, мөн олон улсын байгууллагуудын зүгээс 2020 оны ОУИТБС-ын тайлан дахь санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд эргэлзэж буйгаа илэрсэн бол бусад талуудын зүгээс энэ асуудлаар санал бодол илэрхийлээгүй. Олон улсын ажлын алба нь Засгийн газрын болон компанийн байнгын аудит болон баталгаажуулалтын систем, үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулах болон талууд нь Засгийн газрын олборлох салбарын орлогын мэдээллийн үнэн бодит байдалд сэтгэл ханамжтай байх боломжийг бүрдүүлэх зорилтын ихэнх нь биелэгдсэн хэмээн үзэж байна.</p> <p>2020 оны ОУИТБС-ын Ажлын даалгавар нь УЗ-ийн баталсан журамтай нийцсэн ба үүнийг Засгийн газраас эцэслэн баталжээ. Үүнд Ажлын хэсгийн зүгээс санал өгсөн гэж буй ч иргэний нийгмийн хувьд 2020 оны ОУИТБС-ын тайланд баримталсан “үян хатан” хандлагад сэтгэл дундуур байна. Ярилцлагад хамрагдсан хэд хэдэн ТББ-ын зүгээс цар тахлын үеэр ч тайланд уламжлалт байдлаар нэгтгэл хийх боломжтой байсан гэж үзсэн ба учир нь тайлан гаргагч аж ахуйн нэгжүүд нь өөрийн мэдээллийн цахим тайлагналын платформоор хэдийн ирүүлсэн, энэ байдлаар нийт 1,400 гаруй компани тайлагнасан байсанд оршиж байна. Өмнөх Баталгаажуулалтын хугацаатай ижил төстэй нь Ажлын хэсэг тайлангийн маягтуудыг шууд батлаагүй (сүүлд 2020 оны тайланд зориулан өөрчлөлт оруулсан) харин Ажлын хэсгээс томилогдсон ажлын хэсэг нь ҮСХ-ны баталсан маягтуудад өөрийн саналыг бэлтгэн хүргүүлжээ. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь хамаарах оны Засгийн газар болон компаниудын аудит, баталгаажуулалтын арга ажиллагааны талаарх тоймыг тусгасан ч заавал хийгдэх аудит болон энэ нь олон улсын стандарттай нийцэж буй эсэхийг хамруулаагүй. Монгол улс нь ОУИТБС-ыг ашиглан ТӨК-иудын аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг төвлөрүүлэн хүртээмжийг нь хангасан ч аудитын процессын талаар тойм мэдээллээс бусдаар хувийн компаниудын санхүүгийн тайланг хамруулаагүй байна. ОУИТБС-д хийгдэх чанарын баталгаажуулалтыг Ажлын хэсэг баталж үүнд менежментийн мэдэгдэл, аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан зэргийг баталгаажуулалтын хэрэгсэл болгон тусгажээ. Тус тайланд чанарын баталгаажуулалт гарган ирүүлээгүй 19 компани (60-аас) 26 төрийн байгууллагын (41-ээс) жагсаалтыг гаргаж, тухайн байгууллага нэг бүр нь Засгийн газрын орлогод хэд хувийг эзэлж буйг заажээ. Тайлан нь санхүүгийн мэдээллийн үнэн зөв эсэхээс үүдсэн нөлөөллийг тайлбарлаагүй ч баталгаажуулалт гарган өгөөгүй компаниудын төлсөн татварын нийт дүнгээс харвал компаниудын нийт тайлагнасан мөнгөн дүнгийн талаас илүү нь чанарын баталгаажуулалтад хамрагдсан байна. Баталгаажуулалт гаран ирүүлээгүй, тайлан ирүүлээгүй компаниудын аль нь ч ОУИТБС-ыг дэмжигч компаниудтай холбоогүй байв. Тайлан нь зарим хэсэгт буй санхүүгийн мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдлын талаар зарим асуудлыг дурдсан ч 2020</p>

	оны ОУИТБС-ын тайланд багтан, ил тод болсон санхүүгийн мэдээллийн иж бүрэн, үнэн өв байдалтай хамаатай тодорхой мэдэгдэл байхгүй.
<b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлага 4.1-т заасанчлан Монгол улс нь уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудын зүгээс Засгийн газарт төлж буй бүх материаллаг төлбөр болон Засгийн газрын уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудаас хүлээн авч буй бүх материаллаг орлогыг иж бүрнээр нь олон нийтэд нээлттэй болгож, хүртээмжтэй, иж бүрэн нээлттэй байдлыг хангах шаардлагатай. Монгол улс нь уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудаас материаллаг түвшний төлбөр хүлээн авч буй бүх төрийн байгууллага эдгээр орлогыг хүлээн зөвшөөрсөн цар хүрээнд хамруулан ил тод тайлагнаж байхыг баталгаажуулах шаардлагатай. Хэрэв орлого нь материаллаг дүнг хүрэхгүй гэдгийг нотлон харуулсан тохиолдолд л төрийн байгууллагууд үүргээс чөлөөлөгдөж болно. Санаачилгын хэрэгжилтийн сайжруулахын тулд компаниудаас өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг эсвэл санхүүгийн тайлан байхгүй бол гол үзүүлэлтийг нь (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн үрсгал) ил тод болгохыг шаардаж хэрэгтэй.</li> <li>• Шаардлага 4.3 дээр заасны дагуу Монгол улс нь ашигт малтмал, газрын тос, байгалийн хий олборлох эрх олгосны төлөө бүхлээр нь эсвэл хэсэгчилсэн байдлаар бараа эсвэл үйлчилгээ (үүнд зээл, баталгаа, дэд бүтцийн бүтээн байгуулалт) авах эсвэл тухайн эрдэс баялгаас авах гэрээ хэлцэл буй эсэхийг харгалзан үзэх шаардлагатай. Үүнд Шаардлага 4.3 дээр заасан бартерын төрлийн арилжаа гэсэн тодорхойлолтод нийцэх нөөцөөр баталгаажсан зээл мөн багтана. Монголын ОУИТБС-ын зүгээс тухайн гэрээ хэлцэл нь материаллаг түвшинд нийцнэ гэж үзвэл хэрэгжилтийн хүрээнд эдгээрт анхаарч, ил тод болгохдоо бусад төрлийн татвар, төлбөрийн нэгэн адил түвшинд ил тод болгоно. Монголын ОУИТБС нь дээрх мэдээллийн чанар болон баталгаажуулалтын асуудлаар Шаардлага 4.9 дээр заасны дагуу анхааран, хамаарах журам процедурыг гаргах шаардлагатай.</li> <li>• Санаачилгын хэрэгжилтийн сайжруулахын тулд Монгол улс нь олборлох салбарт хийгдэж буй тээвэрлэлтийн гэрээний талаах нэмэлт мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах шаардлагатай ба үүнд тээвэрлэж буй бүтээгдэхүүний төрөл, тээврийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй аж ахуйн нэгж, байгууллагууд багтана. Монгол улс нь мөн хамаарах тээврийн татвар, тариф болон бусад хамаарах төлбөрийн тодорхойлолт болон тэдгээрийг тооцох арга зүйг тодорхойлон гарган шаардлагатай байна.</li> <li>• Шаардлага 4.7 дээр заасанчлан Монгол улс нь Засгийн газрын эрдэс баялгийн салбараас олж буй бүх орлого болон олборлох үйлдвэрлэлийн компаниудын төлж буй бүх татвар хураамжийг төсөл нэг бүрээр задаргаатай ил тод болгож байх шаардлагатай. Хэрэв эрх зүйн хэд хэдэн гэрээ нь харилцан холбоотой буй бол Монголын ОУИТБС нь аль тохиолдлыг нь нэг төсөл гэж тооцох талаар тодорхойлж, баримтжуулсан байх нь зөв. Харилцан холбоо бүхий гэрээ хэлцэл нь үйл ажиллагаа болон газар зүйн хувьд харилцан хамааралтай гэрээ, тусгай зөвшөөрөл, түрээс эсвэл концессыг хамарч, төлбөрийн үүрэг үүсгэдэг. Тухайн гэрээ хэлцлүүдийг нэг гэрээгээр, хамтарсан аж ахуйн нэгжээр, бүтээгдэхүүн хуваах гэрээгээр эсвэл бусад эрх зүйн гэрээгээр нэгтгэн зохицуулж байж болдог.</li> <li>• Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналын шинэлэг арга хандлагыг эрэлхийлж, одоо үйл ажиллагаа явуулж буй Засгийн газрын порталуудад суурилан үүнийг тодорхойлж, улмаар төр, салбар болон иргэний нийгмийн талуудын хэрэгцээнд нийцсэн шуурхай өгөгдөл мэдээллийг, цаг тухайд нь ил тод болгож байх хэрэгтэй.</li> </ul>	

- Шаардлага 4.9 дээр заасны дагуу Монгол улс нь өөрийн жил тутмын ОУИТБС-ын ил тод болгож буй мэдээлэлд тайлангийн хүрээнд жил тутам компаниудын зүгээс төлсөн хэмээн, төрийн байгууллагуудын зүгээс хүлээн авсан хэмээн тайлагнаж буй мэдээлэл нь үнэн бодит, хараат бус аудитаар баталгаажсан, олон улсын аудитын стандартад нийцсэн эсэх үнэлгээг багтаан тусгаж байх анхаарах шаардлагатай байна. 4 дүгээр шаардлагын дагуу Засгийн газар болон компаниудын ил тод болгож буй мэдээлэл нь үнэн бодит, олон улсын стандартын дагуу хийгдсэн хараат бус аудитаар баталгаажсан байх ёстой. Энэхүү үнэлгээнд тухайн өгөгдөл мэдээлэлд хийсэн аудит болон баталгаажуулалтын үйл явцыг тусган, дэмжих баримт бичгүүд болон компани болон Засгийн газрын аудит, баталгаажуулалтын үйл явцыг улам сайжруулах зөвлөмжүүдийг нийтэд нээлттэй болгоно. Санаачилгын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Монгол улс нь жил тутмын ОУИТБС-ын тайланг Засгийн газар болон компанийн аудит, баталгаажуулалтын үйл ажиллагаанд шинжилгээ хийн, олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн хөрөнгөнд олон нийтийн хяналтыг сайжруулах чиглэлд ажиллах нь зүйтэй.

## Орлогын менежмент (Шаардлага 5.1, 5.3)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

ОУВС-гийн өргөтгөсөн санхүүгийн хөтөлбөрт [2017 оноос хойш](#) хамрагдаж буй Монгол улс нь төсвийн бодлогоо чангатгах, орлого болон зардлыг улсын төсөвт нэгдсэн байдлаар нэгтгэн бүртгэж байх зэрэг төсөв санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. ННФ-ын зүгээс ТӨК-иудын зардалд 2021 онд хийсэн судалгааны [тайланд](#) хоёр гол ТӨК болох Эрдэнэс Монгол болон Эрдэнэт УБУ нь 2020- 2021 онуудад нийт 2 их наяд төгрөгийн (683 сая ам.доллар) төсвийн шинжтэй зарцуулалт хийснийг тооцон гаргажээ. Монгол улс нь ОУИТБС-ын тайланг ашиглан Засгийн газрын Төсвийн тогтворжуулалтын сангийн үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлбарлаж, санхүүгийн тайлангаараа ил тод болгосон ТӨК-иудын мэдээллийн зураглалыг гаргаж ирсэн ч сүүлд (2019- 2020) гарсан ОУИТБС-ын тайлангууд нь улсын төсөвт бүртгэгдэхгүй буй олборлох салбарын орлогуудыг тодорхой ялган салгаагүй байна. КОВИД-19 цар тахлын үеэр ТӨК-иудын төсвийн шинжтэй зарцуулалт өсөн нэмэгдсэн нь Засгийн газрын зүгээс олон улсын зээлдүүлэгчдийн өмнө нэгдсэн төсвийн бодлого барих амлалт авсантай холбоотойгоор илүү ихээр ил тод болгох нэн тэргүүн хэрэгцээ байгааг харуулж байна. Монгол улсын [2021 оны төсвийн зарцуулалт, санхүүгийн тайлагналын тайланд \(PEFA\)](#) дурдсанчлан ОУВС-гийн Төрийн санхүүгийн системийн ангилалд ТӨК-иудыг багтаан өргөжүүлэх, мөн ОУИТБС-ын салбарт хамаарах Засгийн газрын санхүүгийн статистикийн (GFS) системийг ашиглан Засгийн газрын орлогод хамаарах олборлох салбараас төвлөрүүлэх орлогыг Засгийн газрын орлогын нягтлан бодох бүртгэлд тусгах боломжтой юм.

Монгол улсын Засгийн газар нь төслийн явцтай холбоотой олон талыг хамарсан хэд хэдэн портал ажиллуулдаг ба үүнд Сангийн яамны төсвийн портал, Төрийн худалдан авах ажиллагааны вэбсайт, Ерөнхий аудитын газрын вэбсайт, Орон нутгийн хөгжлийн сангийн портал болон 5 сая төгрөгөөс дээр бүх гүйлгээг төрийн бүх байгууллага заавал мэдээлж байх ёстой Шилэн дансны портал багтдаг. Засгийн газрын зүгээс дунд хугацааны төсвийн мэдэгдлийг гарган 5 жилийн хугацааны таамгийг нийтэлж, энэ талаар оролцогч талуудтай, ялангуяа иргэний нийгэмтэй

зөвлөлдөх замаар олон нийтийн сонирхлыг олборлох үйлдвэрлэлийн салбарын тогтвортой байдал, орлогын баялгаас хамааралтай байдалд хандуулж байна. Салбарын зүгээс ч Засгийн газрын зүгээс ил тод болгож буй мэдээллийг улам өргөжүүлэх сонирхолтой буйгаа илэрхийлж байсан.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Олборлох үйлдвэрлэлийн салбарын орлогын хуваарилалт (Шаардлага #5.1)</b></p> <p><i>Хэсэгчлэн ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын алба нь Шаардлага 5.1-ийг Монгол улс ихэнх хэсгийг нь ханган биелүүлсэн хэмээх дүгнэлтийг өгч байна. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс олборлох салбараас төвлөрүүлж буй орлогыг улсын төсөвт орох хүртэл хянах чиглэлд гарч буй ахиц дээр шүүмжлэлтэй хандсан ба үүний гол шалтгаан нь ТӨК-иудын зүгээс төсвөөс гадуур их хэмжээний зээл өгөх, шилжүүлэг хийх явдал түгээмэл байгаад оршиж байна. Төр болон салбарын хэд хэдэн төлөөллийн зүгээс хэлэхдээ Засгийн газар нь 2022 онд Төрийн өмчийн тухай хууль, Баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан төсвийн гадуурх төсвийн орлогыг удирдлагыг сайжруулах төлөвлөгөөтэй буйг дурдсан. Олон улсын Ажлын албаны зүгээс Монголын ОУИТБС нь улсын төсөвт бүртгэгдэхгүй буй олборлох салбараас төвлөрүүлж буй орлогыг хянах чиглэлээр үхралт гаргасан хэмээн үзсэн ба төсвийн гадуурх орлогын ил тод, эргэн тайлагнах байдлыг түвшин сайжраагүй, төсөвлөсөн орлогынхоо хэмжээнд л эргэлдэж байна хэмээн үзэж байна.</p> <p>Монгол улсад одоогоор хоёр баялгийн сан үйл ажиллагаа явуулж буйгаас зөвхөн нэгийг нь л ОУИТБС хамруулж байна. Ирээдүйн өв сан болон Төсвийн тогтворжуулалтын санг 2017 онд баялгийн сан хэлбэрээр анх байгуулсан ба Ирээдүйн өв сан нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд гадаад улсад хөрөнгө оруулалт хийн, хөрөнгө худалдан авах зориулалттай бол Тогтворжуулалтын сан нь богино хугацаанд төсвийн орлогыг тогтворжуулах зориулалттай. Гэвч Ирээдүйн өв санг бодит зориулалтаар нь ажиллуулаагүй, харин төвлөрсөн орлогыг нь КОВИД-19 цар тахлын үеэр улсын төсөвт шилжүүлжээ. Ярилцлагад хамрагдсан нэг ИНБ-ын зүгээс тэдний хийсэн Шилэн дансны мэдээлэлд буй орлогын үрсгалд суурилсан тооцоогоор Ирээдүйн өв санд 4 их наяд (ойролцоогоор 1 тэрбум ам.доллар) төвлөрсөн байх ёстой ажээ. Үүнийг сүүлд гарсан Монголын ОУИТБС-ын тайланд (2019- 2020) оруулаагүй. ОУИТБС-ын 2020 оны тайланд Төсвийн тогтворжуулалтын сангийн үйл ажиллагааны талаар тайлбарлаж, 2020 онд олборлох салбараас төвлөрүүлсэн орлогоос тус санд шилжүүлсэн хөрөнгийн тухай мэдээлэл, сангаас 2020 онд улсын төсөвт шилжүүлсэн мөнгөн дүн зэргийг тусгажээ. Гэвч ОУИТБС-ын тайлан нь ТӨК-иудын төвлөрүүлж буй эсвэл зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагуудаас хураан авч буй боловч төсөвт бүртгэгдэхгүй буй Засгийн</p>

	<p>газрын ямар нэгэн орлого байгаа эсэхийг тодруулаагүй, хэрэв байгаа бол тухайн төсвийн гадуурх орлогыг хэрхэн удирдаж буйг тайлбарлаагүй, хамаарах санхүүгийн тайлангийн холбоосыг заагаагүй байна. ТӨК-иудын санхүүгийн харилцаа, төсвийн шинжтэй зарцуулалтыг ил тод байдал нь улсын төсөвт бүртгэгдээгүй орлогыг олборлох салбараас төвлөрүүлж байгааг харуулна. Оролцогч талуудтай хийсэн ярилцлага болон Олон талт хөгжлийн байгууллагуудын тайлан (Монгол улсын <a href="#">2021 оны төсвийн зарцуулалт, санхүүгийн тайлагналын (PEFA) тайлан</a>) зэрэг нь ТӨК-иуд олборлох үйлдвэрлэлээс орлого олж, үүнийг улсын төсөвт бүртгэхгүй буйг харуулж байна. Монгол улс нь ОУИТБС-ын тайланг ТӨК-иудын санхүүгийн тайлангуудыг нэгтгэн харуулахад ашигласны зэрэгцээ ТӨК-иудын ил тод болгож буй мэдээллийн хийдэл, дутагдалтай талыг тодруулан харуулсны тоонд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-иудын санхүүгийн тайлангууд олон нийтэд ил тод бус буй байдал багтжээ. ОУВС-гийн тайланд Засгийн газрын санхүүгийн статистикийн гарын авлагын дагуу орлогын ангиллын систем ашигладаг хэмээн дурдсан ч Монголын ОУИТБС-ын тайланд үндэсний эсвэл олон улсын орлогын ангиллын системийн талаар заагаагүй байна. Монголын ОУИТБС-ын Ажлын албаны зүгээс Баталгаажуулалтын тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбартаа цаашид ОУИТБС-ын тайлагналд Шаардлага 5.1-ийг хангах байдлыг сайжруулахаар тусгасан.</p>
<p><b>Орлогын менежмент болон зарцуулалт (Шаардлага #5.3)</b></p> <p><i>Үнэлээгүй</i></p>	<p>Олон улсын Ажлын албанаас Монгол улс нь Шаардлага 5.3-ыг хангасан эсэх дээр тухайн хугацаанд үнэлгээ хийгээгүй. Ярилцлагад оролцсон талуудын зүгээс олборлох үйлдвэрлэлээс төвлөрүүлж буй орлогын удирдлагын ил тод байдалд гарч буй ахиц, орлогыг тусгайлан заасан төсвийн зарцуулалтад ашиглах болон төсвийн үйл явцын талаар талаар илэрхийлсэн санал бодол нь ялгаатай байв. Хэд хэдэн төрийн албан тушаалтны зүгээс хэлэхдээ Сангийн яамны ажиллуулж буй олон төрлийн порталууд нь төсвийн болон аудитын үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэл агуулж буй гэсэн ч бусад талуудын төлөөлөл үүнтэй санал нийлэхгүй байв. Салбарыг төлөөлсөн хэд хэдэн төлөөллийн зүгээс Засгийн газрын зарцуулалтын менежментийн талаар илүү их мэдээлэл ил тод байх ёстой, энэ нь ОУИТБС-ын хэрэгжилтийн нэг тэргүүлэх чиглэл хэмээн үзсэн. Иргэний нийгмийн төлөөллийн зүгээс цаашид орлогын тогтвортой байдал, орлогын эрдэс баялгаас хамааралтай байдлын талаар олон нийтийн ойлголтыг бий болгохын тулд илүү их мэдээлэл ил тод байх ёстой гэж үзсэн.</p> <p>Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг ашиглан тодорхой зориулалтаар зарцуулагдах төсвийн орлого, төсөв болон аудитын явц, төсвийн орлогод нөлөөлөх эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, орлогын таамаглал зэргийг ил тод болгох хичээл зүтгэл гаргажээ. Ийнхүү ил тод болгож буй мэдээлэл нь <a href="#">улсын төсөв</a>, <a href="#">аудитын явц</a>, <a href="#">Орон нутгийн хөгжлийн сан</a>, <a href="#">Шилэн данс</a> болон <a href="#">төрийн худалдан авах ажиллагаа</a> зэрэг Засгийн газраас ажиллуулж буй олон платформ дээр тулгуурладаг. Гэвч Монгол улс нь төсөв, аудитын мөчлөгийн талаарх иж бүрэн тоймыг тусгаагүй, улмаар орлогын тогтвортой байдал, хамааралтай байдлын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах нэмэлт мэдээллийг тусгаагүй. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ирэх жилүүдийн төсвийн мөчлөгийн талаарх таамаг мэдээллийг тусгаж буй ч олборлох</p>



	<p>үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлэхээр таамаглаж буй орлого, эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ, орлого зэргийг ил тод мэдээлдэггүй. Шаардлагад хамаарах зарим хэсгийг иж бүрнээр хэрэгжүүлээгүйг харгалзан Шаардлага 5.3-ыг биелсэн хэмээн үзэх боломжгүй тул үнэлэлгүй орхисон. Гэвч Засгийн газрын зүгээс аудит, төсвийн явцын талаар системтэйгээр ил тод болгож байхын ач холбогдлыг энэхүү тайлангийн эхэнд буй үр дүнтэй байдал, тогтвортой байдлын үзүүлэлт дээр тусгайлан заасан.</p>
<p><b>Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд</b></p>	
<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлага 5.1 дээр заасанчлан Монгол улс нь олборлох салбараас төвлөрүүлж буй ямар орлогыг- бэлэн болон бэлэн бусаас үл хамааран- улсын төсөвт бүртгэж буйг олон нийтэд ил тод болгох шаардлагатай. Орлогыг улсын төсөвт бүртгэхгүй буй тохиолдолд эдгээр орлогыг хэрхэн хуваарилан зарцуулж буйг нийтэд хандан тайлбарлах ба жишээ нь баялгийн болон хөгжлийн сангууд, орон нутгийн захиргаа, төрийн өмчит компани болон бусад төсвийн бус байгууллага зарцуулж буй эсэхийг нээлттэй болгох.</li> <li>• Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-ыг цаашид орлогын тогтвортой байдал, эрдэс баялгаас хамаарах хамаарал зэргийн талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах зорилго бүхий шуурхай ил тод мэдээллийн арга зүй байдлаар ашиглах нь зүйтэй ба үүнд төсвийн мөчлөг дэх ирэх жилүүдийн таамаг, төлөвлөж буй үйлдвэрлэлийн хэмжээ, олборлох салбараас төвлөрүүлэх орлогын таамаглал, ирээдүйд салбараас олох орлогын төсөвт эзлэх хувь хэмжээ зэргийг багтааж болно.</li> </ul>	

## Орон нутагт оруулж буй хувь нэмэр (Шаардлага 4.6, 5.2, 6.1)

### Модуль дээр гарсан ахиц дэвшлийн тойм

Монгол улсын 21 аймаг, нийслэл болон 331 сумын ихэнх нь өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй олборлох үйлдвэрлэлийн компаниудаас шууд татвар, төлбөр хүлээн авдаг. Эдгээр шууд орон нутагт хийгдэж буй төлбөр нь (2020 онд Засгийн газрын уул уурхайн салбараас төвлөрүүлсэн нийт орлогын дөнгөж 1%-тай тэнцэх) хэмжээний хувьд бага ч ярилцлагад хамруулсан бүх талуудын үзэж буйгаар нутгийн иргэдэд хамгийн чухал, мэдрэгдэхүйц орлого байдаг ажээ. Монголын ОУИТБС-ын тайлагналын портал нь олборлох салбарын компаниудын зүгээс шууд орон нутагт төлж буй эдгээр төлбөрийг хамарч буй ч 2020 оны ОУИТБС-ын тайланд олсон орлогоо тайлагнах ёстой нутгийн захиргааны байгууллагуудын тайлан дахь зөрүүг л тусгажээ. Монгол улсын хувьд ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутгийн захиргаа өөрийн хүлээн авсан орлогыг ил тод болгож буй эсэхийг нь байнгын болон системтэй байдлаар ил тод болгохыг нь баталгаажуулах, хяналт хийх, нутгийн захиргаад өөрийн төвлөрүүлсэн орлогыг хэрхэн удирдан зарцуулж буй нутгийн иргэдийн тавих хяналтын сайжруулах зэрэгт ашиглах боломжтой юм.

Монгол улсын хувьд төвлөрүүлж буй нийт орлогоос орон нутагт хуваарилж буй хэсэг нь олон нийтийн сонирхлыг ихээхэн татдаг болохыг ярилцлагад оролцсон талууд тэмдэглэн хэлсэн. Орон нутгийн хөгжлийн ерөнхий сангаар дамжуулан орон нутагт хуваарилдаг хөрөнгийн эх үүсвэр нь

олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн орлого болон НӨАТ зэрэг татварын орлого байдаг нь орон нутагт шилжүүлж буй олборлох үйлдвэрлэлийн салбарын орлогыг хянахад хүндрэл учруулдаг. Засгийн газраас Орон нутгийн хөгжлийн санд санхүүжилт олгож, орон нутагт (аймаг, сум) төсөв хуваарилах ба тухайн хөрөнгийг орон нутгаас санал болгосон төслүүдийг санхүүжүүлэхэд ашигладаг. Донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр Сангийн яам нь аймаг бүрд ОНХС-гаас аймаг, сум бүрд тодорхой төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан шилжүүлж буй хөрөнгийн зарцуулалтыг хянах порталыг хөгжүүлсэн. Монголын ОУИТБС-ын сүүлийн тайланд 30 аймаг, сумдад хуваарилахаар төлөвлөсөн болон бодитоор санхүүжүүлсэн дүнг ил тод болгосон ч ОНХС-гаас санхүүжилт авч буй бусад аймаг, сумдын мэдээлэл бүрэн ил тод болгоогүй. Өмнө хийгдсэн Баталгаажуулалтын хугацаатай (2017- 2018) харьцуулбал Монголын ОУИТБС-ын 2019, 2020 оны тайлангууд нь аймаг, сум бүрд хуваарилах ёстой олборлох салбараас төвлөрүүлсэн орлогын хэмжээг тооцоогүй, тухайн тооцоолсон шилжүүлгийг ОНХС-д бодитоор шилжсэн дүнтэй нь харьцуулаагүй. ОУИТБС-ын хувьд энэхүү олборлох салбарын орлогоос жил тутамд ОНХС-д хийгддэг санхүүжилтэд жил тутам хяналт хийх замаар ОНХС-гийн порталд дутагдаж буй зүйлсийг нөхөн боломжтой байна.

Уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниуд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэд, захиргаатай Орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулан ажиллах хуулиар тогтоосон үүрэгтэйн зэрэгцээ тэд нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах үүргийг гэрээгээр (уул уурхайн зарим гэрээгээр) хүлээдэг. Иргэний нийгэм нь 200 гаруй Орон нутгийн хөгжлийн гэрээг ил тод болгоход тэргүүлэн ажилласан ч талуудтай хийсэн ярилцлагаар тухайн гэрээнүүд бүрэн хэмжээгээр ил тод болоогүйг дурдсан. Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг ашиглан Орон нутгийн хөгжлийн гэрээний хүрээнд компанийн төлж, нутгийн захиргааны хүлээн авч буй төлбөрийг ил тод болгож ирсэн ч ОУИТБС-ын тайлагналын “уян хатан” хандлага баримтлах болсноор үүнд хамрагдах компаниудын тоо буурчээ. Нийгмийн чиглэлтэй зарцуулалтыг, үүнд тодорхой гэрээний хүрээнд болон сайн дурын үндсэн дээр хийж буй зарцуулалтыг нэмэлтээр ил тод болгож байх шаардлагыг талуудын зүгээс тавьж байна.

Олборлох үйлдвэрлэлийн салбараас байгаль орчинд нөлөөлж буй байдал дээр олон нийтийн сонирхол маш өндөр байна (*Шардлага 6.4 дээр үзнэ үү*). Энэхүү олон нийтийн сонирхол нь ус ашигласны төлбөр, агаарын болон ус бохирдуулсны төлбөр зэрэг төрд төлдөг бага хэмжээний төлбөрөөс илүүтэйгээр байгаль орчны нөхөн сэргээлтийн сангийн (барьцаа хөрөнгө байдлаар эскроу дансанд байршдаг хөрөнгө бөгөөд компани нь төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлаа хийж дуусгасны дараа эргэн төлөгддөг) удирдлагын мэдээллийг ОУИТБС-ын хүрээнд ил тод болгох хэрэгцээг үүсгэжээ. Гэвч Монголын ОУИТБС-ын 2020 оны тайланд компаниудын байгаль орчны зарцуулалт, төлбөрийг ил тод болгосон мэдээллийн иж бүрэн байдал тодорхойгүй, байгаль орчны чиглэлийн төлбөрөө ил тод тайлагнасан компаниудын тоо бага байна. Компаниудын зүгээс байгаль орчны нөхөн сэргээлтийн санд төлж буй мөнгөн дүнг ил тод болгох чиглэлээр 2016 оноос хойш Монгол улсын авч хэрэгжүүлж буй хүчин чармайлтыг өндөр үнэлж байгаа ч суманд байх байгаль орчны нөхөн сэргээлтийн тусгай дансанд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төлж буй дүнг ил тод болгох явц хомс, энэ мэдээллийг иргэний нийгэм ихээр сонирхож байна. Байгаль орчны нөхөн сэргээлтийн сангийн удирдлага, хяналтад шинжилгээ хийх, үүнд нөхөн сэргээлтээ хийж дуусгасан компаниудад барьцаа хөрөнгийг буцаан олгох явц, байгаль орчныг нөхөн сэргээх ажилд зарцуулж буй хөрөнгө, сангийн аудит болон

хяналт зэргийг багтаан шинжлэх ажлыг гүйцэтгэх замаар санаачилгын хэрэгжилтийг сайжруулж болно.

### Шаардлагыг хангах чиглэлээр гарсан ахиц дэвшил, засан залруулах арга хэмжээ

ОУИТБС-ын шаардлага нэг бүрээрх дэлгэрэнгүй үнэлгээ эсвэл засан залруулах үйл ажиллагааг энэхүү тайлангийн хавсралтад заасан мэдээлэл цуглуулах маягт дээр үзэж болно.

ОУИТБС-ын шаардлагууд болон үнэлгээ	ОУИТБС-ын шаардлагуудыг хангах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийн тойм
<p><b>Орон нутгийн төлбөр (Шаардлага #4.6)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 4.6 дээр заасан ихэнх хэсэг ханган биелэгдсэн хэмээн дүгнэж байна. Зарим төрийн албан тушаалтны зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбараас өөрийн төвлөрүүлсэн орлогыг удирдах нутгийн захиргаанд хяналт тавих боломжийг сайжруулах зорилт хангагдсан гэж үзэж буй бол хөгжлийн түншлэгч байгууллагуудын зүгээс Монголын ОУИТБС нь олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс орон нутгийн захиргаанд шууд төлж буй төлбөрийг ил тод болгох нь ОУИТБС-ын хэрэгжилтийн гол үр дүн болно хэмээн үзэж байна. Иргэний нийгмийн төлөөллийн зүгээс зарим орон нутаг, компани тайлангаа гаргахгүй буй, ирүүлсэн мэдээлэлд буй зөрүү өндөр хэмжээтэй буй ч энэхүү зорилтын ихэнх хэсэг нь биелэгдсэн хэмээн үзсэн. Олон улсын Ажлын албаны зүгээс орон нутаг олборлох салбарын компаниудаас шууд хүлээн авч буй төлбөрийг ил тод болгох цахим тайлагналын системийг бий болгох замаар энэхүү зорилтыг хангахад ахиц гаргасан хэмээн үзэж буй ч бүх хамаарах аймаг, сумдын зүгээс иж бүрнээр ил тод болгоход асуудалтай буй тул ихэнх хэсэг нь л биелэгдсэн гэж үзэж байна.</p> <p>Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын платформ нь 2020 онд нийт 2,096 тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн 1,472-ынх нь орон нутгийн захиргаанд төлсөн дүнгийн мэдээллийг ил тод болгосон ч орон нутгийн шууд төвлөрүүлж буй орлогыг аймаг, сумдаар нь ангилан харах боломжгүй буй нь шаардлагатай мэдээллийг гарган ирүүлээгүй орон нутгийг олж тогтооход саад тотгор учруулж байна. Монголын ОУИТБС-ын 2020 оны тайланд нутгийн захиргаанд төлбөр төлсөн хэмээн тайлагнасан материаллаг дүн бүхий компаниудын олонх (60-аас 57) болон тэдний үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн захиргааг сонгон авч нэгтгэлд хамруулсныг талууд нотолсон. Гэвч 2020 оны ОУИТБС-ын тайлагналд хамрагдсан орон нутгийн захиргааны тоон дээр тодорхойгүй зүйл байгаагийн жишээнд тайлангийн нэг хэсэгт 7 аймаг байгаа бол нөгөө хэсэгт нь 23 болон 25 гэсэн зөрүүтэй тоо байна. Ярилцлагын үеэр Хараат бус аудиторын зүгээс тодруулга өгөхдөө бүх 21 аймаг тайлангаа ирүүлсэн ба сумаар гаргасан тайлангуудыг аймгаар нь нэгтгэсэн хэмээн тайлбарласан. Монгол улсад хэдэн аймагт уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй тооцоолол нь олон янз, ихэнх нь бүх 21 аймаг, 331 сумын 100 орчимд нь уул уурхайн тусгай зөвшөөрөл олгогдсон буй хэмээн үзэж байна. Гэвч ОУИТБС-ын тайлан болон хавсралтуудаас үзвэл багадаа хоёр аймаг 2020 оны тайлангаа гаргаагүй харагдаж байна. Нэгтгэлийн өмнөх болон дараах үед хамаарах компани болон нутгийн захиргааны ил тод</p>

	<p>болгосон мэдээллийг (тайлан гаргасан 57 компаниар) нэгтгэн тулгаж харуулсан нь дэлгэрэнгүй бус буй нь орон нутагт шууд төлж буй төлбөрийн ил тод байдлыг хангах, тайлан гаргаагүй орон нутгийн материаллаг хэмжээг үнэлэхэд саад тотгор учруулж байна. Олборлох үйлдвэрлэлийн компаниудын орон нутагт шууд төлж буй төлбөрийн мэдээллийг ашиглан орон нутагт хүрч ажиллах, мэдээлэл түгээх үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм болон тухайн мэдээллийг ил тод болгох нь үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрлийг нь баталгаажуулах салбарын төлөөлөл аль нь компаниудаас орон нутагт шууд төлж буй төлбөрийн ил тод байдлыг ихээхэн сонирхож байна.</p>
<p><b>Орон нутагт хийх шилжүүлэг (Шаардлага #5.2)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны үнэлгээгээр Шаардлага 5.2-ийг ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээн үзэж байна. Хууль заасан журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлсэн орлогоос орон нутагт (аймаг, сум) заавал хуваарилах ёстой орлогын хувь хэмжээг ОУИТБС-ын тайланд баталгаажуулжээ. Үүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мега төслүүдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн тал хувь зэрэг багтдаг. Олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн орлогоос Орон нутгийн хөгжлийн ерөнхий санд мөн төвлөрүүлж тэндээ Орон нутгийн хөгжлийн сангуудыг санхүүжүүлэх ба тус сан мөн бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлсэн татварын (НӨАТ гэх мэт) тодорхой хувиар санхүүждэг. Орон нутгийн хөгжлийн сан нь санхүүжилтийг орон нутаг дахь хөгжлийн сангуудад шилжүүлэх ба тус сан нь аймаг, сумдын батлагдсан төслүүдийг санхүүжүүлнэ.</p> <p>Сангийн Яам нь хөрөнгийн хуваарилалт, төслүүдийн гүйцэтгэлд орон нутгийн түвшинд хяналт тавих зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн <a href="#">вэбсайт</a> ажиллуулдаг. Энэхүү портал нь хамаарах <a href="#">хууль, журам</a> болон <a href="#">төслийн гүйцэтгэлийн</a> мэдээллийг аймаг, сум бүрээр харуулдаг ч Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл ил тод байхгүй. Тус портал нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар <a href="#">хязгаарлагдмал мэдээлэлтэй</a> байна. Монгол улс нь өөрийн ОУИТБС-ын тайлангаар олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн хөрөнгөөс Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх хувь хэмжээ, бодит шилжүүлэг зэргийг орон нутгийн байгууллага бүрээр харьцуулан гаргахын зэрэгцээ хамгийн сүүлийн тайлан нь (2019 болон 2020 он) Орон нутгийн хөгжлийн ерөнхий сангаас 30 аймаг суманд шилжүүлэхээр төсөвлөсөн болон шилжүүлсэн мөнгөн дүнг ерөнхий дүнгээр нь тусгасан нь орлого хуваарилах томьёоны дагуу уул уурхайн салбарын орлогоор бус, нэгдсэн дүнгээр тайлагнажээ. Сүүлд гарсан ОУИТБС-ын тайлангууд нь олборлох салбараас төвлөрүүлэн ОНХС-д шилжүүлсэн орлогын дүнг (тусгай зөвшөөрлийн төлбөр, АМНАТ), мөн томьёоны дагуу шилжүүлсэн байх ёстой дүнгээс зөрсөн шалтгааныг тусгаагүй. ОНХС-гийн портал дээрх мэдээлэл нь олон тооны орон нутгийн захиргаад шилжүүлэн хүлээн авч буйг харуулсан ч сүүлд гарсан ОУИТБС-ын тайлангууд нь цөөн тооны аймаг, сумдад л төвлөрчээ. Тиймээс олборлох салбараас төвлөрсөн орлогоос орон нутагт шилжүүлэх ёстой болон шилжсэн орлогыг ил тод болгох тал дээр үхралт гарчээ. Ярилцлагад хамрагдсан талуудын зүгээс Монголын ОУИТБС-ын орон нутгийн орлогын ил тод байдлын талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй ч ОНХС-гийн портал нь орон нутгийн шилжүүлгийн талаарх мэдээллийн гол портал болохыг цохон</p>

	<p>тэмдэглэсэн. Олон улсын Ажлын албаны хувьд ОНХС-гийн портал нь ОНХС-гаас аймаг, сумдад хийгдэж буй шилжүүлгийг ил тод болгох, хүртээмжийг сайжруулахад ихээхэн түлхэц болсон гэж үзэж буй ч ОУИТБС-ын зүгээс ОНХС-гаас орон нутагт шилжиж буй мөнгө нь орлого хуваарилах томьёоны дагуу хийгдэж буйг баталгаажуулахад тодорхой үүрэг гүйцэтгэх нь зүйтэй. Тиймээс орон нутагт буй оролцогч талуудад олборлох салбарын орлогоос орон нутагт хийгдэж буй шилжүүлэг, үүний удирдлага нь хуульд заасны явагдаж буй эсэхийг хянах боломж олгох зорилтын ихэнх хэсгийг Баталгаажуулалтад хамрах хугацаанд ханган биелүүлжээ. Баталгаажуулалтын тайлангийн төсөл дээр ирүүлсэн тайлбартаа Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь цаашид ОУИТБС-ын тайлагналд Шаардлага 2.5-ыг даган мөрдөх байдлыг сайжруулах тухай дурдсан.</p>
<p><b>Нийгэм, байгаль орчны зарцуулалт (Шаардлага #6.1)</b></p> <p><i>Ихэнх хэсгийг ханган биелүүлсэн</i></p>	<p>Олон улсын Ажлын албаны зүгээс Шаардлага 6.1-ийн ихэнх хэсгийг ханган биелүүлсэн хэмээн байдлаар дүгнэж байна. Ярилцлагад хамрагдсан салбар болон төрийн хэд хэдэн төлөөллийн зүгээс компаниудын нийгэм, байгаль орчны зарцуулалтын ил тод байдлыг ОУИТБС-ын тайлагналын хүрээнд хангасан хэмээн үзсэн. Гэвч ярилцлага хийсэн ихэнх ИНБ-ын зүгээс үүнтэй санал нийлэхгүй, Орон нутгийн хөгжлийн гэрээнд тусгасан нийгмийн зарцуулалт болон Байгаль орчны нөхөн сэргээлтийн сангийн удирдлагын талаар илүү хариуцлагатай хандаж, тодорхой болгох ёстой гэж үзсэн. Олон улсын Ажлын албаны зүгээс Монгол улс нь энэхүү зорилтыг биелүүлэхэд ахиц дэвшил гаргасан ч биелэлт дээр компаниудын зүгээс нийгэм, байгаль орчны зарцуулалтын иж бүрэн ил тод байдлын хувьд зорилт бүрэн биелэгдээгүй гэж үзсэн.</p> <p>Монгол улсад компаниудад үүрэг болгосон хоёр төрлийн нийгмийн чиглэлийн зарцуулалт байна. Эхнийх нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргаа, иргэдтэй Орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулахаар хуульд заасан үүрэг бөгөөд ОУИТБС-ын хүрээнд энэхүү гэрээний хүрээнд гарсан бүхий л гүйлгээ, төлбөрийг ил тод тайлагнах үүрэгтэй (жишээ нь хандив гэх мэт). Иргэний нийгмийн санаачилгаар нээлттэй гэрээний <a href="#">портал</a> дээр 204 Орон нутгийн хөгжлийн гэрээг ил болгон нийтэлсэн ч хамгийн сүүлд нийтэлсэн гэрээ нь 2019 оны л гэрээ байна. Монголын ОУИТБС-ын 2020 оны тайлангийн Хавсралт 21 дээр эдгээрээс 183 Орон нутгийн хөгжлийн гэрээний гол үзүүлэлтүүдийг тусгасан. ОУИТБС-ын жил тутмын тайлан, үүний хавсралтууд нь Орон нутгийн хөгжлийн гэрээний хүрээнд олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийгмийн чиглэлтэй төлбөрийг ил болгох гол арга зам байна. Санаачилгын <a href="#">цахим тайлагналын платформ</a> нь компаниудын нийгмийн зарцуулалтын талаарх мэдээлэл түгээж буй ч тухайн мэдээлэл нь хангалттай задаргаатай нарийн мэдээлэл бус байна (жишээ нь хүлээн авагчаар гэх мэт). Заавал шаардагдах нийгмийн шинжтэй хоёр дахь төлбөр нь нийгмийн дэд бүтэц байгуулах гэрээний шаардлагын хүрээнд хийгддэг. Монголын ОУИТБС-ын 2020 оны тайланд эдгээр гэрээний заалтыг бартерын төрлийн дэд бүтцийн бүтээн байгуулалт хэмээн буруу ангилсан ба төрийн байгууллага талаас тухайн төлбөрийг хүлээн авсан баримт нотолгоо байхгүй байна. Тайлангийн хавсралтууд дээр нийгмийн дэд бүтцэд (жишээ нь зам) хамаарах гэрээний гол нөхцөлүүд, төлөвлөсөн зардлын дүнг тайлагнасан ч тухайн 2020 онд гарсан бодит зарцуулалтыг тусгаагүй. Ярилцлагын үеэр иргэний нийгмийн оролцогч талуудын зүгээс уул уурхайн компаниуд нь Орон нутгийн хөгжлийн гэрээнээс гадуур бусад нийгмийн зардал ихээр гаргадаг тул эдгээрийг</p>

	<p>ил тод болгохыг шаардсан. Ярилцлагад хамрагдсан салбарын оролцогч талуудын зүгээс томоохон уул уурхайн компаниуд нь өөрийн нийгмийн хариуцлагын тайлан, зардлыг вэбсайт дээрээ байршуулдаг болохыг цохон дурдсан. Баталгаажуулалтын тайланд тайлбар болгон Монголын ОУИТБС-ын ажлын албаны зүгээс хандив тусламжийн бодит хуваарилалтын талаарх мэдээллийг гаргуулан авахын тулд төрийн болон орон нутгийн байгууллагуудад зориулсан ОУИТБС-ын тайлангийн маягтууд дээр өөрчлөлт оруулсан тухай дурдсан ба энэ нь эерэг үр дүн болжээ.</p> <p>Засгийн газарт хандан төлж буй байгаль орчинтой хамаарах төлбөр, хураамжийн хувьд Монгол улс нь ОУИТБС-ын тайлагналыг (хамгийн сүүлд 2020 оны) ашиглан компаниудаас хураадаг орлогын гурван урсгалыг (нэг нь улсын төсөвт, хоёр нь орон нутгийн төсөвт) ил болгож, компани болон хүлээн авагч төрийн байгууллага талаас нэгтгэн шалгаж байна. Гэвч орлогын гурван урсгалын хоёрынх нь орлого нь олборлох үйлдвэрлэлийн компаниудад ноогдуулсан шаардлагаас хамаагүй бага, нийт 12 компаниас 33.8 тэрбум төгрөгийг агаарын бохирдлын төлбөрийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, 3 компаниас 6 сая төгрөгийг ус бохирдуулсны төлбөрт орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. ОУИТБС-ын 2020 оны тайлан нь “уян хатан” аргачлал баримталсан тул нэгтгэлд хамрагдах компаниудын тоо 2019 онд 200 байсныг 2020 онд 60 болтол бууруулсан нь ОУИТБС-ын тайлан дахь нийгмийн зарцуулалтын хэмжээ буурсан харагдахад хүргэжээ. Ярилцлагад хамруулсан иргэний нийгмийн хэд хэдэн төлөөллийн зүгээс энэ байдалд сэтгэл маш дундуур буйгаа илэрхийлж, “уян хатан” хандлага нь нэгтгэлд хамруулах компаниудын тоог бууруулж буйг нь шүүмжилж байв. Монголын ОУИТБС нь уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс байгаль орчны нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлж буй мөнгөн дүнг мөн ил болгож буй ч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс сумын байгаль орчны нөхөн сэргээлтийн санд төвлөрүүлж буй хөрөнгийг үүнд хамруулдаггүй. Олон улсын Ажлын албаны зүгээс өмнөх Баталгаажуулалттай харьцуулбал нийгэм, байгаль орчны зарцуулалттай холбоотойгоор үхралт хийсэн гэж үзэж байна.</p>
--	---

**Засан залруулах шинэ арга хэмжээ болон зөвлөмжүүд**

- Шаардлага 4.6 дээр заасны дагуу Монгол улс нь орон нутгийн түвшинд материаллаг түвшнээс дээш компаниудын төлсөн татвар, төрийн хүлээн авсан орлогыг аймаг болон сумаар нь иж бүрнээр нь ил тод болгоход анхаарах шаардлагатай байна. Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Засгийн газар нь хамаарах бүх аймаг, сум тайлангаа гарган ОУИТБС-д ирүүлж байхыг баталгаажуулах шаардлагатай. Санаачилгын хэрэгжилтийг сайжруулахын тулд Монгол улс нь ОУИТБС-ын дата порталын шинжилгээ, дүрслэлийг улам сайжруулан, аймаг болон сумаар нь ялган харах, Шаардлага 4.7 дээр заасны дагуу орлогын урсгал нэг бүрээр нь задлан харуулах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.
- Шаардлага 5.2 дээр заасанчлан Монгол улс нь олборлох үйлдвэрийн салбараас Засгийн газрын олж буй орлогоос орон нутагт шилжүүлж буй (аймаг, сумд) бүх төлбөрийг ил тод болгох шаардлагатай ба үүнд олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн орлогоос Орон нутгийн хөгжлийн санг санхүүжүүлэн шилжүүлж буй дүнг мөн багтаана. Мөн олборлох салбараас авч буй татвар, төлбөр бүрийг цааш хуваарилахад баримтлах томъёог (орлого хуваарилах томъёо), мөн тухайн томъёогоор тооцсон дүн болон бодитоор хуваарилсан дүнгийн хоорондын зөрүүг төрийн байгууллага, орон нутаг нэг бүрээр нь тайлагнаж байх нь зүйтэй.



- Шаардлага 6.1 дээр заасны дагуу Монгол улс нь компаниудад хуулиар үүрэг болгосон, нийгмийн чиглэлтэй заавал төлөх материаллаг зарцуулалтыг, үүнд хуульд заасан Орон нутгийн хөгжлийн гэрээний хүрээнд заагдсан эсвэл хөрөнгө оруулалттай холбоотой гэрээнд заагдсан дүнг ил тод болгож байх арга хэмжээг авах нь зүйтэй. Энэхүү төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийсэн бол санаачилгыг хэрэгжүүлж буй улс орнууд нь тухайн мөнгөн бус төлбөрийн нөхцөл, тэнцэх мөнгөн дүнгээр илэрхийлсэн хэмжээг ил тод болгож байх үүрэгтэй. Тухайн хууль эсвэл гэрээгээр үүрэг болж, төлөгдөж буй төлбөрийн хүлээн авагч нь гуравдагч тал, жишээ нь төрийн байгууллага биш бол, тухайн хүлээн авагчийн нэр болон чиг үүргийг мөн ил тод мэдээлнэ. Монголын ОУИТБС-ын бүх гурван тал тодорхой нийгэм болон байгаль орчны чиглэлийн зарцуулалт нь материаллаг хэмээн зөвшөөрвөл Ажлын хэсэг нь бусад төрлийн төлбөр, төлбөрийн ил тод тайлагналтай ижил төстэй түвшинд тухайн төлбөрийн ил тод тайлагнуулах үйл явцыг хэрэгжүүлнэ. Монголын ОУИТБС нь Шаардлага 4.9 дээр заасны дагуу энэхүү мэдээллийн чанарын асуудалд анхаарч, баталгаажуулж байхаар зөвшилцсөн байх ёстой.

## Үндэслэл

### Олборлох үйлдвэрлэлийн салбарын тойм

Олборлох үйлдвэрлэлийн салбарын тоймыг ОУИТБС-ын вэбсайтын хамаарах хэрэгжүүлэгч [улсуудын хуудас](#) дээрх Монгол улсын хэсгээс үзэх боломжтой.

### ОУИТБС-ны хэрэгжилтийн түүх

ОУИТБС-ын хэрэгжилтийн түүхийг ОУИТБС-ын вэбсайтын хамаарах хэрэгжүүлэгч [улсуудын хуудас](#) дээрх Монгол улсын хэсгээс үзэх боломжтой.

### Баталгаажуулалтын үйл явцын тайлбар

Баталгаажуулалтын үйл явцын талаарх тойм мэдээллийг ОУИТБС-ын веб хуудаснаас үзэх боломжтой.<sup>2</sup> [Баталгаажуулалтын хөтөч](#) нь ОУИТБС-ын Шаардлагуудад үнэлгээ хийх илүү дэлгэрэнгүй чиглэлийг заасан бол дэлгэрэнгүй [Баталгаажуулалтын журам](#) нь Олон улсын Ажлын албаны зүгээс баталгаажуулалт гүйцэтгэх стандарт процедурыг тусгасан.

Олон улсын Ажлын албаны дэмжих багт Гей Орденес (Gay Ordenes), Бренда Жей Ангелес Мендоза (Brenda Jay Angeles Mendoza) болон Еммануэл Бриа (Emmanuel Bria) нар ажилласан бол Баталгаажуулалтын багт Алекс Горди (Alex Gordy), Олесиа Толочко (Olesia Tolochko) болон Ида Крог (Ida Krog) нар багтсан. Чанарын баталгаажуулалтын дотоод хяналтыг Бади Балде (Bady Baldé), Франциско Парис (Francisco Paris) болон Гай Орденес (Gay Ordenes) нар гүйцэтгэсэн.

### Нууцлал

Мэдээлэл цуглуулах болон үнэлгээний дэлгэрэнгүй маягтууд нь олон нийтэд ил тод байхын зэрэгцээ Баталгаажуулалтын хорооны дотоод хуудсанд байршуулсан.

Оролцогч талуудын зүгээс ирүүлсэн санал, илэрхийлсэн үзэл бодлыг Баталгаажуулалтын тайланд тухайн оролцогч эсвэл хамаарах байгууллагыг шууд дурдалгүйгээр төлөөлж буй оролцогч талаар нь заан дурдсан. Хүсэлт гаргасан тохиолдолд тухайн оролцогч талын мэдээллийг хүндэтгэж, ирүүлсэн тайлбар, өгсөн саналыг аль оролцогч талд хамаарах болохыг нь дурдаагүй. Тайлангийн төслийг оролцогч талуудад зориулан зөвлөлдөх, хэлэлцэх зориулалтаар хүргүүлсэн ба УЗ-ийн зүгээс шийдвэр гаргах хүртэл ажлын баримт бичиг хэлбэрээр байж, нийтэд түгээгдэхгүй.

---

<sup>2</sup> <https://eiti.org/validation> хаягаар үзнэ үү.

### Баталгаажуулалтын цаг хугацаа

Монгол улсад хийгдсэн Баталгаажуулалтын ажил нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хийгдсэн. Оролцогч талуудад өөрийн мэдээлэл, саналаа ирүүлэх хүсэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлсэн. Улмаар 2022 оны 3 дугаар сарын 1-18-ны хооронд талуудтай онлайн хэлбэрээр ярилцлага хийн, мэдээлэл цуглуулсан. Баталгаажуулалтын тайлангийн төслийг 2022 оны 5-р сарын 10-ны өдөр эцэслэн гаргасан. 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Монголын ОУИТБС-ын ажлын албаны зүгээс Баталгаажуулалтын тайланд санал, тайлбар өгөх хугацааг сунгах хүсэлт ирүүлснээр тухайн хугацааг 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл сунгасан. Ажлын хэсэг буй оролцогч тал бүрийн зүгээс төсөлд саналаа ирүүлсний дараа буюу 7-р сарын 1-нд тайланг эцэслэн, УЗ-д танилцуулахаар бэлтгэн гаргасан.

## Эх сурвалжууд

- Баталгаажуулалтын мэдээлэл цуглуулсан файл – [Оролцогч талуудын оролцоо](#)
- Баталгаажуулалтын мэдээлэл цуглуулсан файл – [Ил тод байдал](#)
- Баталгаажуулалтын мэдээлэл цуглуулсан файл – [Үр дүн, үр нөлөө](#)